

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2026 оны 05 дүгээр сарын 26-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 115
1. <i>Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл /санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	9 – 80
2. <i>Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	80 – 115

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны  
05 дугаар сарын 26-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 26 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, Б.Түвшин.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ц.Мөнхтуяа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч, даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

**П.Ганзориг:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 8  
Бүгд: 20  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

***Нэг.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл /санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, мөн комиссын Хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга Х.Цэцгээ, Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Орон нутаг хариуцсан тасгийн дарга Д.Ёндонжамц, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал, мөн яамны Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Бадамцэцэг, Хамтарсан баг, үйлчилгээний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ч.Мэндбаяр, Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, магадлан итгэмжлэх хариуцсан мэргэжилтэн

Л.Баярмагнай, Хүүхдийн эрхийн улсын байцаагч М.Отгонгэрэл, Шуурхай тусламжийн үйлчилгээний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Э.Болорцэцэг, Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн А.Амартүвшин, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, Бодлого, төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн дарга Б.Түмэннаст, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Ш.Энхтуяа, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Яаралтай болон түргэн тусламж, гамшгийн үеийн тусламж, үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч М.Оюунчимэг, Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн бодлого, судалгаа, нэгдсэн төлөвлөлт хариуцсан шинжээч Ө.Энхмаа, Жендэрийн үндэсний хорооны мэргэжилтэн Д.Батхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, зөвлөх Б.Отгонсүрэн, референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, О.Саранчулуун, Ж.Чинбүрэн, Б.Бейсен, Т.Мөнхсайхан, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, Л.Мөнхбаясгалан, М.Нарантуяа-Нара, О.Батнайрамдал нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Ж.Хунан, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Яаралтай болон түргэн тусламж, гамшгийн үеийн тусламж, үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч М.Оюунчимэг, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Ш.Энхтуяа, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, мөн яамны Хүүхэд гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Бадамцэцэг, Хүүхдийн эрхийн улсын байцаагч М.Отгонгэрэл, Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, О.Саранчулуун, О.Батнайрамдал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, референт Б.Цогзолбаяр, референт Б.Энхмаа, Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, зөвлөх Б.Отгонсүрэн, референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, Ж.Галбадрах, Ж.Чинбүрэн, Д.Энхтуяа нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Л.Мөнхбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр, О.Саранчулуун, Ц.Мөнхтуяа нар үг хэлэв.

**П.Ганзориг:** Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**П.Ганзориг:** Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, С.Зулпхар, С.Эрдэнэбат, Д.Ганмаа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 80.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 58 минут үргэлжилж, 30 гишүүнээс 26 гишүүн хүрэлцэн ирж, 86.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 24 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

П.ГАНЗОРИГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр, Мягмар гараг  
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим  
10 цаг 26 минут

### ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**П.Ганзориг:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооноос ирвэл зохих 30 гишүүнээс 18 гишүүн ирж ирц бүрдсэн байна.

Ирц 60 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Буланы Бейсен, Дуламын Бум-Очир, Жанчивын Галбадрах, Амгаланбаатарын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Сархадын Зулпхар, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Дүгэрийн Рэгдэл, Отгоны Саранчулуун, Мягмардашийн Сарнай, Ганбатын Хосбаяр, Бадарчийн Хэрлэн, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Лутаагийн Энхнасан, Доржзовдын Мөнхтуяа, Сүхбаатарын Эрдэнэбат нарын 18 гишүүн өнөөдрийн Байнгын хорооны хуралдаандаа хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар гурван асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

— **Нэгдүгээрт**, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг танилцуулна.

Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

— **Хоёрдугаарт**, Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026 оны 5 сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

— **Гуравдугаарт**, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч,

даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчдийн сонсголын тайлан гээд гурван асуудал хэлэлцэх ёстой.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Ц.Мөнхтуяа гишүүн байна. Микрофоноо дарах ёстой байх. Төхөөрөмжөөрөө. Б.Бейсен гишүүнээр тасаллаа.

Ц.Мөнхтуяа гишүүн.

**Ц.Мөнхтуяа:** Өчигдрийн сонсгол ирц хүрээгүй учраас хойшилсон.

Тэгэхээр үүнийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж өгнө үү.

**П.Ганзориг:** Өчигдөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч, даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн сонсголыг явуулахаар Ц.Мөнхтуяа гишүүн сонсгол даргалагч байсан.

Тэгээд ирц хүрээгүйгээс сонсгол хуралдаагүй тул хэлэлцэх асуудлаас хасъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

А.Ариунзаяа гишүүн Ц.Мөнхтуяа гишүүний гаргасан горимын саналтай холбоотойгоор санал хэлье.

**А.Ариунзаяа:** Сонсголыг зохион байгуулах ирцийн тухай. Энэ ирцийг нь хэн бүрдүүлж байгаа вэ гэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны нийт 30 гишүүн байхгүй юу.

Тэгэхээр эсвэл сонсголын ирцэд өөрсдөө орж байгаа сонсгол зохион байгуулах ажилд бүтэн оролцох ёстой гэдгээ Байнгын хорооны гишүүд нийтдээ ойлгоогүй юм уу, эсвэл ойлгоод үл хайхарч оролцоогүй юм уу. Ирц хүрсэнгүй.

Тэгэхээр дараагийн долоо хоног руу энэ шилжих юм уу, эсвэл Байнгын хорооны ирц нэгэнтээ хүрсэн юм чинь Байнгын хорооны хуралдааныхаа араас нь сонсголынхоо ирцийг бүрдүүлээд сонсголоо зохион байгуулах хэрэгтэй.

Түүнээс биш Байнгын хорооны гишүүд нэг нэгэндээ найдаад ер нь надад нэг их хамааралгүй асуудал. Ирцээ тэгээд өөрсдөө бүрдүүлээд явна биз гэж хандаж болохгүй шүү дээ.

Хариуцлагатай байх ёстой асуудлыг яриад байхад тэгээд өөрсдөөсөө хариуцлагаа эхлэхгүй бол тэгээд хэн хариуцлагатай байх юм бэ. Эсвэл энэ Байнгын хорооны дараагаар үргэлжлүүлээд сонсголоо зохион байгуулахыг хүсэж байна. Эсвэл дараагийн долоо хоногтоо Байнгын хорооныхоо өмнө байдаг юм уу, дараа байдаг юм уу асуудлаа оруулж өгч зохицуулж өг.

Тэгээд Байнгын хорооны гишүүдээ нэг бүрчлэн дахиж мэдээллийг нь өгөх ёстой шүү.

**П.Ганзориг:** А.Ариунзаяа гишүүний хэлж байгаа санал дээр долоо хоног бүрийн Байнгын хороо, ажлын хэсэг, сонсголын тов гээд бүх хуралдааны тов дарааллыг даргын дэргэдэх зөвлөл долоо хоног болгон тогтоож байгаа.

Тэр дагуу Байнгын хорооноос үүргийнхээ дагуу хуралдаад, гишүүдийн саналыг аваад, тэгээд хуралд сонсгол даргалагч болон товыг тогтоогоод түүнийхээ дагуу сонсголууд хуралдаад явдаг. Явах учиртай.

Өчигдөр нэгд ирц хүрээгүй. Хоёрт, нэр дэвшигч нар дээр гомдолтой өргөдөл, гомдлын асуудал ирсэн. Ийм асуудлууд байгаа учраас миний хувьд Үндэсний зөвлөлийн тайланг удахгүй хэлэлцэх юм байна. Үүнтэйгээ уялдуулаад тайлан, дүгнэлтийг нь сонсож байгаад тэгээд нэр дэвшигчийнхээ асуудлыг дахиж хугацаа товлож ойрын хугацаанд хэлэлцэх нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгэхээр мэдээж горимын санал гаргаж байх шиг байна. Ц.Мөнхтуяа гишүүн нэмж санал, тайлбараа хэлэх үү?

**Ц.Мөнхтуяа:** Ерөнхийдөө би даргын саналтай зарчмын хувьд санал нэг байна. Энэ тов чинь тогтоодог дэг журамтай учраас товоо тогтоож байж явуулах байх. Дураараа өнөөдөр явуулах боломжгүй байх гэж бодож байна.

**П.Ганзориг:** Тэгэхээр товыг нь дахиж даргын дэргэдэх зөвлөлөөр оруулж хугацаа тогтоож байгаад товлону.

Тэгэхээр өнөөдрийн хувьд хэлэлцэх асуудлаас хасъя гэдэг саналын томъёоллоор гурав дахь асуудал буюу Нийгмийн даатгалын үндэсний. Гишүүд эхлээд санал хураалтдаа бэлдье.

Манайхан гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалтдаа бэлэн бус гишүүд А.Ариунзаяа гишүүн, Д.Бум-Очир гишүүн, Ж.Галбадрах гишүүн, С.Зулпхар гишүүн, П.Наранбаяр гишүүн, Д.Рэгдэл гишүүн, Г.Хосбаяр гишүүн, Л.Энхнасан гишүүн, М.Энхцэцэг гишүүн, С.Эрдэнэбат гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Бүгд бэлдсэн үү. Тийм ээ.

Ингээд Ц.Мөнхтуяа гишүүний гаргасан санал буюу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч, даатгуулагчийг төлөөлсөн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэх асуудлыг өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаас хасъя гэдэг томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад нийт 20 гишүүн оролцсоноос 12 гишүүн дэмжиж, санал 60 хувиар дэмжигдлээ. /алх цохив/

Б.Бейсен гишүүн санал хэлье.

**Б.Бейсен:** Гишүүддээ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны дарга аа, би танд нэг албан тоот хүсэлт явуулаад хорин хэд хонож байна. Эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээ клиникийн эмнэлгүүд болон дүүргийн аймгийн нэгдсэн эмнэлгийн өглөг, авлага, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтын талаар хэлэлцүүлэг зохиож өг гээд хүсэлт гаргасан.

Гэтэл эрүүл мэндийн салбар, Эрүүл мэндийн яам өр зээл байхгүй, зөвхөн эмийн өр зээл гээд яриад байх юм.

Энэ эмийн өр зээлийн цаана авч эмийн компаниудын өр гээд байх юм. Эмнэлгүүд эм, эмнэлгийн хэрэгсэлгүйгээр ажил нь явахгүй л дээ. Эмнэлгийн тусламжууд шиг цалгарч байна. Удаашралтай. Нөгөө талаар чирэгдэл ихтэй. Ард иргэд ихээр чирэгж байгаа. Энэ талын асуудлыг хэзээ ярих юм бэ?

**П.Ганзориг:** Б.Бейсен гишүүнээс мэдээлэл сонсох хүсэлт ирсэн. Энэ хүсэлтийг бид ирэх долоо хоногт Байнгын хорооны хэлэлцэх асуудлын хуваарьт оруулж байгаа.

Тэгэхээр ирэх долоо хоногт бид энэ асуудлыг Байнгын хороогоороо хэлэлцээд, холбогдох яам, сайдыг нь авчирч мэдээлэл сонсоно. Б.Бейсен гишүүн болсон уу? Тийм ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орьё.

---

**Нэг.Монгол Улс дахь хүний эрх,  
эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл**  
/санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд  
хүргүүлнэ/

---

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 25 дахь илтгэлийг хэлэлцье.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 25 дахь илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид танилцуулна.

Д.Сүнжид дарга индэр дээрээс танилцуулна. Индэрийн микрофоныг нээе.

---

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Х.Мөнхзул Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Ж.Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Т.Ихтамир Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Х.Цэцгээ хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга, С.Тунгалагтамир Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга, Д.Ёндонжамц Орон нутаг хариуцсан тасгийн дарга.

Боловсролын яамнаас Б.Бадамжав Бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Б.Баярсайхан Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хамгааллын ерөнхий газрын дарга, Л.Бадамцэцэг Хүүхэд гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Ч.Мэндбаяр Хамтарсан баг, үйлчилгээний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, Л.Баярмагнай Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, магадлан итгэмжлэх хариуцсан мэргэжилтэн, М.Отгонгэрэл Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Э.Болорцэцэг Шуурхай тусламжийн үйлчилгээний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, М.Цогтбаатар Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч, Төрийн нарийн бичгийн дарга А.Даваажаргал ирсэн байгаа юм байна. Тийм ээ.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас А.Амартүвшин Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн.

Эрүүл мэндийн яамнаас Б.Цэцэгсайхан Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Б.Янжмаа Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Б.Түмэннаст Бодлого, төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн инновац, технологи, цахим хөгжлийн хэлтсийн дарга, Ш.Энхтуяа Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч, М.Оюунчимэг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Яаралтай болон түргэн тусламж, гамшгийн үеийн тусламж, үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч, Ө.Энхмаа Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн бодлого, судалгаа, нэгдсэн төлөвлөлт хариуцсан шинжээч, Д.Батхишиг Жендэрийн үндэсний хорооны мэргэжилтэн.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулж дууслаа.

Ингээд танилцуулгаа эхлүүлэхийг хүсье.

**Д.Сүнжид:** Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 27-нд 25 дахь илтгэлийг Улсын Их Хуралд хүргүүлсэн.

Энэ илтгэлийг 6 сэдвийн хүрээнд дүн шинжилгээ хийж, саналыг томъёолсон. Үүнээс Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд–

- “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх”. **1 дүгээр бүлэг,**
- **5 дугаар бүлэг,** “Хүүхэд хамгааллын тогтолцооны зарим асуудал”,
- **6 дугаар бүлэг,** “Эрэгтэйчүүдийн эрх буюу жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” –

-сэдэвчилсэн хүрээнд энэ гурван сэдвийг нь дагнан танилцуулъя.

Нөгөө гурван сэдэв нь –

- ♦ “Шүүх шинжилгээ ба хүний эрх” гэдэг сэдэв байгаа.
- ♦ “Нийтийн мэдээллийн ил тод байдал буюу мэдээлэл авах эрхийн хэрэгжилт” гэдэг сэдэв байгаа.
- ♦ Мөн “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын хэрэгжилт” гэдэг ийм гурван сэдэв байгаа юм.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хүрээнд олон улсын гэрээ, конвенц, олон улсад баримталдаг шалгуурын дагуу 5 шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

Энэ дээр нэгдүгээрт, ер нь эрүүл мэндийн үйлчилгээ нь өөрөө–

- хүртээмжтэй,
- хүрэлцээтэй,
- чанартай,
- нийцтэй,
- санхүүгийн эрсдэлийг хамгаалсан байж чадаж байна уу –

гэдэг 5 шалгуураар үнэлсэн.

Эрүүл мэндийн тогтолцооны бүрэлдэхүүн өөрөө 6 хэсгээс бүрэлддэг гэж үздэг юм байна.

Үүн дээр нэн тэргүүн ярих асуудал бол–

- ▷ удирдлага,
  - ▷ засаглал,
  - ▷ хууль эрх зүйн орчны асуудал байгаа.
-

Тэгэхээр энэ дээр 30 орчим хууль, 200 орчим эрх зүйн акт үйлчилж байна.

Энэ хугацаанд –

- Хяналт шалгалт хэрэгжүүлэх газраас,
- Эрүүл мэндийн яамнаас,
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас,
- Хүний эрхийн Үндэсний Комиссоос,
- Стандартчилал хэмжил зүйн төвөөс гээд –

хийсэн хяналт шалгалтуудаар нийтэд нь дүгнэж үзвэл “хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил”-ийг нэгдүгээрт арилгах шаардлагатай.

Энэ нийцэл нь хийгдээгүй байна гээд 34 гэдэг тоо гаргасан байгаа. Энэ саналыг залруулаач гэдэг нэг зөвлөмж өгч байгаа юм.

Хоёр дахь нь, эрүүл мэндийн салбарын удирдлага, эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагыг томилохдоо энэ судалгаанд авагдсан хүрээнд 51 төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ёстойгоос 13 нь томилогдсон гээд.

Тэгээд төлөөлөн удирдах зөвлөлтэй холбоотой олон асуудлууд тасрахгүй улс төржсөн байдалтай. Халаа сэлгээ үргэлжилж байна гэдэг дүгнэлт гарсан учраас “удирдлагын улс төрөөс хараат бус тогтвортой ажиллуулах эрх зүйн орчин, суурь бүрдүүлэлт хэрэгтэй байна” гэдэг хоёр дахь санал, зөвлөмжийг өгсөн.

► **“Хүрэлцээтэй, хүртээмжтэй байх” тухайд.**

Бид Монгол Улсынхаа онцлогийг харгалзаад хүн амынх нь 30 орчим хувь нь суурин газраас алслагдмал газар амьдарч байна.

Тэгээд –

- › малчид,
- › хөгжлийн бэрхшээлтэй иргэд,
- › жирэмсэн эмэгтэйчүүд,
- › бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд,
- › ахмадууд гээд –

тусгай эрүүл мэндийн хэрэгцээтэй бүлгүүддээ зориулсан үйлчилгээг бид хүрэлцээтэй, хүртээмжтэй өгч чадахгүй байна гэдэг дүгнэлтийг хийж байгаа.

Хүртээмжийн тухайд зөвхөн орон нутаг төдийгүй Улаанбаатар хотын хэмжээнд ч гэсэндээ бид ер нь хүртээмжтэй орчныг –

- мэдээллийн хүртээмж,
- орчны хүртээмж.

Энэ хүртээмжүүдийг бүх талаараа 100 хувь бүрэн бүрдүүлж чадаагүй байна.

Тийм учраас тодорхой бүлгүүдэд зориулаад орчны мэдээллийн бусад хүртээмжүүдийг сайжруулах ёстой гэдэг дүгнэлтийг хийгээд саналыг нь дэвшүүлсэн.

► **“Чанар, аюулгүй байдал”-ын тухайд.**

Эмтэй холбоотой маш олон асуудал үүсэж байна. Эмийн худалдан авахаас эхлээд, эмийн хяналт, эмийн чанар, эмийн аюулгүй байдалтай холбоотой.

Энэ дээр шинэчлэл хэрэгтэй юм байна гэж дүгнэсэн. Нэг ёсондоо энэ дээр нийлүүлж байгаа үнүүд нь өөр байдаг юм байна. Худалдан авах энэ байдал дээр бид заавал эрүүл мэндийн байгууллагыг оролцуулж, тогтолцоо өөрөө хэр өгөөжтэй юм бэ.

Нэг талаасаа иргэд чанарын л асуудал ярьж байгаа. Бид чанартай эмийг хэрэглэмээр байна, тоног төхөөрөмжөө хангуулмаар байна гэдэг асуудал ярьдаг бол эмнэлгийн байгууллагуудын удирдлагуудтай удаа дараа хийсэн уулзалтаар давтан хэлдэг нэг зүйл нь бид энэ худалдан авалтад оролцох сонирхол байдаггүй. Орсноороо тодорхой байгууллагуудад байнгын хяналт шалгалт буюу гомдол, маргаан үргэлжилсэн байдалтайгаар үйл ажиллагаа, өөрийнхөө чиг үүргийг хэрэгжүүлж чадахгүйд хүрдэг гэдэг асуудлыг ярьж байгаа учраас бид энэ –

- › эмийн худалдан авалт,
- › эмийн чанар,
- › эмийн хяналт –

гэдэг дээр тусгай анхаарал хандуулаад, одоо явж ирсэн тогтолцоогоо зохих ёсоор өөрчлөх ёстой байна гэдэг дүгнэлтийг хийсэн.

► **“Санхүүгийн хамгаалалт”-ын тухайд.**

Хамгийн сүүлд 2020 оноос хэрэгжиж байгаа даатгалын тогтолцоог ер нь зөв байна гэж үзсэн. Ахиц дэвшил гарчээ гэж үзсэн. Гэхдээ энэ дээр харахад бид нэг өрхөөс гарч байгаа зардал, хувь хүнээс гарч байгаа зардал ихэссэн байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөхөөс бид нэг дахин ихэссэн гэдэг дүнтэй. Тэгээд хэрэвзээ хавдар аль нэг өрхийн гишүүнд тусах юм бол тэр өрхийн санхүүжилтэд шууд нөлөөлдөг. Ядууралд хүргэх эрсдэл болж байна гэдэг дүгнэлтийг хийсэн учраас санхүүгийн хамгаалалтыг даатгалын тогтолцоотойгоо уялдуулаад шинэчлэх ёстой байна.

Хоёрдугаарт нь, өглөг, авлагын асуудал байнгын үргэлжилсэн шинжтэй.

Хөдөө орон нутгаар бид 74 байгууллагуудад сумын өрхийн эрүүл мэндийн төв, нийслэлийн хэмжээнд ч гэсэн төрөлжсөн гурван шатны түвшинд нь хяналт шалгалт хийсэн. Тэр түвшинд өглөггүй, авлагагүй тийм эрүүл мэндийн байгууллага тун ховор байна.

Төрөлжсөн эмнэлгүүдийн тухайд л өглөг, авлага ярихгүй байж чадаж байна. Бусад хоёр түвшиндээ байнгын өглөг, авлага үүсгэсэн. Тэрийгээ зарим нь аймгийн хэмжээнд, сумын хэмжээнд өөрсдийнхөө эмч, эрүүл мэндийн ажилтнуудын цалинг тавьж чадахгүй хэмжээнд хүртэл хүрсэн нөхцөл байдалтай байна. Зарчмаа яриад байж байгаа. Энэ дээр дүгнэлт хийх шаардлагатай гэж үзсэн. Гадаадад эмчлүүлэгдэж байгаа асуудал дээр бас санхүүгийн даатгалын тогтолцооны хувьд өөрчлөх ёстой байна гэдэг дүгнэлтийг хийсэн.

Ингээд энэ 5 шалгуураар авч үзээд.

Түүнээс гадна эмч, эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн аятай таатай орчин гэдэг дээр нэг дэд сэдвийг авч үзсэн. Энэ чиглэлээр хамгийн их ярьж байгаа асуудал цалин хөлсний асуудал байгаа.

Мөн түүнчлэн тогтвортой ажиллах байдал алдагдсан юм байна.

Ялангуяа залуу боловсон хүчин, хүний нөөцөд хэрвээ ийм цалингаар, нэмэх нь ийм нөхцөлөөр. Тэгээд хоёр хүн тутмын нэг нь өөрсдийнхөө албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй илүү ажил хавсран гүйцэтгэдэг гэж байгаа юм.

Тэгээд ийм нөхцөлөөр явах юм бол энэ салбарт ажиллах хүсэл эрмэлзэлгүй. Гарахад бэлэн гэдгээ илэрхийлсэн гарч байгаа юм байна.

Тэгээд сувилагч байнгын дутагдалтай. Нөхөн хангалт хийх бодлого хангалтгүй гэдэг дүгнэлт гарч байгаа.

Ажлаас халшрах хам шинж илүү байдаг. Үйлчлүүлэгчээс ирж байгаа дарамт, нэр төр гутаах гээд тун олон асуудал үүсдэг юм байна.

Тэгэхээр бид үүнтэй холбоотой хүний нөөцийнхөө асуудлыг дүгнээд энэ дээр тодорхой санал дэвшүүлсэн.

---

Ингээд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хүрээнд нийтдээ 18 саналыг Улсын Их Хурлын тогтоолд оруулъя гэж Хүний эрхийн Үндэсний Комиссоос санал болгосон.

Хоёр дахь сэдвийн хүрээнд “Хүүхдийн хүүхдийн эрхийн зарим асуудал” байгаа.

Энэ хүрээнд хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд орон нутгийн хэмжээнд, Засгийн газрын хэмжээнд гээд нийтдээ маш олон төрөлжсөн салбар байгууллагууд байгаа.

Тэгээд нийтдээ 10 байгууллагын хэмжээнд бид авч үзээд уялдаа холбоо ямар байгаа юм бэ гээд нийтдэ 2105 нэгжийн хүрээнд үйл ажиллагааг нь дүгнэсэн.

Энэ дээр Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, орон нутгийн зөвлөл, анхан шатын хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа хамтарсан багийн үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхдийн эрхийг хамгаалах –

- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо,
- Хүүхдийн шуурхай тусламж, хамгааллын төв,
- түр хамгаалах бай байр,
- нэг цэгийн үйлчилгээний төв,
- нийгмийн ажилтнууд,
- шинжээч нар,
- хууль ёсны төлөөлөгч,
- ахлах байцаагч,
- байцаагчид гээд –

хүмүүсийн хувьд үйл ажиллагаа ямар байгаа вэ гэдгийг дүгнэсэн юм.

Тэгэхээр нэгдүгээрт бид хуулиараа заасан зарим дүрэм, журмаа батлахгүй хэвээрээ л байгаа юм.

Тэгээд 9 дүрэм, журам энэ илтгэлийг өргөн барьж байх үед батлагдаагүй байна гээд. Энэ нэг асуудал байна.

Хоёр дахь асуудал бол санхүүжилттэй холбоотой.

Хүүхдийн төлөө, хүүхдийн эрхийг хангана гэж хэлээд мэдээж хангалтгүй.

- Хэн,
- хэзээ,

- ➔ хаанаас,
- ➔ ямар нөөцөөр,
- ➔ хэрхэн гэдэг –

үе шат, процедур заагаагүй цагт бид хүний эрхийг хэрэгжүүлж чаддаггүй.

Хүүхдийн эрх дээр энэ тод илэрч байна. Санхүүжилт, төсвийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай хэвээрээ.

Гурав дахь нь, мэдээллийн сан нэгдмэл биш.

Бид мэдээлэл авахаар–

- хамтарсан баг нь нэг мэдээлэл өгдөг,
- цагдаа нь өөр мэдээлэл өгдөг,
- прокурор өөр мэдээлэл гээд дандаа зөрүүтэй явдаг.

Нэг мэдээлэл бидэнд байдаггүй.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, ял ялангуяа хүнд, тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгаа хэдэн хүүхэд байгаа юм бэ гэхээр өөр өөр тоонуудтай бид бүгд сууж байгаа.

- ▶ Статистикийн хороо нэг өөр тоо хэлнэ.
- ▶ Хүүхэд хөгжлийн газар нь нэг өөр тоо хэлнэ.
- ▶ Агентлаг гээд нэг өөр тоо хэлнэ.

Нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээд бид араас нь –

- үүнийгээ хянах,
- эрсдэлийг нь тооцох,
- урьдчилан сэргийлэх,
- таслан зогсоох үйл ажиллагааг –

үр дүнтэй хэрэгжүүлж чадах учраас мэдээллийн сангийн асуудлыг тусгасан.

Дөрөвт нь, хамгийн чухал асуудал бол уялдаа холбоо байна.

Засгийн газрын харьяа орон нутгийн хэмжээнд Засаг дарга, эсвэл Засаг даргын орлогч нь ахалж байгаа юм.

Тэгээд хамтарсан баг гээд. Тэгээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлаг байгаа юм. Энэ чиг үүргүүд хоорондоо уялдаа холбоо муу, сул, хангалтгүй гэж дүгнэсэн.

Тэгээд үүнтэй холбоотой 11 саналыг хүүхэд дээр дэвшүүлсэн.

Хамгийн сүүлийнх нь “Эрэгтэйчүүдийн эрхийн асуудал” байгаа.

Тэгэхээр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт нь 2 жил тутамдаа Хүний эрхийн Үндэсний Комисс дүгнэлт хийдэг.

Энэ хүртэл 25 жилийн хугацаандаа илүү эмэгтэйчүүдийн төрөлжсөн сэдэв дээр бид илтгэж байжээ.

Эрэгтэйчүүдийн эрхийн асуудал дээр гурван асуудал байгаа.

Насжилт, дундаж наслалтын зөрүү. Энэ зөрүү нь ер нь эрүүл мэндийн явцдаа гарч байгаа зөрүү л юм байна л даа.

- Эрүүл мэндийн үйлчилгээ авах байдал,
- Сэтгэцийн эрүүл мэнд,
- Амиа хорлолт давхар орж ирдэг.

**П.Ганзориг:** Нэмэлтээр. Тэгье. 3 минут нэмээд өгье. 3 минутдаа багтаагаад дуусгачих. Тэгээд асуулт хариултын явцад нэмэлт мэдээллээ Та өгөөд явчхаж болно. Гишүүд зөндөө асуулт саналууд явах байх. 3 минут нэмж өгье. Индэр дээр.

**Д.Сүнжид:** Тэгээд эрчүүдийн эхний асуудал нь эрүүл мэндийн асуудал.

Ер нь дүгнэлт дээр тоо харахаар урьдчилан сэргийлэх үзлэгт үзүүлсэн байдал нь их хангалтгүй юм билээ. Дандаа хүндэрсэн тохиолдол үзүүлдэг гэдэг нэг дүгнэлт байгаа.

Хоёрт, сэтгэл зүйн эрүүл мэнд. Нөгөө хамаарал бүхий байдал, адиплог гээд тэр чиглэлээрээ тусламж, үйлчилгээ авч чадахгүй байна. Амиа хорлолтын түвшин өндөр байна.

Тэгээд эрэгтэйчүүдийнхээ эрүүл мэндийг анхаарах ёстой гэдэг нэг асуудал.

Хоёр дахь нь, боловсрол байна.

Үүнийг бид өмнөх хоёр жилийн өмнө ч гэсэн илтгэж л байсан. Тэгээд түүний мөрөөр Засгийн газраас яг эрэгтэйчүүдийн гэдэг боловсролын хоцрогдлыг арилгах ямар нэгэн дорвитой төлөвлөгөө гаргаагүй, үйл ажиллагаа хийгээгүй.

Энэ дээр сургууль завсардаж байгаа хүүхдүүд нь эрэгтэй байдаг.

---

Тэгээд энэ дээр боловсролын түвшингийн ялгаа анх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуульд нэгдүгээр ангид орохдоо нэг нэгийн харьцаатай эхэлдэг боловч дээд боловсрол дээр очихоор энэ зөрүү чинь шууд 30 хувь болоод явдаг.

Тэгээд энэ бүх гэр бүл зүй, хүний нөөц, тэр бүх л зүйлд нь нөлөөлөөд явдаг.

Тэгэхээр боловсролынхоо хоцрогдлыг арилгах гэдэг тусгай хөтөлбөр байдаг юм уу, ийм үйл ажиллагаа зайлшгүй хэрэгтэй.

Энэ сая бид мэдэж байгаа биш. Гэхдээ үйл ажиллагаа хийхгүй байна. Тодорхой чиглэсэн, зорилготой үйл ажиллагаа хийхгүй байна.

Гурав дахь нь, зорилтот бүлгийн эрэгтэйчүүдийн асуудлыг бид ярих ёстой. Энэ дээр малчид орж ирж байгаа. Ажил, мэргэжил эзэмшээгүй залуучууд орж ирж байгаа юм. Эд нартаа зориулсан тодорхой үйл ажиллагаа хийхгүй бол хүн ам зүйн бүтэц чинь өөрөө хот хөдөөгөөрөө, эзэмшсэн мэргэжлээрээ ялгаатай.

Түүнээс улбаалаад цаашдаа нийгмийн харилцаанд оролцох оролцоо, идэвх, байр суурь гэдэг нь тодорхойлогдох үр дагавартай болоод байна.

Амь насандаа эрсдэж байгаа. Өвчнөөс биш, өвчний бус шалтгаанаар амь нас эрсэдэж байгаа байдал аваад үзэхээр хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг эрэгтэйчүүдийн хувьд тулгамдсан асуудал гарч ирж байгаа. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг заавал сахиулах ёстой тийм салбарт ажил хийдэг хүмүүс нь илүү голдуу залуучууд.

Тэгээд тэд нарын тэр хөдөлмөрийн аюулгүй байдлын улмаас, хангагдаагүйн улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирч байгаа байдал, тэр тоо маш өндөр байгаа.

Тэгээд ийм ийм асуудлууд дээр эрэгтэйчүүд дээр гурван чиглэл дээр нь анхаарах ёстой байна гэдэг юу байсан.

Дөрөв дэх нь, хэвшмэл ойлголтыг дурдъя. Яах вэ, эмэгтэйчүүд дээр бид ярьдаг шүү дээ. Хэвшмэл ойлголтыг. Эрэгтэйчүүд дээр мөн адилхан үүнийг анхнаас нь ярихгүй бол.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай бид мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажил хийхдээ ер нь хүн хүнийг хүндэтгэх чухал гэдэг агуулгаар хийхгүй бол олон жил нэг талыг барьсны улмаас ялгаатай. Энэ дээр зарим өрөөсгөл ойлголтууд гарч ирдэг хэвээрээ. Нийгмээс ч гэсэндээ тийм хүлээлт байдаг хэвээрээ юм билээ.

Тэгэхээр нь stereotype. Эр, эм хүйс дээрээ адилхан. Аль аль хэвшмэл ойлголтыг нь эвдэх ёстой байна гээд дүгнэлтийг хийж байгаа.

Эцэст нь 7 саналыг дэвшүүлсэн. Ялангуяа тэр амиа хорлож байгаа байдал, амь нас, эрүүл мэнд эрсдэж байгаа байдал дээр яаралтай даруй арга хэмжээ авах ёстой байна гэдэг.

**П.Ганзориг:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Т.Мөнхсайхан гишүүнээр тасаллаа.

С.Эрдэнэбат гишүүний нэрийг оруулаарай. Ж.Галбадрах гишүүний нэрийг оруулаарай. Ж.Галбадрах гишүүнээр тасаллаа. С.Эрдэнэбат гишүүний нэрийг оруулаарай. Ингээд 8 гишүүнээр тасаллаа.

А.Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

**А.Ариунзаяа:** Гуравхан минутад ийм том илтгэлийг асууж, ярина ч гэдэг бол бас их хүнд даалгавар.

Энэ жилийн илтгэл дээр би жоохон сэтгэл хангалуун бус байна.

Өнгөрсөн жилийнх сайн байсан юм. Өнгөрсөн жил маш их асуудлыг үнэхээр сайн дэвшүүлсэн. Асуудлуудыг гаргасан. Энэ жилийнх их л мөлгөр.

Тэгээд дээрээс нь Хүний эрхийн комисс төрийн албан хаагчдын цалин хөлсний асуудлыг ярихаа болиоч ээ.

Одоо Улсын Их Хурлын гишүүд ч тэр, Хүний эрхийн комисс төрийн албан хаагчдын салбараар нь түүж цалин хөлсийг нь ярьдаг болтлоо бид цалин хөлсийг бүр. Цалин хөлсний нэгдсэн бодлого алдагдлаа шүү дээ.

Уг нь төрөөс үзүүлж байгаа үйлчилгээ тэр тухайн хүн, иргэний ямар эрхийг нь зөрчөөд байгаа юм бэ гэдгийг бид илүүтэй ярих ёстой шүү дээ.

Эрүүл мэндийн салбар. Жишээлбэл, миний уг нь хөндөх ёстой асуудал нь юу юм бэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт нь нэг үйлчилгээ билүү, нэг багцаараа, нэг иргэн үйлчилгээгээрээ цалин хөлсний урсгал зардал, бүх юм нь багтсан яваад байгаа байхгүй юу.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүд цалин хөлсийг нь нэмнэ гэж баахан попорч нэмж байна гэж ярьчаад улсын төсвөөс нэг ч мөнгө тавиагүй. Энэ шимтгэл төлөгчийн нуруун дээр тавигдаж байгаа зардал. Тэгээд зардлыг нь нэмэгдүүлэхгүй байж, төсвийг нь нэмэгдүүлэхгүй байж цалин хөлсний зардлыг нь Улсын Их Хурлын гишүүд дураараа нэмээд, тэгээд эцэстээ юу болж байна вэ гэхээр иргэн эрүүл мэндийнхээ үйлчилгээгээ авч чадахгүй байгаа байхгүй юу.

Яагаад улсын эмнэлэг, хувийн эмнэлэг адилхан төлбөр авч байгаа юм. Төрийн эмнэлэг яах вэ ойлгож байна. Төр тэр хүмүүсийн цалинг нь даах ёстой юм байна. Улсын эмнэлгүүдээ бид тэгээд хувийн эмнэлгүүдтэйгээ адилхан авч үзэх юм уу. Хувийн эмнэлэг чинь өөрөө тусдаа дахиад иргэдээс үйлчилгээ авч байгаа шүү дээ.

Гэх мэтчилэн иргэний эмчлүүлэх эрх нь хөндөгдөж байгаа байхгүй юу. Үүнийг огт ярьсангүй.

Төрийн албан хаагчдын цомхотгол гээд л өнгөрсөн жил өөрсдөө дураараа ярьцгаасан. Эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгааллын салбарыг битгий хамруулаарай гэж манай Байнгын хорооны гишүүд эмэгтэйчүүд зөндөө л ярьсан шүү дээ.

Тэгэхэд яасан. Хүүхэд хамгааллын салбараас маш олон хүнийг цомхотгосон байгаа байхгүй юу. Энэ илтгэл дээр 108 дуудлагын төвөөс 5 хүнийг хассан байна шүү дээ. Энэ хариуцлагыг хэн хүлээх юм? Б.Баярсайхан дарга, агентлагийн дарга 32 эмэгтэй гишүүнтэй болсон хүүхэд хамгааллын зардлыг бууруулсан гээд биднийг буруутгаж байгаа шүү дээ.

Юу гэсэн үг юм бэ. Ингэж болдог юм уу? Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл яг одоо 11.00 цагаас бас нөгөө танхимд хуралдаж байна. Энэ асуудлууд... /минут дуусав/

**П.Ганзориг:** А.Ариунзаяа гишүүнд нэмэлт минут өгье.

**А.Ариунзаяа:** Тэгээд зүгээр л юм л бол хойд талын хар овоохой гэдэг шиг Засгийн газар өөрийнхөө ажлаа зохистой хийхгүй, тэгээд цомхотгол гэхээрээ хаана хамаагүй автоматаар зүгээр бусад салбаруудынхаа ачааллыг нь ч хардаггүй, ач холбогдлыг нь ч хардаггүй. Зүгээр цомхотгоод байж болдог юм уу?

Тэгээд эцэст нь Улсын Их Хурлын гишүүд буруутай гээд. Тэгээд хариуцлага ярья гэхээр нөгөө Ерөнхий сайд нь ч байхгүй. Өөр шинэ Ерөнхий сайдтай. Шинэ кабинет.

Тэгсэн ч гэсэн асуудалд нэг Засаг бол нэг Засаг. Үүнийгээ анхаарах ёстой. Одоо энэ олон хүмүүсийг цомхотгоод дахиад өөр шинэ орон тоонуудыг бий болгосон байх юм бол энэ дээр хариуцлага тооцох ёстой шүү.

Надад нэг асуулт байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд 46 цэрэг амиа алдлаа. 200 орчим цэрэг эрүүл мэндээрээ хохирлоо гэж байна.

Морины уралдаанаас болж сүүлийн 10 жилийн хугацаанд хэдэн хүүхэд амь насаа алдсан? Хэдэн хүүхэд бэртсэн бэ? Энэ тоон мэдээллийг надад өгөөч. 10 жилээр нь.

**П.Ганзориг:** Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид дарга хариулъя. Ж.Хунан хариулах юм уу? Индэр дээрээс Ж.Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн.

**Ж.Хунан:** А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Хүүхэд хамгааллын салбарт цомхотгол хийж байгаа асуудалтай санал нэг байна.

Энэ дээр холбогдох албан тушаалтнууд нь тогтмол өөрчлөгддөг. Хариуцлага хүлээх хүн байхгүй. Төсөв, орон тоо хасагдаж байгаа нь хүүхэд хамгаалалд шууд нөлөөлж байгаа асуудал мөн.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийтдээ 46 хүүхэд амь насаа алдсан байгаа. Мориноос унаж. Он гарснаар одоогийн байдлаар Хүний эрхийн Үндэсний Комисст мэдэгдсэнээр 2 хүүхэд мориноос унаж амь насаа алдсан харамсалтай хэрэг бүртгэгдсэн байгаа. Нарийн мэдээллийг Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс өгөх байх.

Мөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас энэ тоо гарах боломжтой.

Дээрээс нь Шүүхийн шинжилгээний ерөнхий газраас энэ тоо дэлгэрэнгүй цогц байдлаар гарах боломжтой байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комисст мэдэгдэж байгаа тоог би танд сая хэллээ.

**П.Ганзориг:** А.Ариунзаяа гишүүн тодруулъя.

Тэгээд цэрэг гээд бусад статистикууд асууж байгаа юм байна. Бүгдийг нь бүрэн хариулна шүү. А.Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

**А.Ариунзаяа:** Би энэ асуултаар юу гэж асуугаад байгаа вэ гэхээр ер нь зүгээр дан ганц нэг тохиолдол гарахаар нийгмээрээ шуугидаг биш. Энэ асуудалд бүх нийтээрээ анхаарах ёстой юм. Энэ нь байж болно, тэр нь байж болохгүй гэсэн асуудал огт биш.

Цэрэг ч гэсэн дөнгөж хүүхэд наснаасаа гарч байгаа. Дөнгөж л тэр бас л нялх хүүхэд шүү дээ. Дөнгөж 18 настай, 19 настай. Бүхий л энэ асуудлууд чухал.

Тэгээд би өнгөрсөн жил 24 дүгээр илтгэлийг сонсоод тэгээд уг нь ямар хүсэлт гаргасан бэ гэхээр “хүүхдийн амьд явах эрх ямар байгаа” талаар дараагийн жилийнхээ илтгэлдээ авч үзээч гэж хүссэн байхгүй юу даа. Энэ чинь зөвхөн цэрэг, зөвхөн морины хүүхэд биш.

Морины хүүхдийг бид зөвхөн тэр өвлийн болон хаврын асуудлыг л ярьж байгаа. 5 сарын 01-нээс 10 сарын 01-ийг хүртэл нээлттэй. Энэ өв соёлыг ерөөсөө үгүйсгээгүй. Зам тээврийн осол. Зодуулж өгч байгаа хүүхэд. Энэ бүх... /минут дуусав/

**П.Ганзориг:** Л.Мөнхбаясгалан гишүүнийг асуулт асуух дараалалд оруулъя. Индрээс хариулъя. Ажлын хэсэг.

**Ж.Хунан:** Монгол Улсын хүүхэд хамгааллын статистик үзүүлэлтүүд гээд Статистикийн ерөнхий газраас гаргадаг байгаа.

Тэгээд 2024 он хүртэл мэдээлэл нь нэгтгэгдсэн байна. Харамсалтай нь 2025 оныхыг нэгтгэж амжаагүй байгаа юм байна лээ.

Тэгээд 2024 оны байдлаар саяын асуусан статистик мэдээллийг танд танилцуулъя.

Гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд 2024 оны байдлаар 111 байгаа.

Өөрөөр хэлбэл энэ тоо 2021 оноос хойш тогтмол өсөж байгаа тоо байгаа.

- ◆ 2021 онд 83 хүүхэд гэмт хэргийн улмаас нас барсан.
- ◆ 2022 онд 92 хүүхэд.
- ◆ 2023 онд 99 хүүхэд.
- ◆ 2024 онд 111 хүүхэд гэмт хэргийн улмаас нас барсан гэдэг тоо байгаа.

Энэ бол тогтмол өсөж байгаа тоо.

Тэгэхээр үүнийг бид анхаарах ёстой.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүүхдийн тоог би Та бүхэнд танилцуулъя.

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье. Индэр дээр.

**Ж.Хунан:** 2021 онд 550 хүүхэд,

- 2022 онд 852 хүүхэд,
  - 2023 онд 886 хүүхэд,
  - 2024 онд 997 хүүхэд.
-

Энэ тоо мөн ялгаа байхгүй тогтмол өсөж байгаа үзүүлэлттэй байгаа.

Хурдан морь унадаг хүүхэдтэй холбоотой асуудал яригдсан учраас хурдан морь унадаг уралдаанч хүүхдийн тоо мөн жилээс жилд тогтмол нэмэгдэж байгаа тоо байгаа.

2021 онд 1918 хүүхэд байсан. Энэ бол ковид болон бусад хязгаарлалттай холбоотой бага байсан байгаа.

- › 2022 онд 7596 хүүхэд,
- › 2023 онд 11207 хүүхэд... /минут дуусав/

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье. Индэр дээр мэдээлэл чухал мэдээллүүд танилцуулж байна.

**Ж.Хунан:** Ийм тоо байна.

Зам тээврийн ослын улмаас хохирогч болсон хүүхэдтэй холбоотой мэдээллийг Та бүхэнд хүргэе.

Зам тээврийн ослын улмаас хохирогч болсон хүүхэд –

- › 2021 онд 155 хүүхэд байсан бол,
- › 2024 онд 290 болж нэмэгдсэн байгаа.

Энэ тоо мөн ялгаа байхгүй тогтмол нэмэгдэж байгаа тоо.

Тэгэхээр энэ дээр бид дүгнэлт хийх ёстой.

Зам тээврийн ослын улмаас нас барсан хүүхэд ер нь тогтмол 50 гэсэн үзүүлэлтийг харуулж байгаа.

- › 2021 онд 51 хүүхэд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан бол
- › 2022 онд 54 хүүхэд,
- › 2023 онд 51 хүүхэд,
- › 2024 онд 51 хүүхэд зам тээврийн ослын улмаас амиа алдсан.

Ийм харамсалтай статистик мэдээ байгаа.

**П.Ганзориг:** Индэр индэр дээр минут нэмж өгье.

**Ж.Хунан:** Амиа хорлолтын мэдээг Та бүхэнд танилцуулъя.

- › 2021 онд нийт 62 хүүхэд амиа хорлосон бол
  - › 2022 онд 54,
-

- 2023 онд 46,
- 2024 онд энэ тоо эргээд 62 болсон үзүүлэлттэй байна.

**П.Ганзориг:** О.Саранчулуун гишүүн асуулт асууя.

**О.Саранчулуун:** Сайн байцгаана уу? Би тайлангийн форматтай холбоотой хэдэн зүйл тодруулах гэсэн юм. Комиссын гишүүний зөвлөмжийн хариу ирүүлээгүй байгууллага, албан тушаалтан гээд хүснэгт дээр жендэрийн асуудлаар болон хүний эрхийн асуудлаар Боловсролын сайд их дээд сургуулиуд руу санал явуулсан гэж байгаа юм.

Тэгээд хариу ирүүлсэн гэдэг мэдээллүүд байгаа байхгүй юу. 8 байгууллагаас 4 нь хариу ирүүлсэн. 4 нь ирүүлээгүй. Боловсролын яамны 8-аас 4 нь ирүүлсэн, ирүүлээгүй.

Тэгэхээр энэ хариу ирүүлсэн гэдгийн цаана яг юу байгаа юм бэ? Бид энэ жендэрийн асуудал, хүний эрхийн асуудлыг хичээлийн хөтөлбөртөө оруулсан гээд байгаа юм уу, оруулаагүй гээд байгаа юм уу, оруулах боломжгүй гэдэг юм уу. Энэ хүснэгт 4, 5 дээр байгаа тайлангуудыг харахаар ерөөсөө тийм юм байхгүй.

Хугацаа хэтрүүлсэн гэдэг дээр хугацаа хэтрүүлээд тэгээд юу гэсэн юм бол гэдэг мэдээлэл авч чадахгүй байна л даа. Тийм болохоор тодруулахыг хүсэж байгаа.

Дараагийнх дээр нь ер нь Хүний эрхийн комиссын комиссоос жишээлбэл шаардлага, зөвлөмжүүдийг гаргадаг байна л даа.

Гаргаад хяналт шалгалтын хүрээнд –

- гомдлын мөрөөр,
- мэдээллийн мөрөөр,
- дүн шинжилгээний мөрөөр –

шаардлага, зөвлөмж хүргүүлдэг гэж байгаа юм. Гэхдээ тэр шаардлага, зөвлөмжийнх нь дагуу хэд нь яг хэрэгжиж ажил хэрэг болсон юм бэ гэдэг мэдээлэл нь энэ тайлангаас би олж харахгүй байгаа учраас дэлгэрэнгүй тайлбарыг авах хүсэлтэй байна.

Гуравдугаарт нь, Д.Сүнжид дарга түрүүн илтгэлдээ хүртээмжийн асуудлыг нэлээн анхаарч хүртээмж дээр нэлээн зөвлөмжүүд өгсөн гэж байгаа юм. Би Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улсын Их Хурлаар шийдвэр гаргуулахаар өгч буй санал дотор хүртээмжтэй холбоотой, тухайлсан зүйл, заалт тодруулж харсангүй.

Тэгэхээр үүнийг яг аль хэсэгт нь тэр хүртээмжтэй холбоотой асуудлыг дурдсан бэ гэдгийг тодруулъя.

Дараа нь гэрээлэн гүйцэтгэх ч юм уу, гүйцэтгэх ажил хийж байгаад үйлдвэрлэлийн осолд өртсөн хүмүүсийн дараах асуудал яадаг вэ? Тэд нарын мэдээлэл аягүй дутагдалтай.

Яагаад гэвэл эрчүүдийн эрүүл мэндийн бүлэг дээр осол, гэмтэл нэлээн их байгаа. Тэгэхдээ ямар шалтгаанаар осол гэдэг нь задраагүй байгаа.

Тэгэхээр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалаас эргэж төлбөр авах эрх үүсээгүй мөртлөө осол, гэмтэл орсон хүмүүсийн эрхийн асуудал хаана байгаа вэ, юу болж байгаа вэ гэдгийг тодруулах хүсэлтэй байна.

Дараа нь амиа хорлолтын асуудал эрчүүд дээр нэлээн өндөр байна.

Ер нь эрчүүдийн бүлгийг харахаар эмэгтэйчүүдээс угаасаа дандаа хоёр дахин, гурав дахин пунктээр өндөр байгаад байгаа.

Тэгэхээр амиа хорлолтын дараах шалтгаанууд дээр ер нь дүн шинжилгээ хийсэн тайлан манайд байна уу? Яагаад амиа хорлодог вэ? Тэр шалтгааныг нь бууруулахад Засгийн газраас өнөөдрийг хүртэл ямар ажил хийж байгаа талаар мэдээлэл тодруулах хүсэлтэй байна. Тэгээд дараа нь тодруулъя.

**П.Ганзориг:** Эхлээд Д.Сүнжид дарга хариулах уу? Тэгээд нэмэлтээр бусад хүмүүс хариулт өгөхөөр бэлдэж байгаарай. Индрийн микрофон.

**Д.Сүнжид:** О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Зөвлөмж, шаардлага 2025 оны байдлаар 101 зөвлөмж, шаардлага явуулсан. Үүнээс хэрэгжээгүй нэг байгаа. Бусад нь хугацаа хэтрүүлээд ирүүлсэн. Ирүүлэхдээ биелэлтээ ирүүлсэн гэсэн үг. Хугацаа хэтрүүлсэн гэдэг дээр нь л тайлбар бичиж байгаа. Биелүүлсэн гэдгээ ирүүлж байгаа.

Нэг ирүүлээгүй нь Увс аймгийн Иргэний нисэхийн үндэсний төвийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой ажлын хариуцлага тооцох гэдэг тэр зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй, биелүүлээгүй нэг асуудал байгаа. 2025 онд.

Эрүүл мэндийн хүртээмжтэй холбоотой манай Хүний эрхийн Үндэсний Комиссын 25 дахь илтгэлийн 589 дэх талд бид 11-д нь оруулсан юм.

Эрүүл мэндийн байгууллагын –

- орчны хүртээмж,
- үйлчилгээний хүртээмж,

► мэдээллийн хүртээмжийг сайжруулаач ээ гээд гургууланг нь томъёолсон.

Харин Хууль зүйн байнгын хорооноос томъёолсон Их Хурлын тогтоолын төсөлд харин тэр утгаараа ороогүй байна.

Тэгэхээр үүнийг манай Их Хурлын гишүүдээс санаачилж оруулах боломжтой.

Эрчүүдийн эрүүл мэндийн асуудлаар Х.Мөнхзул гишүүн тайлбар өгье.

**П.Ганзориг:** Индрийн микрофон дээр нэмэлт хариулт өгье.

**Х.Мөнхзул:** Бүгдээрээ сайн байцгаана уу?

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хувьд анхаарал татаж байгаа асуудал нь яах аргагүй амиа хорлолтын асуудал.

Амиа хорлолт эрэгтэйчүүдийн нас баралтын шалтгааны гурав дахь шалтгаан болоод байгаа хэдий ч өнөөг хүртэл амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө Монгол Улсад байхгүй байна.

Тэгээд ялангуяа амиа хорлолтын асуудлыг судалсан судалгаа байгаа. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс бидэнд ирүүлсэн мэдээллээс харахад шалтгаан нь эдийн засгийн асуудал.

Ялангуяа ажилгүйдэл, өр зээлээс болдог, нийгмийн орчинтой холбоотой.

Сүүлийн үед цахим орчны дарамт, хүчирхийлэл, дээрхэлтийн асуудал, нэр төрд халддаг асуудал, гэр бүлийн нөхцөл байдлын асуудал, гэр бүлийн орчин дахь хүчирхийлэл, гэр бүлийн таагүй харилцаа, сэтгэцийн бусад асуудлаас гэсэн амиа хорлолтын шалтгааныг илрүүлсэн байгаа.

Тэгээд ялангуяа энэ амиа хорлолтын асуудлаар 35-аас 44 насны эрэгтэйчүүдийн дунд хамгийн өндөр байгаад байгаа. Тэгээд хүүхдийн дунд амиа хорлох эрсдэл 10 хүртэлх наснаас нь эхэлж байгаа нь бидний ирээдүйд дохио өгч байна гэж харж байна. Гэвч сэтгэцийн эрүүл мэнд болон ер нь бүх төрлийн эрэгтэйчүүдэд амиа хорлоход хүргэж байгаа асуудлууд, донтох эмгэгийн тусламж, үйлчилгээ Монгол Улсад хангалтгүй. Энэ чиглэлээр нийт эмч нарын нэг хувьд ч хүрэхгүй байна. Тэгэхээр –

- “амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг яаралтай батлах,
- сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, донтох эмгэгийг даван туулагчдыг сэргээн засах, тусламж, үйлчилгээний зөвлөгчөөр нь бэлтгэж ажиллуулах,

— аймаг, сумдад нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай байна” гэж дүгнэсэн байгаа. Баярлалаа.

**П.Ганзориг:** О.Саранчулуун гишүүн тодруулъя.

**О.Саранчулуун:** Аль хүмүүс нь хариулах юм бол. Сайн мэдэхгүй байна. Ямар ч байсан осол, гэмтэлд орсон байгаа хүмүүс дээр дараагийн асуудал нь яаж байгаа вэ гэдгийг асуух гээд байгаа байхгүй юу.

Цочмог, цочмогдуу үеийн сэргээн засалтын асуудал дээр манайх юу хийж байгаа вэ? Яагаад гэвэл хүн нэг удаа бэртэж гэмтээд нэг удаа өвдөхөөр хоёр дахь удаагаа гэмтэх, бэртэх эрсдэл нь угаасаа өндөр байдаг.

Тэгэхээр энэ дээр би хариулт авмаар байгаа юм. Цочмог цочмогдуу үеийн хариулт. Сэргээн засах.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн яамнаас хариулах уу? Эрүүл мэндийн яамнаас хариулах вэ? Эрүүл мэндийн яамнаас хариулъя.

Индрийн микрофоныг нээе.

**М.Оюунчимэг:** Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах шинжээч М.Оюунчимэг байна.

Ер нь сэргээн засахын тусламж, үйлчилгээ гэдэг бол хамгийн гол нь хөдөлмөрийн чадвар алдалт.

Амьдралын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн чадварыг нь алдагдахыг багасгах, бууруулахад чиглэсэн хамгийн том салбар маань. Гэхдээ сэргээн засахын тусламж, үйлчилгээний өнөөдөр төрөлжсөн мэргэжлийн эмч нарын хүртээмж их муу байгаа.

Тийм учраас анхан шатын тусламж, үйлчилгээ хүн гэртэйгээ хамгийн ойрхон байгаа газраасаа сэргээн засахын тусламж, үйлчилгээг авах, сэргээн засахын тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, дээрээс нь сэргээн засахын тусламж, үйлчилгээ эрт үеийн сэргээн засахыг эрүүл мэндийн байгууллага дээр нь эхлүүлэх гэдэг үйл ажиллагаан дээр чиглэсэн тодорхой ажлуудыг манай Эрүүл мэндийн яамны хэмжээнд тодорхой онцгой анхаарч ажиллаж байна.

Ийм учраас анхан шатын эрүүл мэндийн байгууллагын эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд сэргээн засахын тусламж, үйлчилгээгээ бид... /минут дуусав/

**П.Ганзориг:** О.Саранчулуун гишүүн тодруулъя.

**О.Саранчулуун:** Бид өнгөрсөн жил сэргээн засахын тусламж, үйлчилгээгээ цочмог, цочмогдын үеийн сэргээн засалтаар анхаараач ээ гээд Засгийн газрын таван жилийн төлөвлөгөөнд ч гэсэн оруулсан шүү дээ.

Тэгээд түүнтэй холбоотой тоймтой хариулт ерөөсөө өгөхгүй байна л даа.

Жишээлбэл, жишээ аваад үзье л дээ. Гэрээгээр барилгын компанид гэрээгээр шүү. Өдрийн ажил хийдэг хүмүүс барилгын компанид ажил хийж байгаад гэмтэж бэртлээ. Тэр хүн нийгмийн даатгал төлөх, нийгмийн даатгалын сангаас мөнгө авах эрх нь үүсээгүй байлаа гэж бодъё. Тэгээд тэр хүн хөлгүй боллоо. Хамгийн энгийн жишээ. Хөлийг нь ямар ч байсан амийг нь авраад эмнэлэг аварлаа.

- Одоо тэр хүнийг дараагийн асуудал хаачих вэ?
- Яг бодитойгоор хаачих юм бэ?
- Ямар арга хэмжээ авах юм?
- Ямар сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авах юм?
- Сэргээн засах нь яг хаана байх ёстой юм?
- Хиймэл хөлийнх нь мэдээллийг нь хаанаас авах ёстой юм?
- Гэр бүлд нь хэн туслах юм?
- Хоол ундгүй үлдсэн ар гэрийг нь хэн хариуцах вэ?

Ийм цогц үйлчилгээний талаар би хариулт авмаар байна л даа.

**П.Ганзориг:** Энэ асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулах нэмэлтээр хариулах хэрэгтэй юм байна.

Эрүүл мэндийн яамнаас хариулах бололцоотой бол. Б.Цэцэгсайхан дарга байна уу? Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга байна уу? Саяын асуултад хариулаад. Тэгээд шаардлагатай бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас нэмэлт хариулт авъя.

**Б.Цэцэгсайхан:** О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ асуудлыг өмнө нь ярьж байсан.

Тэгэхээр эмнэлэгт хэвтэхээс өмнө болон эмнэлгээс гарсны дараах тусламж, үйлчилгээг хэрхэн цогцоор үзүүлэх вэ гэдэг Discharge Plan<sup>1</sup>-ыг Эрүүл мэндийн яамнаас боловсруулаад явж байгаа.

---

<sup>1</sup> **Discharge Plan** гэдэг нь өвчтөн эмнэлгээс гарсны дараа үргэлжлүүлэн авах эмчилгээ, сувилгаа, хяналт,

Энэ төлөвлөгөөг Монгол, Японы эмнэлэг дээр хэрэгжүүлсэн байдаг. Энэ дагуу бусад эмнэлгүүддээ яг энэ тусламж, үйлчилгээг хэрхэн цогцоор үзүүлэх вэ, ялангуяа нийгмийн халамжийн үйлчилгээтэй нь дараа нь хэрхэн холбох вэ гээд энэ бүх тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлэх журмыг Эрүүл мэндийн яаман дээр боловсруулаад явж байгаа.

**П.Ганзориг:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас газрын дарга Ю.Отгонбилэг дарга хариулъя. Индрийн микрофон.

**Ю.Отгонбилэг:** О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Хөдөлмөрийн тухай хуулийн 125 дугаар зүйл дээр ажил олгогч нь энд хариуцлага хүлээхээр заасан байдаг. Хэдийгээр шимтгэл төлсөн хугацаа нь хангалтгүй байгаа ч гэсэн энэ хүнд нөхөн төлбөр олгох зохицуулалт Хөдөлмөрийн тухай хуулийн 125.1 дээр байгаа.

Харин яг тухайн хүн одоо жишээ нь гэмтэл, бэртлээс болоод хөлөө хугалаад тайруулсан ч юм уу, ийм тохиолдол гэх юм бол нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь хүрэхгүй бол нийгмийн халамжийн сангаас эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээ тогтоолгож байгаад тэтгэвэр, тэтгэмж авах боломж нь нээлттэй байгаа.

Протез, ортопедын хувьд үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсны өвчний улмаас протез, ортопед, бусад хэрэгсэл авах боломжгүй бол халамжийн сангаас авахаар байгаа. Тэгэхдээ яг энэ сэргээн засалтын хувьд анхаарах асуудлууд байгаа. Энэ дээр нийгмийн халамжийн тухай... /минут дуусав/

**П.Ганзориг:** Индэр дээр нэмэлт минут өгье.

**Ю.Отгонбилэг:** Тэгэхээр сэргээн засалтын асуудлууд дээр эрүүл мэндийн болон нийгмийн гээд бусад сэргээн засалтуудыг анхаарах шаардлагатай байгаа.

Ийм учраас Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр мэргэжлийн зөвлөл ажиллах, тухайн хүний кэйс нөхцөл байдал дээр нь үндэслээд яг ямар тусгай хэрэгсэл, дэмжлэг тухайн өрхөд шаардлагатай байхыг тодорхойлж, энэ дагуу тодорхой үйлчилгээ үзүүлэхээр тусгаад явж байгаа юм.

**П.Ганзориг:** Ж.Чинбүрэн гишүүн асуулт асууя.

**Ж.Чинбүрэн:** 25 дахь илтгэлийг сонслоо.

Илтгэл дотор эрүүл мэндийн, тэр дотроо хүний эрх, эрүүл мэндтэй холбоотой асуудлаар нэлээн том бүлэг болгож ярьж байгаад Та бүхэнд баярлалаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Гэхдээ бас бодитой байгаарай. Та бүгдийн авсан эх сурвалжууд –

- 2025 оны төгсгөлөөр, 2026 оны эхээр Засгийн газраас гарсан бичиг баримтууд орсон уу?
- Хийсэн ажлууд орсон уу?
- Тусгагдсан уу?

Аливаа зүйл их тийм бодитой байхгүй бол зүгээр шүүмжлэх байдлаас хандах нь өөрөө тийм зохимжтой биш. Та бүгдийн гаргасан сайжруулах хүрээнд эрүүл мэндтэй холбоотой 18 заалтууд байж байна. Би үүнийг харж байна.

Хууль, эрх зүйтэй давхцаж байгаа зүйлүүдийг хүлээн зөвшөөрч байна. Зөв. Өөрчлөлттэй зүйлүүд байгаа. Засах зүйлүүд байгаа. Санхүүжилтийн эх үүсвэрийг тэнцвэржүүлэх нь чухал байгаа. Эрүүл мэндийн даатгалын. Ялангуяа төрөөс дааж байгаа, хураамжийг нь төлж байгаа тэрийг тогтвортой болгох ёстой. Үүнийгээ бүр дурдах хэрэгтэй шүү дээ. Зоригтой хэлэх хэрэгтэй шүү дээ.

Дээрээс нь төрөөс дааж байгаа тусламж, үйлчилгээний зардал өртөг хоёр нь хоорондоо тохирохгүй байгаа шүү дээ. Зөрүүтэй байгаа.

Үүнээс болоод олон мянган иргэд гадаад руу эмчилгээнд явж байна шүү дээ. Хүртээмжгүй байдлаас болоод. Үүнийг жишээ болгоод хэлмээр байна шүү дээ.

Зүгээр нэг тоймлоод л, зүгээр нэг дурдсан болоод, эсвэл хэдэн улс төрчдийн хэлсэн үгнээс эшлэл татаад л тавьяж болохгүй шүү дээ. Илүү бодитой баймаар байна шүү дээ.

Бас манай салбарт өнгөрсөн хугацаанд нэлээдгүй сайн зүйлүүд байгаа. Тухайлах юм бол “Б”, “Ц” вирус устгах үндэсний хөтөлбөрийн үр дүнд өнөөдөр архаг өвчтэй элэгний “Б”, “Ц” вирустэй улсуудын тоо цөөрлөө. Анх удаагаа “Д” вирустэй хүмүүсийн эмчилгээ нэвтэрлээ. Бас нэг тийм шүүмжлэлийн хажуугаар нэг хийж байгаа зүйлүүдийг оруул л даа.

Жишээлэх юм бол “Өвчний хяналт сэргийлэлтийн үндэс Үндэсний төв” байгуулах захирамж энд дурдагдахгүй байна шүү дээ.

Үүний цаана ямар утга агуулж байгаа вэ гэхээр энэ бол бодлогын том бичиг баримт. Дээрээс нь Ерөнхий сайдаар ахлуулсан “Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл” байгуулах шийдвэрийг буцаагаад хуулийн хэрэгжилтийг биелүүлж байна шүү дээ.

- Яагаад үүнийг дурдаж болохгүй байгаа юм.
- Энэ чинь урам өгөх хэрэгтэй шүү дээ.
- Энэ салбарын чинь олон мянган ажилчид ковид цар тахлын дараах нөлөөлөл, тэрийг буулгах зорилгоор хүчтэй ажиллалаа.

Сайн хийсэн зүйлүүд байж байна. Эрхтэн шилжин суулгах хагалгаанууд хийж чаддаг боллоо.

- Дээрээс нь салбарын ажилчдын эрх зөрчигдсөн байсан шүү дээ. Шоронд бүр ял аваад байж байсан байна шүү дээ. Д.Сүнжид дарга яагаад үүнийг дурдаж болохгүй байгаа юм. Салбарын ажилчдын эрх ашиг хохирчлоод байгаа шүү дээ.

Тэгээд яаж тэмцэл болж цагаатгаж гаргаж ирэв. Үүнтэй холбоотой амьд донор, амьгүй донорын харьцаа алдагдсан. Амьгүй донор нэг ч гараагүй шүү дээ.

Дөнгөж саяхан л нэг гарлаа.

Тэгэхээр бодлогын шинж чанартай зүйлүүдээ бас нэг зөв өнцгөөс нь яримаар байна. Сая нэг чухал зүйл ярилаа. Би 1 минутаа нэмье.

**П.Ганзориг:** Ж.Чинбүрэн гишүүнд нэмэлт минут өгье.

**Ж.Чинбүрэн:** Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоолын талаар Та бүхэн яагаад үүнийг дүгнэж гаргаж ирэхгүй байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээг бид илүү сайжруулах гэж 135.0 тэрбум төгрөгийн зузаатгал хийж байна шүү дээ. Тэр дотроо ялангуяа амиа хорлолтод өртөөд байгаа залуучуудыг хамруулж, өрхийн эмч нар, сумын эмч нар үздэг байх санхүүжилтийн тогтолцоо, насны ангиллыг шинээр гаргасан шүү дээ.

Сайн зүйлийг дурдъя л даа хэдүүлээ. Дандаа шүүмжлэх юм. Сайн зүйл байна шүү дээ. Хүүхдийг бурмаар, хүнийг урмаар гэдэг юм шүү дээ. Энэ салбарын хийж байгаа ажлуудыг ярь л даа. Дандаа болохгүй болсон юм шиг юм ярих юм.

Жишээлбэл, эмийн үнийн хязгаарлалтыг бууруулах зорилгоор олон нийтэд үнийг нь ил болгосон шүү дээ.

- Энэ талаар яагаад дурдагдахгүй байна?
- Судлахгүй байгаа юм уу?
- Харахгүй байгаа юм уу?
- Мэдэхгүй байгаад байгаа юм уу?

Үүнтэй холбоотой эмийн аптекуудаар зөрүүтэй зарж байсан эмүүдийн үнийг адилхан болгосон шүү дээ. Тийм ээ. Нэгдсэн худалдан авах тогтолцоог ил хийж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтолцоо дутуу байгаа. Үнэн.

**П.Ганзориг:** Д.Сүнжид дарга Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулт өгөх нь зөв өө.

Минутдаа багтаагаад гол анхаарах асуудлуудаа сая танилцуулах шиг болсон.

Тэгэхээр мэдээж хүний эрх зөрчигдөж байсан эрүүл мэндийн салбартай холбоотой асуудлууд дээр шийдэгдээд явж байгаа дэвшилттэй сайн талуудаа дурдах нь зөв. Энэ тайландаа гэсэн санал хэлж байна. Энэ чухал. Тэгэхээр энэ асуудлууд дээр Та нэг хариулт өгөөд, тэгээд Ж.Чинбүрэн гишүүн тодруулъя.

Индрийн микрофон.

**Д.Сүнжид:** 4 төрөлжсөн судалгааг Хүний эрхийн Үндэсний Комиссоос захиалж хийлгэсэн юм.

- Санхүүжилтийн асуудал.
- Эмч, эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх эрхийн асуудал.
- Хүртээмж, хүрэлцээний асуудал.
- Гомдол шийдвэрлэж байгаа байдал гээд.

Эд нар дээр авч үзсэн. Иргэдийн сэтгэл ханамжийн түвшин гээд.

Түүнээс гадна бид өөрсдөө 74 эрүүл мэндийн байгууллагуудаар хяналт шалгалт хийсэн.

- Хөдөө орон нутаг,
- Хот.

Дараа нь ахиад эрүүл мэндийн салбар, бүх агентлагуудаас албан бичгээр сүүлийн үеийн бүх статистик мэдээллүүдийг авсан.

Хамгийн сүүлийнх нь 3 сарын 26-ны байдлаар бид update хийгээд тэр авсан мэдээлэл, статистик, тоо баримтыг комиссын илтгэлд ашигласан.

Сайн зүйлүүдийг дурдахыг хичээсэн. Болж байгаа зүйлүүдийг нь. Энэ 2026 оны байдлаар.

Энэ хугацаанд бид хувийн, төрийн өмчийн байгууллагуудын удирдлагуудтай хэлэлцүүлгийг удаа дараа хийсэн. Агентлаг, Эрүүл мэндийн яамдын удирдлагуудтай хийсэн. Өөрөөр хэлэх юм бол энэ салбарт яригдаж

байгаа асуудлууд, ахиц дэвшил болон шийдэх ёстой асуудлуудыг бодитой хандахыг эрмэлзээд 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулаад, өөрсдийнхөө тайлангийн явцыг танилцуулж саналыг нь авсан байгаа юм. Үүнийгээ үндэслээд бид хийсэн.

Жишээнүүд дээр яг Ж.Чинбүрэн гишүүний дурдаад байгаа жишээнүүд байгаа.

- Гадаадад эмчлүүлж байгаа яг нэг хүний жишээ бий.
- Оношийн зөрүү дээр бий.
- Эмч, эрүүл мэндийн ажилтнуудын шүүх, цагдаагаар шийдвэрлэгдэж байгаа байдал.

Түүн дээр тоо статистик болон тодорхой жишээнүүд байгаа. Шигтгээ гээд авсан дээр бид хамгийн их нийтлэг илэрхийлж чадна гэж үзсэн тохиолдлуудаа шигтгээ байдлаар оруулахыг хичээсэн байгаа юм.

**П.Ганзориг:** Ж.Чинбүрэн гишүүн тодруулъя.

**Ж.Чинбүрэн:** Тэгэхээр эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин 75 хувиар түүхэнд байхгүй нэмэгдсэн. Одоо 30 хувь нэмэгдээд явж байгаа. Энэ том дэвшил болж байгаа.

Дээрээс нь эмийн чанартай холбоотой асуудал дээр лавлагаа, лабораторийн үйл ажиллагаа, дээрээс нь цахимжиж байгаа байдал, ил тод байдлууд энэ болгон чинь эрүүл мэндийн салбарт гарч байгаа сайн зүйлүүд байгаа юм.

Ер нь тэгэхдээ нэг тийм мохоох биш, бас нэг жоохон хурцлаад өгөх, урам өгөх асуудал чухал шүү.

Таны зөвлөмж дээр гарсан зүйл нэг зүйлтэй санал нийлж байна. Мэргэжлийн бус улсууд салбарын үйл ажиллагааг хэт их доромжлох, гутаах, тэгснээрээ иргэдэд итгэл бий болохгүй, гадагшаа явах урсгалыг илүү нэмэх зүйл үүсээд байгаа шүү дээ.

Дээрээс нь мэдээж бид салбарт хийх ажлууд зөндөө байгаа. Ойлгож байна.

Ялангуяа бид сэргийлж болох нас баралтыг дурдсан байна лээ.

Тэгэхээр сэргийлж болох нас баралттай холбоотой том хөтөлбөр... /минут дуусав/

**П.Ганзориг:** Б.Бейсен гишүүн асуулт асууя.

---

**Б.Бейсен:** Тайлантай танилцлаа. Өнөөдөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар үйлчлүүлж байгаа ард иргэд, өвчтөнүүдийн эрс зөрчигдөж байгаа талаар тусдаа бүлэг болгоод ярьж байгаад их талархуштай байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үнэхээр алдагдсан уу. Алдагдсан. Одоо хэвтэж байгаа өвчтөнүүд ерөөсөө гаднаас эм авчирч байна. Хотод ирээд үзүүлж чадахгүй байна. 6 сар хүртэл очер хүлээж байна. Дараалал хүлээж байна.

Эмнэлгүүдийн өр зээлийг ер нь ил болго гээд би урьд нь ярьж байсан. Өглөг, авлагыг нь. Эрүүл мэндийн яам болохоор эмнэлгүүдэд өр, зээл байхгүй. Тэр эмийн компанийн өр гээд байх юм. Үүний цаана эмгүйгээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ явахгүй нь мэдээж. Үүнийг ерөөсөө тодорхой яримаар байх юм. Эмийн тендерт хаалттай систем гээд ороод их төсвийг нь аваад явдаг асуудал байж байгаа.

Нөгөө талаар ер нь улсын клиникийн том том эмнэлгүүд 9 дүүрэг, 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн өглөг, авлагыг ил болгохгүй ерөөсөө энэ эмнэлгийн тусламж салгасан хэвээр байх болно. Ерөөсөө. Эмийн компанийн өр гээд юу яриад байгаа юм. Ер нь. Үүнийг анхаарах цаг болсон.

Би түрүүн асуусан. Бүр хөдөөгийн эмнэлгүүдийн урсгал зардлыг хүртэл хасаад хаясан. Алсын дуудлагын юм уу, эмийн төсвийг нь бүр тэрбум хүртэл хасаад хаясан. Яах вэ, төсвийн ерөнхий захирагч нарын алдаатай бодлого, төсөв зөв зарцуулаагүй асуудал байдаг л байх. Гэхдээ энэ асуудал дээр дүгнэлт гаргаад үүнийг ил болгох шаардлагатай байгаа юм. Ингээд он дамжаад явж байх юм уу? 3, 4 жил явж байна.

Нөгөө талаар хавдартай өвчтөнүүдийн эрх зөрчигдөж байна. Эм байхгүй. Яг хавдар тойрсон аптекууд дээр байж байна. Доод тал нь 400 мянга, дээд тал нь сая хэртэл, 2 сая хүртэл эм авч байна шүү дээ.

Нөгөө талаар хөдөөгөөс ирээд 6 сар хүлээж байгаад үений хагалгаанд Алтай сумын нэг иргэн орж байна л даа. 11 саяар 2 дугаар эмнэлэгт маргааш орох гэж байна. Хагалгаанд. Аль эсвэл энэ хувийн эмнэлгүүдийг зогсоох хэрэгтэй. Доод тал нь 3 сая, дээд тал нь 30 хэдэн сая хүртэл төлбөр авдаг. Улсын эмнэлгээ босгож ирэхгүй бол төрийн улсын мэдлийн эмнэлгүүд чинь нурлаа шүү дээ. Яг өр, зээл нь хэд байна? Яг тодорхой ярьж өгөөч?

Нөгөө талаар нэг ярих асуудал байна. Энэ төсвийг Эрүүл мэндийн яамнаас асуухад Сангийн яам хассан гээд яриад байгаа байхгүй юу. Эмч, эмнэлгийн ажилчдын цалин нэмсэнтэй холбоотой гээд яриад байна. Үүнтэй холбоогүй. Үнэхээр эмнэлгийн ажилчдын эрх нь зөрчигдөж байгаа. Түрүүн Ж.Чинбүрэн гишүүн ярилаа.

Үүнийг яг Сангийн яам хассан юм уу, үгүй юм уу? Эсвэл Эрүүл мэндийн яам, Сангийн яам хоёр буруу тооцоолол хийгээд төсвийг батлаад оруулж ирж байна уу?

Өндөр өртөгтэй юунууд байж байна. Оношийн хамааралтай бүлгийн вакцин боловсруулах, түүнийг тарифыг тогтоохдоо дата мэдээлэл нь байхгүй асуудал байж байгаа. Эргэлзээтэй. Энэ ямар учиртай юм? Дараа нь тодруулъя.

**П.Ганзориг:** Д.Сүнжид дарга эхлээд хариулах уу? Эсвэл Эрүүл мэндийн яамнаас уу? Тэгвэл Б.Цэцэгсайхан Эрүүл мэндийн яамнаас хариулъя. Индэр дээр.

Эрүүл мэндийн яамнаас хэн хариулах юм? Энэ хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой чухал асуудал ярьж байхад сайд нар нь байхгүй бол Төрийн нарийн нар нь баймаар байна.

Тэгээд бодлогын чухал асуудал гишүүд асуухаар хариулж чадахгүй юм. Тэгээд бие бие рүүгээ хэн хариулах вэ гээд хараад сууж болохгүй шүү дээ.

Бүх юмыг Хүний эрхийн Үндэсний Комисс руу чихэж болохгүй. Энэ чинь хариуцсан бодлогын яамд байж байгаа шүү дээ.

Энэ байгууллагын өөрсдийнх нь хүн хүч, ажиллаж байгаа цар хүрээ юу билээ. Тийм болохоор холбогдох салбарын яамд, яамны сайд нар, Төрийн нарийн нар энэ чухал тайлан хэлэлцэж байхад хуралдаа орж ирж суугаад гишүүдийн асуултад бүрэн дүүрэн хариулт өгч, иргэдэд ч гэсэн бодитой мэдээлэл өгмөөр байна. Индэр дээрээс хариулъя.

**Ш.Энхтуяа:** Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн яамны ахлах шинжээч Ш.Энхтуяа байна.

Тэгэхээр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2024 оны шинэчилсэн найруулгаар эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалттай холбоотой нэлээд олон зохицуулалтууд орсон.

Энэ хүрээндээ бид эмнэлгийн тусламж, үйлчилгээний таслалаас сэргийлэх, эмийн хангамжийг дээшлүүлэх чиглэлээр нэг эх үүсвэрийн худалдан авалтыг хэрэгжүүлж эхэлсэн байгаа.

Тэгэхээр хавдрын эм дээр бид нэг эх үүсвэрийн худалдан авалтыг хамгийн анх 2024 оноос эхлүүлсэн.

Энэ хүрээндээ эхний удаад зөвхөн ганц Хавдар судлалын үндэсний төв дээр хавдар судлалын эмчилгээнд хэрэглэдэг 5 нэрийн эмийг авч хэрэглэж байсан бол өнгөрсөн онд эрүүл мэндийн 32 эрүүл мэндийн байгууллагын захиалгыг нэгтгээд тэр хавдрын 5 эмийг 32 эрүүл мэндийн байгууллагад Тендерийн хууль буюу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасны дагуу нэг эх үүсвэрийн аргаар худалдан авч түгээлтийг хийсэн байгаа.

Энэ нь хангамж, хүртээмж нэмэгдүүлж байгаа нэг арга байгаа юм.

Эмийн өртэй холбоотой асуудлыг гишүүн ярилаа. Эмийн өрийн асуудлыг манай санхүүгийн газар болоод Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас үе шаттай шийдвэрлэх зохицуулалтын аргуудыг хийж байгаа. Үүний дүнд бид 2026 оны 3 сарын байдлаар яг идэвхтэй үйл аж ажиллагаа явуулж байгаа 29 эм ханган нийлүүлэх байгууллагуудын өр, авлагын мэдээллийг авч үзэхэд 120 тэрбум орчим төгрөгийн өглөгтэй байсан.

Тэгэхээр манай даатгалын ерөнхий газар болоод санхүүгийн газрууд хамтраад өрүүдийг нь үе шаттай шийдэх зохицуулалтуудыг хийж ажиллаж байгаа.

Дээр нь бид эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдлаас сэргийлэх, орон нутгийн эмийн хангамжийг дээшлүүлэх чиглэлээр нэг эх үүсвэрээс гадна тендерээр худалдаж авч байгаа эмүүд маань нээлттэй тендер буюу түүнээс гадна цахим дэлгүүр гэж байгаа.

Тэгэхээр манай эм, эмнэлгийн хэрэгслийг 2018 оноос нээлттэй цахим дэлгүүр буюу ерөнхий гэрээг эхлүүлсэн. Ерөнхий гэрээгээрээ бид анх 2018 онд эхлүүлэхэд зөвхөн 18 нэрийн эмээр эхэлж байсан бол өнөөдөр 2025 оны сүүлийн байдлаар бид 216 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл, цахим дэлгүүрт байршсан гэсэн үг.

Өөрөөр хэлэх юм бол цахим дэлгүүрээс эм, эмнэлгийн хэрэгслээ авснаараа –

- үнийн ил тод байдал хангагдана,
- нэг үнээр авах боломж бүрдэнэ,
- хүртээмж нэмэгдэнэ.

Өөрөөр хэлэх юм бол тухайн эмнэлэг эмээ тухай бүр захиалаад авах боломж бүрдэж байгаа.

Дээр нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас судалгаа хийгээд сая 216 нэрийн эмээ нэмэгдүүлээд, 25 нэрийн эм, 26 нэрийн эмнэлгийн хэрэгслийг судлаад дахиад ерөнхий гэрээний эм дээр нэмэхээр Худалдан авах ажиллагааны газар луу санал хүргүүлсэн байгаа.

**П.Ганзориг:** Асуулт асуух гишүүдийн жагсаалтад М.Нарантуяа-Нара гишүүнийг нэмье. Б.Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** Энэ бас л эмийн өр зээл.

Хүний эрхийн комиссоос асууя. Одоо өндөр юутай болоод машинаа зараад, гэрээ барьцаалаад зээл авч байна. Гадагшаа эмчилгээнд явж байна. Бололцоо байсан мөртлөө Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт гэж байхгүй болсон. Байгаа юм уу? Одоо эрх нь зөрчигдөж байгаа асуудал мөн үү? Нэгдүгээрт.

Хоёрдугаар асуудал. Сая хөдөөгөөс нэг эмэгтэй хотод орж ирсэн. Аймгийн нэгдсэн эмнэлэгт зүгээр төрөхөөр очсон эмэгтэй умай нь урагдаад, сүүлдээ умайг нь тайраад, шээсний замыг нь гэмтээгээд 3 дугаар эмнэлэг хүнд байдалтай байж байна. Энэ эрх нь зөрчигдсэн асуудал мөн үү? Эрүүл мэндийн яам үүнийг шалгаж үзсэн үү?

**П.Ганзориг:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос хариулъя. Индрийн микрофон.

**Д.Сүнжид:** Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Эхний тэр санхүүжилт өр, авлагатай холбоотой тэр 80 хувийн санхүүжилтийг квотоор тогтоож байгаатай холбоотой. Ялангуяа анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд байнгын өглөг, авлага, үйлчилгээгээ зохистой үзүүлж чадахгүй байна гэдэг асуудлыг 74 байгууллагуудын хяналт шалгалтын хүрээнд ярьж байна.

Хоёр дахь нь, эм, тэр туслах хэрэгслийг зээлээр худалдаж авдаг асуудал төрөлжсөн эмнэлгүүдийн хувьд ч гэсэн түгээмэл байна.

Тэгээд он дамжсан өглөгүүд байна. Зөвхөн цөөхөн хэдэн төрөлжсөн, одоо Гэмтэл согог судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нялхсын эрүүл мэндийн үндэсний төв гэсэн энэ хэдээс бусад нь байнгын өглөг, авлагатай.

Ерөөсөө энэ харьцааг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай уулзаж ярилцан. Өөрсдөө шийдэхийг эрмэлзээд явж байна гэдэг хариу өгч байгаа. Энэ нэг өглөг, авлага огт тасраагүй процесстой юм билээ.

Хоёр дахь нь, чанарын хувьд. Одоо оношилгоо... /минут дуусав/

**П.Ганзориг:** Индэр дээр нэмэлт минут өгье.

---

**Д.Сүнжид:** Оношилгоо зөв байна уу, үгүй юу гээд. Үүнийг бид тэр чанар, нийцтэй байдал дээр авч үзсэн юм.

Тэгээд улсын хэмжээнд бид 7.3 хувь гэдэг онош буруу тавьсан, онош зөрүүтэй гэдэг мэргэжлийн, аюулгүй байдлын мэргэжлийн алдаа гэдэг асуудлыг ярьж байгаа.

Тэгээд хөдөө орон нутагт энэ нь хоёр дахин их байна лээ. 13 хувь. Яг таны хэлээд байгаа шиг иймэрхүү тохиолдвол хөдөө орон нутагт их болдог юм байна. Шалтгаан нь их олон хүчин зүйлтэй л авч үзээд байна л даа.

- Эмчийн ур чадвар.
- Мэргэшсэн байдал.

Түүнээс гадна хөдөө орон нутагт мэргэжлийн эмч нар байнга дутагдалтай юм билээ.

3 төрлийн эмч нар хөдөө орон нутагт тогтмол дутагдалтай байдаг. Хайгаад олдоггүй. Тогтвортой ажиллуулж чаддаггүй гэдгээ хэлдэг. Тэр нөлөөлдөг гэдгээ хэлдэг. Байгаа эмчийнх нь өөрийнх нь ур чадвараас нөлөөлж байна гэдгийг хэлдэг.

Дараагийнх нь тоног төхөөрөмжийн асуудлыг ярьдаг. Нөгөө урвалж, химийн бодис бэлэн лаборатори байна уу гэдэг асуудлуудыг асуудлыг ярьдаг. Тэгэхдээ чанарын болон оношийн зөрүүгийн асуудал байсаар байгаа. Үүнээс болоод хүн хохирч байгаа асуудал бий. Амь нас, эрүүл мэндээр хохирч байгаа асуудал бий. Бид дүгнэсэн.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн яамнаас нэмэлтээр хариулах уу? Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга байгаа юм байна шүү дээ.

Б.Янжмаа дарга хариулах уу? Индрийн микрофон.

**Б.Янжмаа:** Асуултад хариулья.

Тэр орон нутгаас тээвэрлэгдэж ирсэн эхийн умай урагдаж 3 дугаар эмнэлэгт шилжсэн гэсэн асуудлын талаар надад тодорхой нарийн мэдээлэл одоогоор алга байна. Би танд тодруулаад мэдээллүүдийг өгч болно. Баярлалаа.

**П.Ганзориг:** Б.Бейсен гишүүн тодруулья.

**Б.Бейсен:** Энэ харамсалтай байна. Эрүүл мэндийн сайд, Төрийн нарийн бүгд мэдсэн.

Тэгээд хотоос ч өчнөөн эмч очлоо. Сүүлдээ 3 дугаар эмнэлэгт ирсэн. Одоо хүнд байдалтай байгаа. Үүнийг мэдэж байх хэрэгтэй.

Хоёрдугаарт, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авахаар гэрээлэгдсэн юугаар тусламж авч байгаа ард иргэд, өвчтөнүүд тодорхой хэмжээний зардлаа буцааж авах ёстой. Үүнийг шалгаж үзсэн үү, үгүй юу? Хүний эрхийн комисс. Хэчнээн хүнд буцааж зардлыг нь олгосон юм бол? Аль эсвэл тэд нар чинь зээлээр авч байгаа шүү дээ.

Гэрээ барьцаалаад, машинаа барьцаалж зээл авч байгаа улсууд байхгүй юу. Цалингаа барьцаалаад.

Гэтэл буцааж олгож байсан тохиолдол байна уу?

**П.Ганзориг:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос хариулах уу? Нэмэлтээр Эрүүл мэндийн яам хариулах уу? Энэ эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой, санхүүжилттэй холбоотой асуудал байгаад байна шүү дээ.

Эрүүл мэндийн яамнаас холбогдох хүн нь хариулахаар бэлдэж байгаарай.

**Д.Сүнжид:** Санхүүжилтээс буцааж авсан тоо байгаа. Би илтгэлээсээ яг тодорхой харж байгаад тоог болон үнийн дүнг нь танд мэдээлье. Тохиолдлуудыг нь авч үзсэн. Илтгэлд оруулсан байгаа.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн яамнаас хэн хариулах вэ? Бодлого, төлөвлөлтийнх нь газрын дарга нар байна уу? Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга хариулах уу? Индрийн микрофон.

**Б.Цэцэгсайхан:** Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгүүдийн хувьд өнгөрсөн оны 198.0 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан гэсэн тоон мэдээллийг өгсөн байгаа.

**П.Ганзориг:** Т.Мөнхсайхан гишүүн асуулт асууя.

**Т.Мөнхсайхан:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Эрүүл мэндийн яамнаас хамгийн их ач холбогдол өгч энэ дээр хамгийн их л хүн ирсэн байна даа. Тэгээд өөрсдийнхөө хариуцсан асуултуудад тодорхой хариултуудыг нь өгөөд явмаар байна.

Бид хүүхдийн эрхийн асуудлаар, хүүхдийн эрхийг хангах талаар байнга л тогтмол анхаарал тавьж ярьж байдаг.

Гэтэл хүүхдийн эрхийн нөхцөл байдал ерөөсөө огтоосоо сайжрахгүй байгааг нэг тоо үзүүлэлтүүд маш тодорхой харуулж байна. Өсвөр насны хүүхдийн жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийн асуудал жил ирэх тусам нэмэгдэж байна. Хэрвээ хүүхдийн эрхийг хамгаалах тал дээр дорвитой зөв бодлого, арга хэмжээ авч байгаа бол энэ тоо жил ирэх тусам буух ёстой.

Гэтэл 15 насны хүүхдийн жирэмслэлт 2024 онд 1931 байсан бол 1994 болсон байна. 2025 онд 15-аас 19 насны хүүхдийн үр хөндөлт 600 гараад явж байна.

Ингээд өсвөр насны хүүхдийн жирэмслэлт, төрөлт 2600, 2700-аар яригдаж байна.

Тэгээд энэ тоо баримт үнэхээр хүүхдийн төлөө энэ олон байгууллагууд байгаад байдаг. Энэ олон байгууллагууд хяналт, шалгалт хийгээд байдаг. Энэ тоон үзүүлэлтүүд яагаад буухгүй байна аа? Буухгүй байгаа шалтгаан нь юутай холбоотой гэж авч үзэж байна? Хяналт шалгалт, дүгнэлт хийсэн байгууллагууд маань. Цаашдаа ямар бодитой цогц арга хэмжээнүүд авбал бид хүүхэд эрхийг хамгаалах, өсвөр насны хүүхдүүдийн жирэмслэлт, үр хөндөлтийг зогсоох вэ? Энэ өнөөдөр зөвхөн мэдэгдэж байгаа, илэрч байгаа тоо нь байхгүй юу.

Гэтэл үүний цаана хүчирхийлэлд өртөж байгаа маш олон тоонууд дарагдаад байж байгаа. Энэ дээр хариуцсан хууль эрх зүйн, хариуцлага тооцсон тоо баримтууд хэчнээн байна вэ? Бид цаашдаа ер нь яаж ажиллавал зөв болгох нь вэ? Энэ тал дээр Та бүхэн маань нэг тодорхой мэдээлэл өгөөч.

**П.Ганзориг:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос хариулъя. Индэр дээр индерийн микрофон.

**Ж.Хунан:** Т.Мөнхсайхан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр үнэхээр санал нэг байна. Өнөөдөр бид хүүхэд багачуудаа хамгаалж чадахгүй байна. Энэ чадахгүй байгааг өнөөдөр статистик тоонууд зүгээр бид нарт тодорхой илхэн хэлээд өгчхөж байгаа юм.

Тэгэхээр энэ хүүхдийн асуудал дээр нэг талаасаа нэг байгууллага, эсвэл нэг албан тушаалтныг хариуцлагатай байхыг шаардах асуудал биш. Энэ хүүхдийн өмнө насанд хүрсэн хүн бүр үүрэг хүлээгч гэдгийг бид маш сайн ухамсарлах ёстой байгаа юм.

Бага насны хүүхдийн жирэмслэлттэй холбоотой нэг зүйлийг тодруулж хэлэх нь зүйтэй байх. Энэ дээр 14 наснаас доошоогоо хүүхэд жирэмсэн бол энэ автоматаар гэмт хэрэгт тооцогдоод явж байгаа.

2024 онд 14-өөс доош насны хүүхэд жирэмсэн тохиолдол 144 байгаа.

Өөрөөр хэлбэл 144 гэмт хэрэг бүртгэгдээд шалгагдаад зохих ёсоор хүмүүс нь хариуцлага тооцоод, хариуцлагаа хүлээгээд явсан гэдэг зүйлийг хэлэх байна.

Нөгөө талаараа Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг чиг үүргийг хүлээдэг 10 нэгжийг өнгөрсөн онд судалж энэ дээр үнэлгээ өгч ажилласан байгаа. Эдгээр 10 нэгж бүгдээрээ хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Доор бүрнээ. Ялангуяа соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа.

Тэгэхээр энэ чиг үүрэг хангалттай хэмжээнд хэрэгжихгүй байна. Бидний дүн шинжилгээгээр хүүхэд хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын хоорондын уялдаа холбоо ерөөсөө байхгүй байна гэдэг зүйлийг ярьж байгаа.

Тэгэхээр түрүүн хэлсэн хүүхэд хамгаалал гэдэг бол зөвхөн хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газрын асуудал биш. Энд боловсролын салбар, эрүүл мэндийн салбар бүгдээрээ хамтарч ажиллах ёстой. Энэ дээр бүгдээрээ үр дүнтэй мэдээллээ солилцож ажиллах ёстой байгаа.

Бидний тавьж байгаа нэг асуудал бол хүүхэд хамгаалал. Бид яагаад өнөөдөр хүүхэд, багачуудаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж чадахгүй байгаа юм бэ гэхээр өнөөдөр бид энэ чиглэлээр мэргэжилтнүүдийг хангалттай хэмжээнд бэлдэж чадахгүй байна.

Ялангуяа хүүхэд багачуудтай ажиллах боловсон хүчин, одоо байгаа алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалт, тогтолцоо сул байгаатай холбоотой.

Дараагийн нэг асуудал бол төсвийн асуудал байгаа. Бид хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тавьж байгаа, зарцуулж байгаа төсөв хөрөнгө үнэхээр хангалтгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 онд бид баталсан боловч өнөөдөр хүртэл хүүхэд хамгааллын хуульд заасан арга хэмжээ, ажлууд бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгаатай шууд холбоотой.

Анхан шатны нэгж дээр хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнууд өнөөдөр ажиллаж байна. 2026 оны 3 сарын байдлаар 753 нийгмийн ажилтан анхан шатын нэгж дээр ажиллаж байна гэсэн үг. Энэ хүмүүс бүгдээрээ эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, энэ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Харамсалтай нь үр дүн төдийлөн гарахгүй дүр зураг байгаад байна.

Тэгэхээр энэ чиглэлээр бид ямар зүйлийг санал болгож байгаа вэ гэхээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдүүдийг соён гэгээрүүлэх ажлыг чанартай, хүртээмжтэй байдлаар хүүхдэд ойлгомжтой, хүүхдийн нас, онцлогт нь таарсан байдлаар бүх түвшинд нь хийх хэрэгтэй байна. Байгууллагууд хоорондоо уялдаа холбоотой ажиллах хэрэгтэй байна. Ялангуяа хамтарсан багийн үйл ажиллагаа... /минут дуусав/

**П.Ганзориг:** Индэр дээр нэмэлт минут өгье. Нэмж хариулах уу. Болсон уу? Тийм ээ. Уг нь нэмэлтээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Бадамцэцэг байна уу? Та нэмж хариулъя. Танай яамны бодлогын асуудал. Индрийн микрофон.

**Л.Бадамцэцэг:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрыг төлөөлж байна. Тийм.

Эрт жирэмслэлтийн асуудал ер нь нэлээд байгаа.

Тэгээд бид нарт хамгийн гол нь бүр аль хэдийнээ хүүхэд бэлгийн харьцаанд орсон, жирэмсэлсэн ийм үед нь бид илрүүлж байна.

Тэгээд ер нь хамгийн гол нь яг өсвөр насны хүүхдэд багаас нь л бэлгийн боловсрол олгох энэ ажил нэлээн дутмаг гэж харж байгаа. Шалтгааны хувьд. Ер нь бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж байхад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын гэр бүлийн боловсрол олгох 8 модуль, 34 сэдэвтэй гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөр батлагдаад, одоо жил болгон яг гэр бүл рүү чиглэсэн, хүүхэд рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг 21 аймаг, 9 дүүргийнхээ газар, хэлтсүүдээр дамжуулаад... /минут дуусав/

**П.Ганзориг:** Индэр дээр нэмэлт минут өгье.

**Л.Бадамцэцэг:** Дээр нь хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан гээд нэгхэн настай нийгмийн ажилтан мөн 2025 оны 01 сарын 01-нээс эхэлж ажилласан.

Ер нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх асуудал дээр манай нийгмийн ажилтнууд өнгөрсөн жилүүдийг бодох юм бол илрүүлэлтийн асуудал ер нь 20-иод хувиар нэмэгдсэн.

Тэгээд эцэг, эх рүү нөлөөлөх, сургуулийн хүүхэд хамгааллын багт холбон зуучлах, тэгээд өсвөр насны кабинетад. Тийм ээ. Эмнэлэг рүү хүүхдээ зуучлах энэ ажил өсөөд явж байгаа. Тэгэхдээ хамгийн гол нь яг өсвөр насны хүүхдэд бэлгийн боловсрол олгох ажлыг Боловсролын яам, тэгээд сургуулиуд, тэгээд манай байгууллага хамтарсан багтай зайлшгүй хамтарч ажиллах шаардлагатай гэж бид яг чиглэл явуулаад тэгээд үр дүнгээ тооцож ажиллаж байгаа.

**П.Ганзориг:** Т.Мөнхсайхан гишүүн тодруулъя.

**Т.Мөнхсайхан.** Одоо хэдүүлээ тэгээд болохгүй байгаа нь тодорхой юм байгаа учраас цаашдаа үүнийг яаж болдог болгох вэ. Нэгдсэн бодлого, арга хэмжээгээр хэн хангаж явах юм бэ гэдэг зүйлээ бид тодорхой болгомоор байна.

Та хэд бидний зүгээс энэ хууль эрх зүйн орчныг сайжруулах, энэ дээр ямар нэгэн нэмж шинэ хууль санаачлах ёстой юу, юу хийх ёстой вэ. Энэ зүйлийг бид нарт маш сайн тодорхой болгож өгмөөр байна.

Тэгэхгүй бол одоо өнөөдөр нэг нэг рүүгээ чихсэн байдалтай. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал юм уу, Боловсролын яамны асуудал юм уу, тухайн орон нутгийн асуудал юм уу.

Энэ олон байгууллага яаж хамтарч ажиллах юм гэдэг нь тодорхойгүй. Энд тэнд салангид. Болсон болоогүй ганц нэг аян хөтөлбөр хийж явсаар байтал энэ хүүхдүүдийн маань эрх зөрчигдөөд, энэ өсвөр насны жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт чинь утгаа алдаад байна.

2600 гэдэг чинь манай улсын хувьд нэг их тийм бага тоо биш шүү. Энэ маш их анхаарал хандуулах ёстой ийм тоо.

**П.Ганзориг:** Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас хариулаад, дээр нь яамнаас хариулах хэрэгтэй байна. Бодлогын асуудал дээр нь. Ямар хууль, эрх зүйн зохицуулалт Их Хурлын түвшинд, Байнгын хорооны, тэр тусмаа Засгийн газрын түвшинд хэрэгтэй байгаа юм бэ? Хүний эрхийн Үндэсний Комисс хариулах уу? Индэр дээрээс хариулчих. Яамнаас индэр дээрээс хариулчих.

**М.Цогтбаатар:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Ахлах шинжээч М.Цогтбаатар.

Тэгэхээр охидын жирэмслэлттэй холбоотой, ер нь гэр бүлийн боловсролын талаар бид бүхэн тодорхой судалгаануудыг авсан.

2024 онд Монгол гэр бүлийн хэв шинжийн судалгаа авсан. Эндээс гэр бүлийн боловсролыг хэр түвшинд олгож байгаа юм бэ. Ер нь гэр бүл болоход залуучууд маань амьдралд бэлтгэгдэж чадаж байна уу гэдэг асуудлаар судалгаа хийгдсэн.

Энд 70 орчим хувь нь гэр бүлийн боловсрол олгогдоогүй, бэлгийн боловсрол, төлөвлөлт чиглэлээр хангалттай үр дүнд хүрч чадахгүй байна. Тийм боловсрол, мэдлэг олж чадахгүй байна гэсэн судалгааны үр дүн гарсан. Энэ үүднээс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг сая 5 сарын 20-нд Засгийн газрын хуралдаанаар

хэлэлцүүлсэн. Одоо Улсын Их Хуралд өргөн барихаар тов гарах гэж байна. Энэ хуульд ер нь энэ гэр бүлийн боловсролыг, гэр бүлийн... /минут дуусав/

**П.Ганзориг:** Индэрт нэмэлт нэмэлт минут өгье.

**М.Цогтбаатар:** Гэр бүлийн төлөвлөлт, нөхөн үржихүйн боловсрол зэрэг энэ зүйлсийг гэр бүлийн орчинд нь гэр бүлийн төвөөр дамжуулж салбар дундын уялдаа холбоотойгоор хэрэгжүүлэх энэ заалтыг оруулж ирсэн байгаа юм. Санхүүжилтийн тогтолцоог мөн тусгаж өгсөн.

Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилт батлагдаад явах юм бол гэр бүлийн бүх гишүүдэд зориулсан хуулийн хэрэгжилт явах байх.

Ер нь хүүхэд хамгааллын тухай хуулиар бүх орчин дахь хүүхэд хамгааллыг зохицуулж өгсөн. Энд ялангуяа гэр бүлийн эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлагын асуудал байдаг. Боловсролын салбарын, эрүүл мэндийн салбарын гээд тоон мэдээллийг өгөх, хүүхэд хамгааллын мэргэжилтэнд хандах гээд энэ зохицуулалтуудыг бүгдийг нь заасан байгаа.

Тэгэхээр энд яг хэрэгжилт дээр салбар дундын уялдаа холбоог хангах хууль зохицуулалтаараа энд туссан байгаа.

Тэгээд энэ нь хууль дээр тусгагдаад явбал. Аянг бол мэдээж нуудаггүй байя. Охидын жирэмслэлтээс... /минут дуусав/

**П.Ганзориг:** Д.Сүнжид дарга нэмэлтээр хариулъя. Индрийн микрофон.

**Д.Сүнжид:** Хүний эрхийн зөрчлийг харахаар хэд хэдэн шалтгаантай л байдаг.

Тэгээд хамгийн том шалтгаан нь би төрийн албан хаагч нь хариуцаж байгаа байгууллагуудын өөрсдийнх нь манлайлал гэж хэлнэ.

Одоо бид нарт материаллаг хууль дутаагүй. Мэдээж процесс ч гэдэг юм уу, уялдаа холбоо хийх асуудал байдаг. Тэрийг бид хяналт шалгалт хийж явахдаа хардаг.

Зарим газар адилхан төсвөөр илүү ахицтай ажил хийсэн байдаг. Зарим нь ямар нэгэн шалтгаан хэлээд сууж байдаг байхгүй юу. Хийх хүнд шалтаг олдог, хийгээгүй хүнд юу олдог билээ яг тэр үг шиг юм болдог. Тийм болохоор бид ингэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт, хууль нь батлагддаг. Тэгэхдээ хуулиас болоод байгаа гэж би ёстой хэлэхгүй.

---

- ▷ **Нэгдүгээрт**, Засгийн газрын өөрсдийнх нь, яамдынх нь манлайлал, чиг үүрэгтээ эзэн болох байдал хэрэгтэй.
  - ▷ **Хоёрдугаарт**, уялдаа холбоо хэрэгтэй. Орон нутагтаа ажиллах системтэйгээ, тогтолцоотойгоо яаж уялдах юм бэ. Тэр хэрэгтэй.
  - ▷ **Гуравдугаарт**, хэдүүлээ тийм асар том юм нэг зэрэг хийх гээд байх хэрэггүй.
    - Тэр эрэгтэйчүүдийн кабинет,
    - эмэгтэйчүүдийн кабинет,
    - эрүүл мэндийн кабинеттайгаа гэр бүлийн боловсролыг –
- ахмад,
  - ахлах ангийнхан,
  - өсвөр насныхан, тэр бусад... /минут дуусав/.

**П.Ганзориг:** Индэр дээр нэмэлт минут өгье.

**Д.Сүнжид:** Зэрэгцээ бүх ажлыг хийх хэрэгтэй л гэж хэлнэ. Зөвхөн бид сургалтын хөтөлбөрийг нь асар сайхан нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг нь олгох юм гээд хүлээх биш байгаа. Боловсролын системээ сайжруулна. Нэг байгаа эрүүл мэндийн систем нь энэ. Яаж эрүүл мэндийн тогтолцоог нь сайжруулах юм бэ гэдэг дээр ажиллана.

Гуравт нь, эцэг, эх тэр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй ажиллах нийгмийн ажилтнуудын чармайлт энэ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чармайлт асар чухал байна.

Нийгмийн ажилтантай болсон. Одоо тэгвэл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэйгээ яаж ажиллах юм, тэр эцэг, эх, асран хамгаалагчтай нь яаж ажиллах юм. Гэр бүлийн хүрээнд л бүх энэ нөхцөл байдал чинь ихэнх нь явж байгаа шүү дээ. Гаднын гэхээсээ илүү.

Тэгэхээр үүн дээр бид таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилдаа яамыг манлайлаасай гэж хүсэж байна.

**П.Ганзориг:** Т.Мөнхсайхан гишүүн тодруулъя.

**Т.Мөнхсайхан:** Тийм. Тэгэхээр бид өсвөр үеийн жирэмслэлттэй холбоотой авах арга хэмжээнүүд маань уг нь их тодорхой байгаад байдаг. Бид өсвөр үеийн жирэмслэлтээс яаж сэргийлэх юм. Сэргийлэхийн тулд ямар арга хэмжээнүүд авах юм. Сургагч багш бэлдэхээс эхсүүлээд энэ дээр маш олон төрлийн арга хэмжээ байгаа. Бид ганц нэгийг нь л аваад байгаа.

Тэгээд өсвөр насны жирэмслэлт болсны дараа хариуцлага тооцох асуудал яах юм. 14-өөс 16 насны хооронд тэр жирэмсэн болгосон этгээд хуулийн хариуцлага хүлээх ёстой шүү дээ. Гэтэл энэ дээр дахин давтан үйлдлүүд яваад байдаг. Үүнийг илчилж гаргаж ирдэггүй энэ боловсролын байгууллагууд, тухайн хороо, дүүргийн нийгмийн ажилтнууд ямар хариуцлага хүлээж байгаа юм. Энэ дээр хариуцлага хүлээж байгаа тохиолдлууд ерөөсөө огтхон бараг байхгүй гэж хэлж болохоор байгаа юм.

Тэгэхээр бид хариуцлагын систем, тогтолцоог яаж сайжруулах юм. Гэх мэтчилэн бүх түвшинд нь цогц арга хэмжээг авч хэрэгжүүлдэг энэ бодлогоо гаргамаар байна.

**П.Ганзориг:** Үг хэллээ. М.Энхцэцэг гишүүн асуулт асууя.

**М.Энхцэцэг:** Сайн байцаана уу Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Танилцуулга хийсэнд баярлалаа.

Би хоёр асуудлаар ерөнхийдөө асуулт асууя гэж бодож байна.

- **Нэгдүгээрт нь,** цахилгааны аюулгүй байдал.
- **Хоёрдугаарт нь,** ажлын байрны аюулгүй байдлын тухай.

Тэгэхээр Та бүхэн мэдэж байгаа. Сүүлийн үед маш олон хүн, хүүхэд цахилгаан цохиулж нас барж байна. Мөн гэмтэж бэртээд хөдөлмөрийн чадвараа алдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй болж байна.

- Асуулт нь нэгдүгээрт энэ асуудал хүний эрхийн асуудалд орох уу?
- Энэ асуудлыг бууруулахын тулд би Та бүхэнд цаашдаа ямар ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа вэ?
- Ямар ажлыг хийе гэж бодож байгаа вэ?
- Мөн сүүлийн 5 жилийн хугацаанд хэдэн хүн, хүүхэд цахилгаанд цохиулж нас барсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон гэсэн судалгаа байна вэ?

Яалт ч үгүй хүн аюулгүй, найдвартай цахилгаан хангамжаар хангагдах нь хүний эрхийн наад захын асуудал. Хүний анхан шатны хэрэглээний асуудал. Энэ дээр хариулт өгөөч.

Хоёрдугаар асуудал нь, хүн аюулгүй, найдвартай ажлын байраар хангагдах хэрэгтэй.

Тэгэхээр энэ асуудал бас хүний эрхийн асуудалд орж байна уу? Маш олон хүмүүс эрсдэлтэй, өнөө маргаашгүй дэлбэрэхэд бэлэн тоноглолын хажууд ажиллаад нас барж байгаа, хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа, ажлын чадвараа алдаж байгаа.

Та бүхэн санаж байгаа бол дөнгөж өнгөрсөн онд яг өдийд дулааны цахилгаан станц III дээр дэлбэрэлт гарсан. Залуухан инженер хүн амь насаа алдсан.

- Тэгэхээр Та бүхэнд яг энэ төрлийн судалгаа байна уу?
- Хэдэн хүн тийм эрсдэлтэй нөхцөл байдал дээр өнөөдөр ажиллаж байна?
- Хэдэн хүн ажлын байран дээрээ эрсдэлтэй болоод нас барсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон?
- Энэ асуудлыг бууруулахын тулд ямар ажлуудыг хийхээр төлөвлөж байна вэ?

Ямар хууль, эрх зүйн орчинд яам нь онцгой анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй байна вэ гэдэг тал дээр хариулт өгөөч ээ. Энэ хоёр асуудал дээр.

**П.Ганзориг:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос хариулах уу? Эхлээд. Тэгээд салбарын яам нь.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах орчинтой холбоотой асуудлуудаар судалгаа тооцоо, цаашид ямар бодлогын арга хэмжээ авах вэ гэдэг талаас нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хариулахаа бэлдэж байгаарай.

Индрийн микрофон.

**М.Мөнхзул:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос авагдсан судалгаагаар 2020-2024 оны байдлаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үзүүлэлтийг нь авч үзвэл 2020 онд 354 байсан бол 2024 онд 711 болж хоёр дахин нэмэгдсэн.

Ялангуяа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд ихэвчлэн эрэгтэйчүүд өртөж байгаа. Хүнд ажил хөдөлмөр, осол гэмтлийн гол нөлөөлж байгаа хүчин зүйл болж байгаа.

Монгол Улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн үндэс бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүд тодорхой хэмжээнд бүрдэж олон улсын хэм хэмжээнд ойртож байгаа хэдий ч яг бодит байдал дээр үүний хэрэгжилт хангалтгүй байгаа.

Ялангуяа ажил олгогч Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүргийн, ажил олгогчийн үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсад бас мөрдөгдөж байгаа энэ чиглэлээрх стандарт хоорондын давхардал зөрчил, асуудлууд байна.

Тэгэхээр ажил олгогчийн үүргийг дээшлүүлэх, ялангуяа стандартуудын хэрэгжилтийг сайжруулах, мөн стандартын давхардал хийдлийг арилгах зайлшгүй шаардлагатай байна гэж харж байна.

Тэгэхээр аж ахуйн нэгжүүдийн зөвхөн 30 хувь нь л хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөөтэй, 40 хувь нь л аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтнуудтай гэхээр ажил олгогчийн үүргийн хэрэгжилт маш хангалтгүй байгааг дахин хэлмээр байна.

**П.Ганзориг:** Индрийн микрофоноос яамнаас нэмэлтээр хариулъя.

Гишүүний асуултад хариулъя.

**Ю.Отгонбилэг:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг.

Тэгэхээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар энэ харилцаа зохицуулагдаж байгаа. Гэсэн хэдий ч сая судалгаа, үнэлгээнүүдээр харахад хэрэгжилт хангалтгүй байгаа.

Тэгэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2025, 2026 онд энэ бүх стандартуудад үнэлгээ хийгээд, хуучирсан болон бүр 90-ээд оноос өмнөх стандартуудыг хүчингүй болгож, шинэчилж батлуулах ажлуудыг хийсэн байгаа.

Дараагийн нэг ажил бол Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас шинэчлэн боловсруулаад Их Хуралд өргөн барих товоо хүлээгээд байж байна.

Тэгэхээр энэ хуулиар яг энэ ажил олгогч нарт хүлээх хариуцлага, бас тодорхой санхүүжилтүүдийн асуудлуудыг нарийвчлан тусгасан байгаа. Хуулийн төсөл дээр. Тийм.

**П.Ганзориг:** Тодруулах уу? М.Энхцэцэг гишүүн. М.Энхцэцэг гишүүн тодруулъя.

**М.Энхцэцэг:** Тэр цахилгаанд цохиулаад хүн, хүүхэд нас барж байгаа асуудал дээр хариултаа авч чадсангүй

Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөх боломж байна уу? Хэрвээ байхгүй бол. Нэмээд авъя даа.

**П.Ганзориг:** Нэмэлтээр Ажлын хэсгээс индрийн микрофондоо хариулъя.

**М.Отгонгэрэл:** Гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар.

---

Хүүхдийн аюул осол, эндэгдлийн хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас “Хамгаалъя, шалгая” аяны хүрээнд, мөн “Эрхэм хэрэглэгч” аяны хүрээнд жил болгон эцэг эх, гэр бүлүүдийг гэрийн орчны цахилгаан, хүүхдийн аюулгүй орчныг шалгах шалгуур үзүүлэлтийг гарган шалгадаг.

Энэ хүрээнд сая 2026 оны 4 сар, 5 сард хоёр сарын хугацаанд хяналт шалгалт болон эцэг, эхчүүдийн өөрсдийн гэрийн аюулгүй орчин, сургуулийн орчны аюулгүй байдлын үнэлгээнүүдийг хийлгэсэн байгаа.

Энэ хүрээнд нийтлэгээр яг гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдал, цахилгааны эрсдэл 60-аас 70 хувийн улсын хэмжээнд эрсдэлтэй гэж нэгдсэн тайлан мэдээ гарсан. Энэ дээр эцэг, эх гэр бүлүүдийг гэр бүлийн болон бусад орчны аюулгүй байдлыг хангах дээр холбогдох зөвлөмжүүдийг өгөөд явдаг.

**П.Ганзориг:** Энэ уг нь холбогдох газрууд нь тоо статистиктай асуудал байна. Үүнийг бодлогын хэмжээнд ингэж шийднэ гээд тодорхой хариулбал зүгээр.

Тухайлбал, сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2019-2023 оны хооронд 0-ээс 19 насны хүүхэд яг энэ осол гэмтлийн улмаас эрүүл мэндийн байгууллагад зөвхөн бүртгэгдсэн л байхгүй юу. 5 жилийн хугацаанд 323 мянган хүүхэд гээд энэ тайлан дээр байж байна.

Тэгэхээр ийм өндөр тоотой, ноцтой асуудал байхад үүн дээр тухайлбал холбогдох газрууд нь ямар бодлогын арга хэмжээнүүд авах хэрэгцээ шаардлагатай байгаа юм бэ гэдгээ гишүүдийн асуултад хариулахдаа тодорхой хэлээд явах хэрэгтэй байна шүү.

М.Энхцэцэг гишүүн тодруулах уу? С.Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэбат:** Тайлантай нэлээн танилцлаа. Тэгэхдээ нэлээн тулгуу өглөө. Уг нь маш чухал. Зарим чиглэлээр нь хөндөгдөөгүй. Анх удаа хөндөгдөж байгаа асуудал байж байна.

Хүний эрхийг хамгаалагчийн тухай эрх зүйн байдлын талаар нэлээн судалгаа хийжээ. Би тодорхой асуултууд асууя. Яг хүний эрхийг хамгаалагчийг өөрийг нь хамгаалах тухай асуудал байж байгаа. Энэ тал дээр хэр зэрэг бэхжиж байна вэ? Нөгөө манай хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах тухай нөгөө зөвлөл маань ямар хэргүүд орсон бэ гэдэг юмыг асуумаар байна.

Ялангуяа хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах асуудал маань мэдээж эрх мэдэл, мөнгө хөрөнгө, маш олон зүйлтэй холбогддог.

Тэгэхээр цаашдаа бид тэр хүмүүс өөрсдөө гомдол гаргана гэхийг хүлээхээсээ илүүтэйгээр өөрсдөө энэ хүмүүсийг нээн илрүүлэх ийм ажлыг хийж

чадахгүй бол магадгүй олон хүний эрхийг хамгаалагчийн итгэл буурах, магадгүй энэ асуудал маань далд хэлбэрээр өнгөрөх асуудал байна. Надад маш олон юм ирдэг юм.

Тэгээд юу гэж хэлдэг вэ гэхээр яг ний нуугүй хэлэхэд эргээд биднийг үнэхээр сайн хамгаалж чадахгүй бол бүр эргээд эрсдэлд орох эрсдэл өндөр гэж.

Тийм учраас энэ тал дээр мэдээж асуулт асуумаар байна.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн асуудал оруулж ирсэн байна. Чухал асуудал байна. Тухайлбал, намайг сая хөдөө явж байхад Хөвсгөл аймагт 7 сум Эрүүл мэндийн даатгалаасаа эмийнхээ хөнгөлөлттэй үнийг авч чадахгүй бараг 2 жил боллоо. Нэг.

Энэ нь өөрөө эргээд нөгөө даатгал, төрөөс тусламж, дэмжлэг авах эрх нь хангагддаггүй. Эрүүл мэндийн яам нэлээн өндөр стандарт тавьчихаад суугаад байдаг. Нэг сумын төв дээр аптека ажиллуулах стандарт гээд Улаанбаатар хотын бараг Моносын стандартыг нь тавьчихаад байдаг. Яах вэ, стандарт нь зөв байх. Гэхдээ бодит байдал, бодит энэ зүйлийг яах вэ. Магадгүй 330 сумаас хэд нь ийм байгаа бол.

Эрүүл мэндийн даатгалаараа хөнгөлөлттэй эмээ авч чадахгүй. Тэр хүн эмээ хөнгөлөлтөө авч чадахгүй гомдол их ирдэг гэж.

Гуравдугаар асуудал бол хүүхдийн эрхийн асуудал гээд тавьсан. Та хэд үүнийг сонирхож үзэв үү, үгүй юу. Хүүхдийн орчинд байгаа засвар үйлчилгээ, нөгөө будгаас маш их хэмжээний хар тугалга илэрдэг гээд. Энэ бол одоо нөгөө үйлдэхүй болон эс үйлдэхүйгээрээ хүүхдийн эрхэд ноцтой хохирол учруулж байгаа асуудал байгаа.

Би ганцхан жижигхэн жишээ гэж хэлж магадгүй. Та хэд хэрвээ бүх 10 жилийн. Үүнийг хэрвээ хийгээгүй бол та бүгд маань нэг явуулаад үзээч гэж. 10 жилийн хүүхдүүд дээр яг яваад үзэхээр агаарын чанарын асуудал аягүй том асуудал байдаг юм байна лээ.

Ж.Галбадрах гишүүн, бид хэд 10 жилийн сургуулиар яваад үзэхээр цонх нь ялангуяа өвлийн улиралд яадаг вэ гэхээр битүү томоороо нээгддэг. Агааржуулалтаа хийхийн тулд яадаг вэ гэхээр хамгийн захын хүүхэд даарч байгаа учраас тэр цонхыг хэзээ ч онгойлгодоггүй.

Тийм учраас хүүхдүүд агаарын дутагдлаас болоод маш их том өвчний суурь юу болж байдаг. Үүнийг би Боловсролын яаманд зөндөө хэллээ. Үе үеийн сайд нарт нь хэллээ. Жижиг асуудал гээд тоодоггүй юм байна.

**П.Ганзориг:** С.Эрдэнэбат гишүүнд нэмэлт минут өгье.

**С.Эрдэнэбат:** Энэ тал дээр нэг хариулж өгөөч гэж.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд маш чухал асуудал хөндсөн байна. 10 жилд байж байхад хүүхдүүдийг очоод хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, оюутнуудын компаничилсан үзлэг гээд байгаа. Яах вэ, үүнийг манай Эрүүл мэндийн яам маань урьдчилан сэргийлэх гэдэг байдлаар тавингуут яг эрэгтэйчүүд нь үлдээд байх шиг байх юм.

Тэгээд үүнийг эрэгтэйчүүд байдаг газар хүчээр бараг оруулах гэдэг нэг юм руу хүний эрх гэхээсээ илүүтэйгээр тэр хүмүүсийг хамгаалах гэж байгаа бол яг ийм арга хэмжээг зохион байгуулахгүй бол яг нөгөө эрчүүдийн эрүүл мэндийн асуудал орхигдоод байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал байж байгаа. Зүрх судас гэдэг юм уу, даралт гэдэг юм уу, ажлын байран дээр харваад өнгөрөнгүүт нь яадаг вэ гэхээр тэр өвчнөөр нь оношлоод л тавьдаг.

Гэтэл үүний цаана мэргэжлээс шалтгаалах өвчлөл буюу орчны хүчин зүйлийн нөлөөлөл гэдэг зүйл дээр бид тусгайлан хяналт хийхгүй энэ нас баралт буурахгүй.

Хамгийн сүүлийн асуудал. Хөдөөгийн хүүхдийн сурах асуудал дээр ер нь ямар байр суурьтай байгаа вэ? 10-тайд нь сургая гээд яриад байгаа шүү дээ? Энэ дээр хүний эрх... /минут дуусав/

**П.Ганзориг:** Д.Сүнжид дарга хариулъя. Тэгээд нэмэлтээр холбогдох яамдууд хариултаа бэлдэж байгаа.

**Д.Сүнжид:** С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт дээр сайн гарсан үзүүлэлт нь энэ хуулийг мэддэг болсон гэдэг нь 99 хувь байна лээ.

Ямар нэг байдлаар энэ хуулийг мэддэг хүний эрх хамгаалагчийн эрх зүйг хамгаална, гомдол гаргаж болно гэдэг механизмыг мэддэг болсон байна. Энэ 4 жилийн хугацаанд.

Ямар асуудал байна вэ гэхээр энэ дээр заналхийлэлд өртдөг, хамгаалалтад өөрсдийгөө авч чадна гэдэг итгэлгүй байна гэдэг хоёр хүн тутмын нэг нь тийм эргэлзээтэй байна гэдгээ хэлж байна.

Тэгээд үүний цаана бид жил болгон өгөөд байгаа нэг санал бий. Гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн байдлыг тодорхой болгож өгнө үү гээд. Бид нарт энэ дээр гэрч, хохирогчийг хамгаалах found байдаггүй. Сэтгэл зүйн тусламж,

үйлчилгээг одоо бид Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн found-аас авч хэрэгжүүлдэг. Хүний эрхийн хамгаалагчийн хороо. Шаардлагатай сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ болохоор бид тусгайлсан төсөв байдаггүй байдаг учраас олон улсын байгууллагын дэмжлэг дээр үүнийг хэрэгжүүлж байна. Гэрч хамгаалагчийг бид цагдаагийн байгууллага руу шилжүүлж байна. Тэр нь 5 хүнтэй нэг нэгж байна.

Тэгэхээр зөвхөн манай хороо гэлтгүй хамтдаа уялдаа холбоотой ажиллаж гэрч, хохирогчийг хамгаалахгүй бол энэ нэг систем бүхлээрээ иж бүрэн цогц болох боломжгүй дүр зураг. Өрөөсөн баганатай л явж байгаа нэг дүр зураг байгаа юм.

Хүний эрх хамгаалагчийн хороо 7 гишүүнтэй ажилладаг. Тэгээд энэ нь орон тооны бус. Манай С.Дондов гээд гишүүн Хүний эрхийг хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн ахалдаг. Жилдээ 20 орчим гомдол ирж байгаа. Ихэнх нь сэтгүүлчдээс ирж байгаа юм.

Мөн иргэний нийгмийн активуудаас өөрсдөө хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсныхаа төлөө заналхийлэлд өртлөө гэдэг асуудлаар ирдэг.

Үүнийг бүгдийг нь хариуг нь өгөөд хянан шийдвэрлээд явж байгаа. Үүнийгээ ч хэвлэл, мэдээллээр С.Дондов гишүүн болон түүний хороо танилцуулаад явдаг.

Хоёр дахь асуудал. Улсын Их Хурлын 2024 оны 37 дугаар тогтоолоор бид дотоод орчны агаарын чанарыг авч үзсэн юм.

Тэгээд 37 дугаар тогтоол дээр Засгийн газарт үүрэг болгоод, дотоод орчны агаарын чанарын стандартыг бий болгоод хяналт тавиач ээ гэдэг ийм заалтыг Засгийн газарт үүрэг болгосон. Нэмэх нь бид үүнийг тухайн үед Байгаль орчин, аялал жуулчлалын яам гэж байсан. Тэнд Боловсролын яаманд, Эрүүл мэндийн яаманд бүгдэд нь явуулсан.

Одоо яг тэр 0-ээс 5 насны хүүхдүүдийн уушгины өвчлөлийн улмаас нас барж байгаа тоо гэсэн чинь гадна агаарын чанар биш дотоод агаарын чанарын улмаас нас барж байгаа тоо нь өндөр.

Тэгээд өвчилж байгаа тоогоор тэр астма, уушгины зам. Зөвхөн уушги биш зүрх судасны замын өвчлөл бий болж байна гэдэг дүгнэлт байсан учраас үүнийгээ тэр засвар үйлчилгээ, авч байгаа материалынхаа чанарыг хянаач ээ гэдгийг нь бид Сангийн яам, Гаалийн ерөнхий газар луу хүртэл бүгдийг нь явуулсан. Хариу нь бид анхаарч байна гэж ирүүлсэн. Хамгийн сүүлийн ахиц гэвэл стандарттай болсон явдал л байна. Бусад яг хэрэгжүүлж байгаа байдал дээр яамд өөрсдөө тодорхой хариулт өгвөл зүгээр байна.

Нөгөө хоёр асуудал дээр манай гишүүдээс нэмэлт тодруулга хийе.

---

**П.Ганзориг:** Хэн хариулах вэ? Индрээс.

**М.Оюунчимэг:** Сайн байна уу? Гишүүний эмийн сантай холбоотой асуултын хэсэг дээр хариулт өгье.

Тэгэхээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 2800 орчим эмийн сан байгаа. Тэдгээрийн 1100 орчим нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа.

Эмийн сан маань тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулахаар Зөвшөөрлийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан байдаг. Энэ хүрээндээ тухайн орон нутагт эмийн сангийн тусгай зөвшөөрөл өгч байгаа.

Сая гишүүний асуудлаар тухайлах юм бол Хөвсгөл аймагт гэхэд тусгай зөвшөөрлөө авсан байж байгаад даатгалаар хөнгөлөлттэй олгох эмээ авахад даатгалтай гэрээ хийх асуудал дээр хөндөгдөж байгаа асуудал гарч байгаа.

Тэгэхээр ер нь манай эмийн сангийн стандарт 2015 онд батлагдсан байдаг. Энэ стандарт орон нутагт эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “эмийн сангийн эрхлэгч нь эм зүйч биш, эм найруулагч байж болно” гэдэг стандартын зохицуулалт, заалт байдаг. Өөрөөр хэлэх юм бол хөнгөлж байгаа нэг зохицуулалт.

Дараа нь бид Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2024 оны... /минут дуусав/

**П.Ганзориг:** Нэмэлт минут. Индэр дээр.

**М.Оюунчимэг:** Эм, эмнэлгийн эрхийн тухай хууль дээр тусгай зөвшөөрлийн зохицуулалтууд нэмж өгсөн байж байгаа.

Тэгээд дээр нь тухайлах юм бол Хөвсгөл аймгийн 7 сумын эмийн сангийн асуудлыг өмнө нь С.Эрдэнэбат гишүүнтэй энэ асуудал дээр мэдээлэл солилцож байсны хувьд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт чиглэл өгөөд Галт болон Мөрөн сумууд дээр эмийн сангуудын гэрээ 2025 онд хийгдсэн.

Дахиад Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр гэр гэрээт эмийн сангууд дээр хяналт, үнэлгээ хийгдээд 2026 оны гэрээ хийгдэх асуудлуудыг дахиад явж байгаа. Энэ дээр бид эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд даатгалаар олгох эмийн сангуудынхаа тоог нэмэгдэх чиглэлийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар өгсөн байж байгаа.

Дараагийн нэг асуудал нь Эмийн сангийн 2015 оноос хойш мөрдөгдөж байгаа стандартыг шинэчлэхээр бид боловсруулаад Стандарт, хэмжил зүйн

газарт хүргүүлсэн. Стандарт, хэмжил зүйн газрын сайтаар олон нийтээс санал авах шатдаа явж байна.

**П.Ганзориг:** Эрүүл мэндийн салбарын санхүүжилттэй холбоотой асуудлуудаар ирэх долоо хоногт Байнгын хороогоор бид сайдаас нь мэдээлэл сонсохоор хуваарьт тавьсан байж байгаа.

Тэгээд өнөөдөр хангалттай хариулт авч чадахгүй байх шиг байна. Тийм болохоор ирэх долоо хоногт Байнгын хорооны хэлэлцүүлгийн үеэр нэлээн дэлгэрэнгүй энэ асуудлыг онцгойлж хэлэлцэнэ.

С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

**С.Эрдэнэбат:** Хүний эрхийн хамгаалагч хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байвал үүнийгээ өгөөч ээ. Энэ дээр би мэдэж байна. Уг нь анхны төсөл нь аягүй сайн хууль орж ирээд явцын дунд тэгээд мөлийлгөсөөр байгаад орхисон.

Тийм учраас энэ тал дээр Хүний эрхийн комисс маань санал байвал өг. Шаардлагуудаа бид дэмжээд өргөн барья. Тэгэхгүй яг ний нуугүй хэлэхэд бидний хүчин чадал, чадавх яг тэр тал дээр үндсэндээ нэг зөвлөл байгуулаад, тэгээд мөрдөн шалгах малгах зөндөө ажиллагаа байгаа. Тийм ээ. Түүн дээр ерөөсөө тодорхой ажиллагаа хийхэд нэлээн хүндрэлтэй. Хүний эрхийн комисс аваад явахад.

Хүүхдийн дотоод орчны юман дээр Та бүгд маань тэрийг Боловсролын яам руу. Уг нь маш амархан л хий ёстой байгаа юм. Үүнийг нэг явуулж өгөөч ээ. Тэр цонх агааржуулалтын асуудлыг нь гэдгийг хэлмээр байна.

Эрүүл мэндийн хувьд хүмүүсийг очер дарааллыг нь албаар сар сард нь хуваарилаад, одоо энэ 20 хоногийн дараа гэдэг юу чинь эрүүл мэндийн санхүүжилт хуваарилснаас болоод байгаа юм байна лээ шүү дээ.

**П.Ганзориг:** О.Батнайрамдал гишүүнийг асуулт асуух гишүүдийн жагсаалтад нэмье.

Ж.Галбадрах гишүүн асуулт асууя.

**Ж.Галбадрах:** Өдрийн мэнд хүргэе.

2024 он, 2025 он гэсэн энэ хоёр зузаан илтгэлийг харж байгаа. Энэ дээр боловсролын талаар хүний сурч боловсрох эрхтэй гэсэн Үндсэн хуулийн 16.7-д заасан тэр эрхийн талаар ерөөсөө үзэгдэхгүй байна. Энэ одоо яаж бүтцээр нь яаж бичдэг юм гэдгийг нэгдүгээрт асууя.

---

Тэгээд хэдийд нь тэр орж ирэх вэ? Энэ жилийнхийг харахад түрүүчийн гишүүн хэлж байсан. Их баяртай байна. Аягүй олон асуудал орууллаа гээд. Эрүүл мэндийн асуудал нэлээн сайн орсон байна. Боловсролын асуудал “Боловсрол ба эрэгтэйчүүд” гээд. Тийм ээ. Жендэрийн асуудал дээр л нэг орж ирлээ.

Нэгдүгээрт, яагаад боловсролын салбар орохгүй байна. Дараагийн 2026, 2027 онд орно гээд байгаа юм уу? Боловсролын салбарт хүний эрх, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудлыг жил болгонд нь бичээд, тэр шалтгаан нь байхгүй юм уу гэдэг асуудал.

Ер нь боловсролын салбарт эрх зөрчигдөхгүй байгаа гэж үзээд байна уу гэдэг асуудал байна.

→ Сурч боловсрох эрхтэй гэдгийг ер нь хамрагдалтын хувиар нь л үзээд байна уу?

Цэцэрлэгт –

- сургуулийн өмнөх боловсрол,
- бага боловсрол,
- суурь боловсрол,
- Бүрэн дунд боловсролд хамрагдалт Монгол Улс өндөр.

Тэр өндөр хувиар нь үзэнгүүтээ энд эрх зөрчигдөхгүй байна гээд үзээд болж байна уу?

Боловсролын салбарт маш олон хүүхдийн эрх ашиг зөрчигдөж байгаа. Маш ноцтой зөрчигдөж байна. Багш нарын эрх ашиг зөрчигдөж байна.

Энэ хүүхдийн эрх ашгийг Та бүхэн маань яг юу гэж ойлгодог вэ? Жишээ нь, би их хүртээмж ярьдаг хүн. Нэг ангид 40-өөс дээш хүүхэд сурч байгаа үед тэнд сургалтын чанар ярих арга байхгүй. 40-өөс дээш бүлэгт сурч байгаа хүүхэд Монгол Улсын хэмжээнд хэдэн мянган хүүхэд байдаг юм бол? Тэр хүүхдүүдийн эрх зөрчигдөж байгаа. Тэнд яагаад ч чанартай сургалт олж авах боломж байхгүй. Сургалтын чанарын тухай ярих боломжгүй болж байгаа.

Нэг сургуульд 4 мянга, 5 мянга, 6 мянга давсан багтаж чихэлдэж байгаа тэр газар хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэх энэ талын эрхийн асуудал маш ноцтой зөрчигдөж байгаа.

Үүнийг Хүний эрхийн Үндэсний Комисс маань энэ дээр гаргаж ирж тавьж явж байж энэ асуудал маш олны анхааралд очно.

Түүнээс хамрагдалтын зүгээр хуваарь яваад байгаа биш. Ийм тоонуудыг асууя.

Багшийн хомсдол гэж байгаа. Багшгүйгээс болоод зөндөө ярьдаг шүү дээ. Хүмүүс. Би зүгээр энэ явган яриа шиг юм яримааргүй байна. Одоо 5 мянга гаруй багш дутагдаж байгаа.

Тэгээд энэ дотор чинь хими, физикийн багшаас эхлээд дутагдана. Химийн багш байхгүйгээс тухайн нэг сумд ерөөсөө анагаахад элсэж ордог хүүхэд байхгүй.

**П.Ганзориг:** Ж.Галбадрах гишүүнд нэмэлт минут өгье.

**Ж.Галбадрах:** Одоо багшийн хомсдол гэдэг ноцтой байна.

Багшгүйгээс болоод хими, физикийн хичээл үзэхгүй. Тэгээд эмч болж чадахгүй. Ирээдүйд ингээд явж байгаа, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудал мөн үү? Үүнийг яагаад энэ дээр авч үзэж ярихгүй байгаа юм бэ?

Хүний эрхийн Үндэсний Комисс хийгээд л энэ дээр маш том шүгэл үлээж,

- ➔ жил болгон гарч ирээд,
- ➔ энэ нь хэдээр багасаад байгаа юм,
- ➔ яагаад байгаа юм,
- ➔ ямар арга хэмжээ авах ёстой юм –

гэдэг энэ асуудлуудыг л би гаргаж ирж тавих ёстой гэж бодож байгаа.

Түүнээс биш энэ дээр өөр өөр сэдэв гаргаж ирээд, өөр өөр судалгааны материал гэдэг юм уу, юманд хэрэглэхээр юмнууд бичиж яваад байна л даа.

Энэ бүгдийг нь. Тэгээд дуусаж байх шиг байна. Дараа тодотгож асуух юм байгаа.

**П.Ганзориг:** Ж.Галбадрах гишүүн боловсролын салбарт хүүхдийн, бүр цаашлаад багш нарын эрх зөрчигдөж байгаатай холбоотой чухал асуудал асууж байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Цагааннуур, Ренчинлхүмбэ, Баянзүрх гээд суманд аймаг болгон нь галлагаатай байгаа шүү дээ.

Галлаад галлаад хасах температур доор хичээллэж байгаа. Тэнд хүүхдийн сурах эрхээс гадна эрүүл мэндийн асуудал. Багш нар ч гэсэн ажиллах нөхцөл, орчин маш хэцүү. Одоогоос бараг 50, 60 жилийн өмнө баригдсан модон сургууль яаж ч дулаалаад дулаан алдагдал нь зогсохгүй. Тэгээд галлагаатай байж байгаа.

Тэгэхээр ийм ноцтой асуудлуудыг Хүний эрхийн Үндэсний Комиссоос тайлан дээрээ оруулж дурдаж, асуудлыг шийдэх дээр шахаж шаардаж явах нь зөв өө. Их Хурлын гишүүдийн анхааралд оруулж үүнийг явахгүй бол олон жил явсан. Төсөв, хөрөнгө оруулалт нь шийдэгддэггүй гээд асуудлууд байгаа.

Индэр дээрээс хариулъя.

**Д.Сүнжид:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос жил болгон тодорхой сэдвүүдийг сонгож аваад тэр хүрээнд хүний эрхийн асуудлыг илэрхийлж байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 24 дэх илтгэлд бид боловсролын салбар дахь хүний эрхийн асуудлыг бүтэн дүгнэсэн. 37 дугаар тогтоол байна. Энэ дээр бид яг Ж.Галбадрах гишүүний ярьж байгаа –

- сургуулийн өмнөх боловсрол,
- ерөнхий боловсролын сургууль,
- мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчид,
- дээд боловсролын сургуулийн –

орчин дахь –

- хүрэлцээ (availability),
- хүртээмж (accessibility),
- чанар (acceptability),
- нийцтэй байдал (adaptability)
- эдийн засгийн чадвар, төлбөрийн боломжтой байдал (affordability)

гэсэн “5 Эй” гэдэг зарчмаар нь авч үзээд, тэнд дутагдаж байгаа асуудлуудыг нь, сул талыг нь, ахиц дэвшлийг нь бүгдийг нь дүгнээд Улсын Их Хурлын 37 дугаар тогтоолд оруулсан.

Тэгэхээр бид тогтоолын хэрэгжилтээ харин одоо авч хэлэлцэх ёстой байгаа юм. Засгийн газраас.

Бид өөрсдөө үнэлэхдээ Хүний эрхийн Үндэсний Комисс энэ тогтоолын хэрэгжилтийг 51 хувь гэж үнэлээд байгаа. Өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй байна гээд.

Энэ дээр ялгаж өгсөн үүргүүд байгаа. Тэр сургуулийн өмнөх хоолны мөнгө нь явж байгаа. Яг таны ярьж байгаа тэр багшийн дутагдал өөрөө явж байгаа.

Тэгээд анги, танхимын хүрэлцээ, багтаамжийн асуудал явж байгаа. Эрэгтэйчүүдийн боловсролын дутуу, хоцрогдолтой байгаа л бүгд орсон. Боловсролын салбар дахь хүний эрхийн асуудлыг иж бүрнээр нь авч үзсэн юм.

Тэгэхээр бид одоо Засгийн газраас энэ 37 дугаар тогтоолын хэрэгжилтийг харин хэлэлцэх нь илүү ач холбогдолтой. Ямар ахиц гарсан юм. Ямар ухралт байгаа юм бэ гэдгээ дүгнэх нь илүү хэрэгтэй болов уу гэдэг санал байна.

Хоёр дахь асуудал дээр, Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ. Тийм ээ. Манай Ж.Хунан гишүүн ахлаад өнгөрсөн жил хяналт шалгалт хийгээд энэ асуудлыг яг олны сонорт хүргэсэн.

Түүнээс гадна эрх бүхий байгууллагуудад нь шаардлага, зөвлөмжийг нь хүргүүлсэн юм.

Тэгэхээр энэ дээр бид зөвхөн нэг илтгэлээр хэзээ ч хязгаарладаггүй. Хүний эрхийн асуудал, зөрчил байвал өөрсдийнхөө мэдээллийн хүрээнд юм уу, эсвэл гомдлын хүрээнд, дүн шинжилгээний хүрээнд энэ дээр шаардлага, зөвлөмжийг байнга явуулдаг гэдгийг дурдъя.

**П.Ганзориг:** Ж.Галбадрах гишүүн тодруулъя.

**Ж.Галбадрах:** Тийм. Одоо ингээд 23 дээр нь бичсэн юм байна. Энэ чинь тэгээд 24, 25 дээр нь байдаггүй. Тэрийг нь одоо хэлэлцье гэдэг асуудал хэдэн жилийн дараа бичээд мартаад гарч ирж байна.

Үүнийг чинь жил болгон явах ёстой юм биш үү? Жил болгон тэр чанартай боловсролоо олж авч чадахгүй. Би тодорхой тоо хэлье л дээ.

40-өөс дээш бүлэгт сурч байгаа хүүхэд 214 мянган хүүхэд байгаа юм. Өнгөрсөн жилийн тооцоогоор. Тэр нь жоохон багассан. 200 руу орж ирсэн. Тэгвэл яасны улмаас орж ирсэн бэ гэвэл бид 108 сургууль, 95 цэцэрлэг барья гээд. Түүнээс маш удаан яваад байгаа юм. Үүнийгээ барих ёстой гэдгийг нь шаардаад явах ёстой нь Хүний эрхийн Үндэсний Комисс.

Тэгээд үүнийг нь шаардаад, шахаад, хийлгээд, Засгийн газартаа яамандаа шахаад явах ёстой юм биш үү гэдгийг. Үүнд хариулт авъя.

Нөгөө талаас стандартын асуудал.

**П.Ганзориг:** Ж.Галбадрах гишүүнд нэмэлт минут өгье.

**Ж.Галбадрах:** П.Ганзориг Байнгын хорооны даргын түрүүн хэлсэнтэй адилхан.

Жишээ нь, Цогтцэций сум. Өмнөговь аймгийн. Хичээл нь явж байгаад гэнэт сургууль нь нурсан. 1 дүгээр сургууль нь. Тэгэнгүүт тэнд байсан хүүхдүүдийг тэр 2 дугаар сургууль руу. Угаасаа тэр нь дүүрэн. Тэр хэдэн сургууль руу оруулах гээд. Тэнд ерөөсөө сургалт явагдаагүй. Юун нөгөө 30, 40-өөрөө суух нь битгий хэл бүр сургууль олдохгүй, сурч чадаагүй хэдэн ээлжид ч оруулсан юм. Ингээд явсан.

---

5 дугаар сургууль энэ хойно баригдсан. 2 жил баригдах байсан. Нөгөө барилга нь шүүхдээд бариад нөгөө барилгын комисс нь цаашаагаа яваад 6, 7 жил явахад тэнд сурч байсан хүүхдүүд талаар нэг тараад ерөөсөө сургалт олж авч чадаагүй. Энэ маш ноцтой зөрчигдөж байгаа.

Тэгээд үүнийг бид чимээгүй байсаар байгаад л тэгээд л өнгөрсөн. Тэр үед тэнд сургуульд сурч байсан хүүхдүүд хохироод өнгөрсөн.

Тэгэхээр энэ чинь хүний эрхийн маш ноцтой зөрчил. Ерөөсөө бүх юмны үндэс боловсрол байгаа.

Тэгээд чанартай боловсрол олж авах. Чанартайгаа больё. Хэвийн боловсрол олж авах нөхцөл нь бүрдээгүй зөрчигдөөд яваад байгаа асуудал дээр Та... /минут дуусав/

**П.Ганзориг:** Сургуулиудын асуудал их олон л асуудал байгаа юм шиг байна лээ.

Би сая Булган аймагт очиж ажиллахад Булган аймгийн Орхон сумын сургууль маш том цууралт өгөөд нурахад бэлэн болсон. Тэгэхдээ тэр орчинд хичээллэхээс өөр арга байхгүй гэж байгаа байхгүй юу. Багш нар нь. Маш аюултай нөхцөл байдалд орсон. Өргөдөл, гомдлыг нь би Байнгын хороо руугаа авсан. Холбогдох газар нь уламжлаад явж байгаа.

Индэр дээрээс хариулья.

**Д.Сүнжид:** Нийтдээ Хүний эрхийн Үндэсний Комисс 25 удаагийн илтгэлийг Улсын Их Хуралд хүргүүлсэн байна. Үүний 13-д нь бид сурч, боловсрох эрхийг авч үзэж байна.

Тэгээд хэн хариуцах вэ гэвэл үүнийг Засгийн газрын чиг үүрэг юм. Хариуцан хэрэгжүүлэх ёстой чиг үүрэг.

Тийм болохоор жишээлбэл, Хууль зүйн байнгын хорооноос, Улсын Их Хурлаас гарсан тогтоолын хэрэгжилтийг Их Хуралд тайлагнах үүрэгтэй. Засгийн газар. Түүнийг нь хэлэлцэх нь Их Хурлын өөрийнх нь бүрэн эрхэд байгаа.

Бид энд асуудал байна. Хүний эрх зөрчигдөж байна. Ийм шалтгаан нөхцөл байна. Залруулах ийм боломж байна гэдгийг санал болгож байгаа хөндлөнгийн байгууллага. Ийм статустай.

Тэгээд бид сурч, боловсрох эрхийг чухалд үзэж байна.

---

Ж.Галбадрах гишүүний саналтай нийлж байна. Тийм. Одоо энэ эдийн засаг, нийгэм, соёлын эрх бүгдээрээ чухал гэж үзсэн учраас бид жил дараалалд нэг нэгээр нь илтгэж байна.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх чухал уу. Чухал. Бид өнгөрсөн жил илтгэлээ сурч, боловсрох эрх чухал уу. Чухал. Тэрний өмнө жил илтгэлээ. Хөдөлмөрлөх эрхийг бид салбараар нь эмэгтэйчүүдийн, хөдөөгийнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнх... /минут дуусав/

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье. Индэр дээрээс. Та хоёр удаа тодруулсан.

**Ж.Хунан:** Ж.Галбадрах гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Түрүүн дурдсанчлан дотуур байр, ерөнхий боловсролын сургууль дахь хүний эрхийн асуудлыг бид хэдийгээр илтгэлдээ жил болгон оруулдаггүй ч гэсэн яг хяналт шалгалтын хүрээнд очсон газар болгон, өөрөөр хэлбэл аймаг, сум болгонд бид шалгах ажиллагаа явуулаад тэгээд тухай бүр нь зөвлөмж, шаардлага өгөөд явдаг гэдгийг танд хэлье.

Нөгөө талаараа Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг санаачилга бол жил болгон бид Улсын Их Хуралд өргөн барьдаг илтгэл маань тодорхой асуудлыг хөндөж байгаа учраас “хүний эрхийн үндэсний индекстэй болъё” гэдэг ажлыг эхлүүлээд явж байгаа юм.

Өөрөөр хэлбэл эрх тус бүр дээр нь шалгуур үзүүлэлтүүдийг бий болгоод, тэгээд үүнийгээ бид хэмждэг. Өөрөөр хэлбэл динамик нь. Тухайн жилдээ таны... /минут дуусав/

**П.Ганзориг:** Нэмэлт минут.

**Ж.Хунан:** Боловсрох эрхийн чиглэлээр бид ахиц гаргасан байна уу, ухралт хийсэн байна уу гээд.

Тэгээд энэ хүрээндээ жишээлбэл чухал үйл явдал, сургууль нурлаа гэхэд энэ үзүүлэлт нь тодорхой хэмжээгээр нөлөөлдөг, энэ индекс буурдаг байдлаар.

Тэгэхээр цаашдаа бид жил болгон хэмжих үү, эсвэл хоёр жилд нэг удаа байх уу гэдэг асуудал ярьж байгаа.

Тэгээд 6 сардаа бид багтаагаад энэ индекс, энэ аргачлалыг танилцуулна. Энэ хүрээндээ Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлж танилцуулах ажлыг зохион байгуулна гэдгийг нэмэлт мэдээллээр хэлье.

**П.Ганзориг:** Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

---

**Л.Мөнхбаясгалан:** Тэр тэр нурсан сургуультай тойргийн гишүүн байна. Тэгээд сургууль нурсны дараа олон л асуудал болсон.

Тэгээд Ж.Галбадрах гишүүн болон Та бүхэнд баярлалаа. Энэ асуудлыг хөндөж олны анхаарлын төвд тавьж байгаад.

Улсын Их Хурал дээр Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байгаа юм.

Тэгээд хүн амын ундны ус, хүний аюулгүй байдал, эрүүл мэндэд ноцтойгоор нөлөөлж байгаа удаа дараагийн судалгаа байна. Монгол Улс тэр чигээрээ ус нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй гээд миний судалгаан байна л даа.

Тэгэхээр манай Хүний эрхийн Үндэсний Комисс энэ бол хүний амьд явах эрх. Тийм ээ.

Энэ тал дээр хийсэн судалгаа байдаг юм уу? Байдаг бол Та бүхэн хариулж өгөөч ээ. Энэ бол ноцтой асуудал.

Дараагийн нэг асуудал. Сургууль орчмын аюулгүй байдлын тухай хууль Б.Энх-Амгалан гишүүн оруулж ирээд ярилцаж байх үед анги танхимыг будаж байгаа будагч бодист формальдегид, бензол гэдэг хүүхдийн хорт хавдар үүсгэдэг бодистой будгаар будаж хорт хавдар үүсгэж байгааг нотолсон тухай судалгаа хийсэн эрдэмтэн Улсын Их Хурал дээр хэлсэн. Би энэ хүнтэй уулзсан. Үнэхээр тийм байсан. Энэ будгуудыг Америкийн Нэгдсэн Улс, Европт хориглодог. Хятад үүнийг аль хэзээний тогтоосон.

Гэтэл манай сургууль, цэцэрлэг будсаар байгаа. Энэ тал дээр судалгаа, сануулга байгаа юу? Сая 0-ээс 5 насны хүүхдийн уушгийн өвчлөлт, сургуулийн өмнөх насны боловсролын цэцэрлэгт байна гэж сая гарлаа.

Яагаад гэвэл цонх нь онгойдоггүй. Одо манай энэ цонх ч гэсэн томоор онгойхоор бид сая гадаа дуу чимээ байгаад буцаагаад хаалаа шүү дээ. Тэгээд бүгчим байна.

Тэгээд бид нэг хүүхдээ боддоггүй, хүүхдүүдийнхээ аюул, эрүүл мэндийн асуудалд санаа зовдоггүй улс ч юм шиг. Сурах орчинд нь санаа зовдоггүй. Дээрээс нь хүн ард нь өнөөдөр уух ус нь бүсчлээд гаргасан энэ миний өмнө байгаа шинжилгээгээр чанарын шаардлага, эрүүл ахуйд нийцэхгүй гээд гарсан байхад энэ талаар ер нь юу хийж байсан?

Гурав дахь асуулт байна. Сэтгүүлч Л.Баяржаргалыг хориход хүн ёсны наад захын тусламж, үйлчилгээ, хувцсаа солих эрх олгоогүй. Ар гэртэй нь уулзах эрх олгоогүй байсан талаар би сонссон.

Тийм учраас Хүний эрхийн Үндэсний Комиссоос албан ёсоор тодруулъя.

Би гурван асуултдаа хариулт аваад нэмээд тодруулъя.

**П.Ганзориг:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос хариулъя.

**Д.Сүнжид:** Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс дахь Хүний эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд эхний сэдэв нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг авч үзсэн юм. Энд бид 4 сэдвийг хөндсөн.

- ▶ Агаарын бохирдлын асуудлыг,
- ▶ усны чанарын асуудлыг,
- ▶ хөрсний бохирдлын асуудлыг,
- ▶ Улаанбаатар хотын хэмжээний стандартын асуудлыг авч үзсэн юм.

Энэ дотор усны асуудлуудыг бид байгаа хэмжээнд нь илтгэсэн.

Өөрөөр хэлбэл тэр усны чанар, худаг. Сайжруулах ёстой ямар арга хэмжээ байгаа юм бэ гэдгийг нь Улсын Их Хурлын 2024 оны 37 тогтоолд бид санал өгсөн юм. Нэг ажил явж байгаа.

Таны хэлж байгаа үнэн.

- Устай холбоотой,
- хөрстэй холбоотой,
- агаартай холбоотой,
- дотоод орчны агаарын чанар стандарттай холбоотой –

бүгд дээр нь олон хийх ажил байна.

Тийм учраас сайжруулна гэдэг энэ саналыг нь тухайн үед өгөөд 37 дугаар тогтоол батлагдсан юм.

Хэрэгжилтийнх нь араас бид хөөцөлдсөн. Өнгөрсөн жилжингээ 37 дугаар тогтоолын биелэлтийг ирүүлээч гээд.

Түүнээс гадна 37 дугаар тогтоолд нь ороогүй зарим заалт,

- ус,
  - хөрс,
  - агаар,
  - стандарттай холбоотой –
-

бид гишүүний зөвлөмжөөр эрх бүхий байгууллага яамд тус бүрт нь хүргүүлсэн. Үүнийг хэрэгжүүлээч гээд.

Тэгээд үнэлгээг нь аваад үзэхээр хангалтгүй. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаарх бидний хүний эрхийн илтгэл, түүний мөрөөр гарсан Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг 25 хувь гэж үнэлээд байгаа. Хангалтгүй байгаа юм. Аль аль нь бүх талаар хангалтгүй.

Тэр хоёр бодис ярьж байна. Тэр бодисуудыг бид яг тусгасан.

- Гаалийн газраас,
- Стандарт, хэмжил зүйн газраас,
- боловсролын байгууллагаас–

-бид төлөөллийг оролцуулж байгаад Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс шүгэл үлээсэн. Энд бид нарт alarm, анхааруулга дохио өгөөд байхад бид хайхрахгүй байна. Ядаж 6 сар засвар үйлчилгээгээ хийх хэрэгтэй байна.

- Эрүүл мэндийн байгууллага,
- боловсролын байгууллага,
- хүн олноороо зорчдог нэг цэгийн үйлчилгээний төв зэрэг байгууллага –

дотоод агаар сэлгэлт, агаарын чанараа сайжруулах ёстой байна гээд энэ бүхнийг нь бид тэр тоотой, баримттай, кэйстэй нь оруулаад арга хэмжээ аваач ээ гэж санал болгосон гэсэн үг. Энэ 37 дээр явж байгаа нэг асуудал байгаа.

Хоёр дахь асуудал нь Л.Баяржаргалын тухайд манайд Хүний эрх хамгаалагчийн хороонд өөрөө хүсэлт, гомдлоо ирүүлсэн.

Тэгээд манайхаас 3 удаа өөртэй нь холбогдсон байна. 2 удаа 461 дээр очиж орчин, нөхцөлийнх нь талаар сонссон байна.

Ер нь өөрийнх нь тавьсан хүсэлт эм эрүүл мэндийн байдлаа бид хяналтад байлгах хүсэлтэй байна гэсэн.

Тэгээд тэрийг нь уламжлаад эмчийн хяналтад оруулаад эрүүл мэндийнх нь байдалд үзлэг, зөвлөгөө өгсөн.

Хоёр дахь нь, ер нь сэтгүүлчийн үгээ хэлсэн, үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбоотой асуудлын талаар байр сууриа илэрхийлээч ээ гэж хүссэн.

Гурав дахь тэр өөрийнх нь мөрдөн шалгагдаж байгаа асуудлын талаар Хүний эрхийн Үндэсний Комисс хуулийнхаа дагуу эрх олгогдоогүй байдаг юм гэдгийг нь тайлбарласан.

**П.Ганзориг:** Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

**Л.Мөнхбаясгалан:** Сургуулийн өмнөх цэцэрлэг, тэгээд ерөнхий боловсролын сургуулийн анги, танхимыг будаж байгаа будагч бодист –

- хорт хавдар үүсгэдэг бодис ороод байгаа нь тогтоогдсон.
- Үүгээр будаад байгаа нь тогтоогдсон.
- Стандарт нь байдаг.
- Манай улсад байдаггүй стандарт биш.
- Үүнийг оруулж болохгүй гээд стандарт нь байдаг. Хэрэгждэггүй.

- ◆ Үүнийг Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээд байдаг.
- ◆ Бид мэдээд байдаг.
- ◆ Сайд нь мэдээд байдаг.

Улсын Их Хурлын тогтоол гарч байсан уу? Энэ чиглэлээр.

Одоо Сургууль орчмын аюулгүй байдлын тухай хуульд үүнийг яаж эвтэйхэн зохицуулах талаар оруулаач гэж сайдаас хүссэн. Сайд ажлын хэсэг гаргаад ахлаад ажиллаж байгаа гэсэн. Гэхдээ бид үүнийг аймаар хорт хавдар яриад үүнийг орхиод байж болмооргүй байгаа юм.

Одоо надад чинь нэгхэн л минут байгаа юу? Тийм ээ. Байгаа юу? Тийм ээ.

Монгол орны ундны усны чанарын үзүүлэлтийг зүгээр... /минут дуусав/

**П.Ганзориг:** Л.Мөнхбаясгалан гишүүнд нэмэлт 1 минут өгье.

**Л.Мөнхбаясгалан:**

- Хангайн бүсэд усных нь 65 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй,
- төвийн бүс 48 хувь,
- зүүн бүс 75 хувь,
- говийн бүс 86 хувь,
- баруун бүс 68 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангадаггүй юм.

Тэгэхээр бид Төрийн ордонд 6 сарын 04-нд “Усны эрүүл ахуйн үндэсний аюулгүй байдал” гэсэн бодлогын хэлэлцүүлэг хийж байгаа.

Энэ дээр би Хүний эрхийн Үндэсний Комиссоос 37 дугаар тогтоолынхоо хэрэгжилтийн талаар 23 дахь илтгэлдээ усны чанар, эрүүл мэндийн талаар оруулсан илтгэлээ авчирч тавихыг урьж байна. Баярлалаа.

**П.Ганзориг:** М.Нарантуяа-Нара гишүүн асуулт асууя.

---

### **М.Нарантуяа-Нара:** Өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр илтгэлдээ ялангуяа хүүхдийн хэсэгтэй нэлээн сайн танилцлаа. Хүүхэд хамгааллын тухай хууль бол Монгол Улсад анх удаагаа шат шатад хүүхэд, гэр бүл, нийгмийн ажилтан ажиллах эрх зүйн орчин бүрдсэн, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлого анхан шатад хүргэж хэрэгжилтийг хангахад чиглэсэн ач холбогдолтой зохицуулалт болжээ гээд тэмдэглэсэн байна.

Тэгээд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.6, 36.7-г үндэслээд сум хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалаар улсын хэмжээнд 833 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулахаар орон тоо баталснаас энд 753 нийгмийн ажилтан ажиллаж байгаа гэж ойлгож байна.

Тэгэхээр Монгол Улсын сум бүрт ямар ч л байсан нэг нэг нийгмийн ажилтан байна гэсэн үг мөн үү? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал нь, түрүүн Т.Мөнхсайхан гишүүн өсвөр насны охидын жирэмслэлтийн асуудал давхацсан учраас үүнийг болиод шууд гуравдугаар асуудалдаа оръё.

Гуравдугаар асуудал нь, одоо жишээлбэл –

- бүх сумд нийгмийн ажилтан байгаа гэж ойлгож болох уу?
- Бүх суманд байгаа бол Булган аймгийн Хишиг-Өндөр сумд нийгмийн ажилтан байгаа юу?

Миний санахаар мэдээж хүүхэд, гэр бүлийн орчиндоо, гэрийнхээ орчиндоо хаалганы цаана ямар хүчирхийлэлд өртөж байгааг тэр бүрчлэн шалгаж, хянаж, урьдчилан сэргийлэх боломж хомс гэдгийг би маш сайн ойлгож байна.

Гэхдээ нийгмийн ажилтан тухайн сум, орон нутагтаа хүүхэд эрсдэж болохуйц ямар нэгэн олон нийтийн үйл ажиллагаа болж байгаа зүйл дээр тулж очиж ажиллаж, урьдчилан эрсдэлийг үнэлж, ингэх ёстой юм шиг санагдаад байх юм.

Дөнгөж саяхан 4 сарын 19 байна уу, дөнгөж 4 сарын 16-ны үеэр 5 сарын 01-нээс уралдааны цагийг нээсэн байгаа шүү дээ.

Гэтэл 4 сарын 16, 19-ний үед Булган аймгийн Хишиг-Өндөр сумд Засаг дарга нь хэлж сануулсаар байхад морин уралдааны сунгаа ч юм уу, юу гэдэг гэнэ үү. Нэг тийм юм болоод түүн дээр асран хамгаалах хүн, хараа хяналт муутай

айлын дөнгөж 4 нас гараад явж байсан бага насны хүүхдийг морин дээр хүлээд уралдуулсан байгаа шүү дээ.

Энэ хүүхэд одоо Эх нялхсын эмнэлэгт үхлүүт байгаа. Эх нялхсын захирал эмч хэлэхдээ энэ хүүхэд ер нь босож чадахгүй. Тухайн зөвшөөрөлгүй уралдааныг зохион байгуулсан уяач нарын зүгээс... /минут дуусав/

**П.Ганзориг:** Нэмэлт 1 минут өгье.

**М.Нарантуяа-Нара:** ... гэж байгаа юм байна. Гэсэн ч энэ хүүхэд ямар ч босох найдвар байхгүй дээ гэж байгаа юм.

Энэ хүүхдийн талаар Та бүхэнд яам, нийгмийн ажилтан мэдэгдээд, арга хэмжээ аваад, одоо энэ хүүхдийн байр байдлыг судлаад харж хандаад явж байгаа хүн байна уу?

Зургийг нь Та бүхэнд харуулъя. Энэ хүүхэд ингээд үхлүүд байж байна шүү дээ.

Тэгээд ард түмэн, иргэд, олон нийтийн татварын мөнгө урсаад байдаг. Нийгмийн хамгааллын яам, Хүний эрхийн Үндэсний Комисс, хүүхэд хамгааллын байгууллага гээд татвар төлөгчдийн бүх мөнгөнөөс хуваарилаад байгаа шүү дээ.

Тэгээд байж байхад энэ хэмжээнд ажиллаж байна гэдэг бол энэ бол мөнгө дэмий урсаад байна л гэсэн үг байгаа биш үү.

Одоо энэ хүүхдийн яг тулгамдсан асуудлыг би ярьж байна. Эндээс та нар мэдсэн хүн байна уу? Аль аль нь энэ хүүхэд дээр ямар арга хэмжээ хараа хяналт... /минут дуусав/

**П.Ганзориг:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос хариулъя.

**Ж.Хунан:** М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс энэ удаагийн илтгэлдээ хүүхэд хамгааллын тогтолцооны нэгжүүдийн үйл ажиллагаатай холбоотой үнэлгээг өгч ажилласан.

Энэ хүрээнд таны түрүүний хөндсөн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан гээд шинээр бий болсон нийгмийн ажилтны үйл ажиллагаанд үнэлгээ өгч ажилласан.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар сум хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар 753 хүн ажиллаж байгаа. 60 хүний орон тоо дутуу байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл сум болгонд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллаж байгаа гэсэн мэдээллийг танд өгье.

Гэхдээ Булган аймгийн Хишиг-Өндөр гэсэн үү? Тийм ээ. Тийм. Хишиг-Өндөр суманд хэрвээ энэ хүн байхгүй байгаа бол бас ямар нэгэн шалтгааны улмаас ажиллаагүй байхыг үгүйсгэхгүй.

Тэгэхдээ яг одоогийн бодит мэдээллийг Гэр бүл, хөгжил хамгааллын газраас өгөх байх гэж бодож байна.

Тэгээд энэ анхан шатны нэгж дээр хүүхэд хамгааллын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гол субъект бол гэр бүл, хүүхэд, нийгмийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан байгаа.

Таны хэлсэн гэр бүлээр орж нөхцөл байдлын үнэлгээг хийдэг, эрсдэлийг эрт илрүүлдэг, холбогдох арга хэмжээг авдаг, холбон зуучилдаг чиг үүргийг хэрэгжүүлдэг ийм нэгж.

Гэхдээ асуудалтай зүйлүүд байна. Хэдийгээр энэ чинь байгуулагдаад үйл ажиллагаагаа явуулаад удаагүй байгаа ч гэсэн 172 хүн анх томилогдсоноос хойш чөлөөлөгдсөн байгаа.

Тэгэхээр энэ ачаалал маш өндөр байгаагийн нэг илрэл байна.

Дээрээс нь мэргэшсэн, бэлтгэгдсэн байдал нь хангалтгүй байсан улмаас ажлаасаа чөлөөлөгдсөн.

Гуравт, ажиллах орчин бүрэн бүрдээгүй гэдэг.

Өөрөөр хэлбэл айл өрхөөр явахад тогтмол халдлагад өртдөг. Шөнө орой халдлагад өртөх, заналхийлэлд өртөх, нохой шувуунд хазуулах, дайруулах асуудлууд байна гэдэг дүгнэлтийг комисс хийсэн байгаа.

Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутаг дэвсгэр дээр болсон харамсалтай үйл явдалтай холбоотойгоор Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээллийг авсан.

Мөн ялгаа байхгүй олон нийтийн сүлжээнээс энэ талаар мэдээллийг авсан. Шалгах ажиллагааг явуулж байгаа.

Хурдан морь хориглосон хугацаанд хүүхдээр унуулж уралдуулсантай холбоотойгоор Хүний эрхийн Үндэсний Комисс өнгөрсөн хугацаанд 3 шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Булган аймгийн Засаг даргын хувьд яг энэ хориглосон хугацаанд хүүхдээр хурдан морь унуулсантай холбоотойгоор шаардлагыг хүргүүлнэ. Бэлдэж байна.

Яг хүүхэд бэртсэн асуудлаар цагдаагийн байгууллага шалгах ажиллагаа явуулж байгаа учраас энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс хөндлөнгөөс оролцох боломжгүй. Гэхдээ холбогдох байгууллагуудаас мэдээллийг аваад энэ дээр дүн шинжилгээ хийж байгаа. Энэ асуудлаар зөвлөмж, шаардлага гаргана гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

**П.Ганзориг:** Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас нэмэлтээр хариулъя.

**Л.Бадамцэцэг:** Булган аймгийн Хишиг-Өндөр суманд Н.Оюунбаяр гэдэг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллаж байгаа. Анх томилогдсон цагаасаа эхлээд одоо болтол ажиллаж байна.

5 настай хүүхэд гэдэг ер нь хурдан морийг яг хуулиар 8 нас бүрэн хүрсэн хүүхэд унах ёстой. Яг энэ стандарт, яг энэ хуулийг бид хууль дээр хяналт тавиад явдаг.

5 настай хүүхдийн тухайд яалт ч үгүй л эцэг, эхийн хараа хяналтгүй, өрх толгойлсон ээжийн том хүүхэд. Тэгээд өөрийнхөө ээж дээр суманд аваачсан. Ээж нь Улаанбаатар хотод байдаг.

4 сарын 18 гэдэг Засгийн газрын тогтоолоор хурдан морь унах, морины ажилд хүүхдийг оролцуулахыг хориглосон хугацаа.

Яг энэ хориглосон хугацаанд Морин спорт, уяачдын холбоо ерөөсөө ямар ч уралдаан, үсэргээ, сунгааг зохион байгуулаагүй... /минут дуусав/

**П.Ганзориг:** Индэрт нэмэлт минут өгье.

**Л.Бадамцэцэг:** Хууль бус. Тийм ээ. Уяачид хоорондоо нэгдээд дундаасаа бооцоо гаргаад уралдаан, үсэргээ зохион байгуулдаг.

Тэгээд энэ бол Булганы Хишиг-Өндөрт 4 сарын 18-ны өдөр хэсэг уяачид нийлээд бооцоот уралдаан зарлах гэж байсан. Засаг даргаасаа зөвшөөрөл аваагүй. Энэ мэдээллийг авангуутаа манай Булган аймгийн Хишиг-Өндөр сумын хамтарсан баг, Засаг дарга нь уралдааныг хориглосон.

Тэгээд яг энэ үед 5 настай хүүхдийг, тэгээд уяачид хоорондоо энэ хүүхдийг дамжуулсан байгаа байхгүй юу.

Тэгээд ерөөсөө яг энэ мэдээллийг хүүхэд бэртэж гэмтсэн яг тэр цаг мөчид Булган аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас Ерөнхий газартаа мэдээллийг өгсөн.

Тэгээд тэр шөнөдөө Булган аймгаас хүүхэд тээвэрлэгдэж ирсэн. Уяач өөрөө аваад, эмээг нь аваад, бусад хамаатан садныг нь аваад хүүхэд... /минут дуусав/

**П.Ганзориг:** Нэг талаас нь бид анхаарах ёстой зүйл. Энэ хориглосон хугацаанд Засгийн газраас гарсан тэр шийдвэрийг хэрэгжүүлэх ёстой субъект чинь өөрөө аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга нар шүү дээ.

Тэд нар нь юу хийж байсан юм? Хүний эрхийн Үндэсний Комиссын төлөөлөгч, нийгмийн ажилтан байгаа. Тэгэхдээ бүхэл бүтэн аймгийн Засаг дарга дээрээ доороо агентлагтай шүү дээ. Аймаг болгон дээр. Энэ хараа хяналтаа, хариуцлагаа аймгийн Засаг дарга нь анхаараад явж байх ёстой.

Тэгэхээр Их Хурлын гишүүд ч гэсэн аймгийн Засаг дарга нар дээр Засгийн газраас өгөгдсөн үүрэг байгаа шүү дээ.

Энд нь илүү шаардлага тавьж ажиллах нь зүй зохистой болов уу гэж бодож байна. М.Нарантуяа-Нара гишүүн тодруулъя.

**М.Нарантуяа-Нара:** Тэгээд их харамсалтай байгаа юм л даа.

Одоо энэ төсөв мөнгө, энэ бүх асуудлыг чинь аль болох урьдчилан сэргийлээд, аль болох хүүхэд, аль болох хүний эрх зөргүй байх талаас зохицуулах гэж л энэ мөнгөнүүдийг ер нь тавьж байгаа шүү дээ.

Тэгээд Засаг дарга нь хориглосон юм бол Засаг дарга нь нийгмийн ажилтандаа хэлээд, нийгмийн ажилтан нь уралдаан болох газарт нь очоод зогсож байх ёстой байдаг биш юм уу? Хүүхэд үхлүүд болсон хойно нь ард нь очоод, тэгээд энэ хэргийн араас нь хөөнө гэдэг чинь яг бид нарын, одоо жишээлбэл Хүүхэд хамгааллын тухай хууль чинь араас нь хөөе гэсэн ажил биш шүү дээ.

Энэ хууль чинь өөрөө урьдчилан сэргийлэх дээр илүү чиглэж байгаа ажил. Гэхдээ би үүнийг Та бүхнийг шууд буруутгаж байгаа юм биш. Тэрийг ойлгоорой.

Жишээлбэл, Засгийн газрын тогтоол гараад үүнийг хэрэгжүүлэхгүй юм бол тогтоол гарч яах юм. Тогтоолыг шат шатандаа хэрэгжүүлэх ажлыг Засгийн газар ч гэсэн анхаармаар байна. Өдөр болгон л тогтоол гаргаад л байдаг. Нөгөөдөх нь хэрэгждэггүй.

**П.Ганзориг:** О.Батнайрамдал гишүүн асуулт асууя.

**О.Батнайрамдал:** Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 25 дугаар илтгэл 600 хуудас гаруй том илтгэл байна.

Нэг зүйл байгаа юм. Би асуултаа асуугаад явъя. Бүгдээрээ жоохон чимээгүй болох уу.

602 дугаар хуудас. Хүний эрхийн комиссоос зөвлөмж гаргахад хариу ирүүлээгүй байгууллагууд.

6 байгууллага байна. Бүгд Боловсролын яамтай холбоотой. Зургуулаа.

С.Зулпхар гишүүн ээ, би асуултаа асууя. Тэгэх үү?

Зургуулаа –

- Боловсролын яамтай холбоотой,
- Боловсролын зээлийн сантай холбоотой,
- нийгмийн ажилтантай холбоотой.

Уралдаант хүүхдүүдийн талаар. Боловсролын яам яадаг юм. Хариу өгдөггүй юм уу?

Эндээс ямар дүгнэлт хийж болох вэ гэхээр хамгийн их хүний эрх зөрчигдөж байгаа газар чинь Боловсролын яам биш шүү. Яагаад Боловсролын яам хариу өгдөггүй юм.

Энэ дээр Л.Энх-Амгалан сайд. Энэ болсон зүйлүүд Л.Энх-Амгалан сайд томилогдохоос өмнө.

Тэгэхээр Л.Энх-Амгалан сайдад хандаж хэлмээр байгаа юм. Энэ хариу өгөөгүй албан тоотуудыг яаралтай та хариу болгож өгнө үү. Хамгийн их нь “Боловсролын зээлийн сан” дээр байна.

Хоёрдугаарт, хамгийн гол нь Хүний эрхийн комисс ажиллаад байдаг, ажиллаад байдаг. Тэндээс үр дүн гарч байна уу? Ерөөсөө бид үр дүн л харах ёстой.

607 дугаар хуудас. Комиссын гишүүдийн шаардлагыг хэрэгжилтээр нь аваад үзэхээр ер нь бүгд л өөрийгөө өндөр дүгнэсэн байна даа. 79, 84, 100 хувийн хэрэгжилттэй гээд.

Ер нь бид чинь тэгвэл асуудлаа бүгдийг нь шийдсэн юм биш үү. 100 хувийн хэрэгжилттэй юм байна шүү дээ.

Нэг асуулт байгаа юм.

→ Тухайн байгууллага нь гомдол гаргахад хариу ирүүлэнгүүт тэрийг 100 хувь хэрэгжсэнд тооцоод байна уу?

→ Үнэхээр тэр хүний гомдол эсрэгээрээ бүгд 100 хувь шийдэгдсэнийг бид хэрэгжилт гэж үнэлж байгаа юу?

Албан тоотын хариулт ирэхэд бид хэрэгжилтийг хэрэгжилт гэж үзмээргүй байгаа юм.

→ Яг тухайн хүний асуудал шийдэгдсэн үү?  
→ Хүний эрхлэлийн зөрчил нь арилсан гэж үзэж Та бүхэн хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлж байгаа юу?

**П.Ганзориг:** Эхлээд Хүний эрхийн Үндэсний Комисс хариулъя. Тэгээд Боловсролын яам.

**Д.Сүнжид:** О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

2025 оны байдлаар зөвлөмж, шаардлага нийлээд 101 явсан.

Тэгээд үүн дээр тусгасан асуудлуудад бид нэг зөвлөмж дээр 4 асуудал тусгадаг. Эсвэл 5, 10 гээд. Тийм ээ. Тэгээд нийлээд бүгдийг нь тус тусад нь үнэлдэг. Нэг зөвлөмжийг бүхэлд нь биш. Зөвлөмжийн –

- хөдөлмөрлөх эрх нь,
- хариуцлага тооцсон нь,
- сургалт хийсэн нь ч гэдэг юм уу. Тийм ээ.

Бүгдийг нь үнэлээд энэ бүгд хэрэгжсэн байдлыг нь л хувиар илэрхийлж байгаа байдал нь энэ юм.

Өмнөх жилүүдэд бид ярьдаг байлаа.

Ингээд хугацаа хоцроож ирүүлж байгаа асуудал, үзэгдэл тасрахгүй байна. Хугацаа хэтрүүлж байна. Бид нарт 60 хоног байгаа. Хуулиар. 60 хүртэл хоногийн хугацаанд зөвлөмж, шаардлагын хариу ирүүлэх ёстой.

Хэрвээ нэн яаралтай эрүүл мэнд, амь насны асуудал яригдаж байвал бид 5, 1 хоногийн ч хугацаа өгдөг.

Энэ хугацаанд бид нарт хариу ирүүлэх ёстой. Хугацаа хэтрүүлдэг байдал нэгдүгээрт тасрахгүй даамжирч байгаа байдал байна. Тэгэхдээ ирүүлж байна. Тийм ээ.

Хоёрт, хариуцлага тооцох асуудал дээр 22 албан тушаалтанд хариуцлага тооцон, 1 хүнд хариуцлага тооцоогүй асуудал одоо явж байгаа. Шүүхээр явж байгаа 1 асуудал байгаа.

Энэ хүртэлх хугацаанд юу болсон бэ гэхээр Хууль зүйн байнгын хороон дээр хамтраад бид хэлэлцүүлэг хийсэн. Зөвлөмж, шаардлагын биелэлт ямар ямар байгаа вэ, ямар байгууллага биелүүлэхгүй байгаа вэ гэдэг асуудлыг нэг ярьсан.

Хоёрдугаарт, бид зөвлөмж, шаардлагаа явуулахдаа заавал хоёр зүйлийг нэхдэг болсон. Нотлох баримтыг ирүүлээч ээ гэж.

Зүгээр ер нь тайлбар ирүүлээч ээ гэхээр –

- хийж байна,
- хийх гэж байна,
- төлөвлөж байна –

гэдэг тийм хариулт ирүүлэх гээд байдаг учраас бид яг юу хийсэн бэ, нотлох баримтаа, гарсан шийдвэр, төлөвлөгөө, шийдсэн асуудлыг хамт ирүүлнэ үү гэдэг ийм байдлаар дүгнэж байгаа гэдгээ танилцуулъя.

**П.Ганзориг:** Боловсролын яамнаас нэмж хариуля.

**М.Бадамжав:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Боловсролын яам М.Бадамжав.

**О.Батнайрамдал** гишүүний асуултад хариуля.

Хүний эрхийн комиссоос өгсөн зөвлөмжийн хариуг манай яамнаас тодорхой хугацаа хоцорч өгсөн байгаа. Хариуг нь. Тухайлбал, сургуулийн орчинд нэгдсэн журмаар олныг хамарсан эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, ялангуяа хувь хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой үзлэгийг таслан зогсоох бүх шатны байгууллагад үүрэг чиглэл өгч, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах гэх мэт 2025 оны 01 сарын 16-ны 03 дроб 02 гэсэн албан бичиг. Бид 6 сард хариуг нь өгсөн.

Тэгээд энэ ямар шалтгаантай вэ гэхээр энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг хангаад тодорхой ажлууд, арга хэмжээг зохион байгуулаад эргээд түүнийхээ үр дүнг тайлагнах, хэрэгжилтийг хангах хүрээнд тайланг нь хүргүүлэхэд хугацаа алдсан асуудал байгаа.

**П.Ганзориг:** О.Батнайрамдал гишүүн тодрууля. Минутдаа багтаагаад тодорхой хариулна шүү.

**О.Батнайрамдал:** Тэгэхээр хар даа. Ийм л байна л даа.

Хариу ирүүлээгүй байгууллага албан тушаалтан нь ерөөсөө 6-хан байгууллага байгаа байхгүй юу. Бүгд боловсролын яамтай холбоотой.

---

Тэгэхээр ийм байж болохгүй. Хүний эрх хамгаалагдах ёстой. Тэр дундаа хүүхдүүдийн эрх хөндөгдөж байгаа үед хамгийн түрүүнд хуулийн хугацаандаа хариулах ёстой байхгүй юу. Ийм байж болохгүй. Үүнийг Л.Энх-Амгалан сайд аа, шийдээсэй гэж бодож байна. Л.Энх-Амгалан сайд хурдтай ажилладаг. Энэ дээрээ бас яг тэр хурдаа гаргах хэрэгтэй.

Хоёрдугаарт, Хүний эрхийн комисс хариулж байна л даа. Хүний эрхийн комисс ажлаа хийдэг юм байна лээ. Би ч гэсэн Улсын Их Хурлын гишүүний хувьд Оюу Толгойн сонсголын үеэр Хүний эрхийн комисст би хүний эрхийн хувьд хандсан. Хүний эрхийн комисс тэр доор нь хариу авсан боловч бусад байгууллагуудаас нь хариу ирээгүй л дээ. Одоо ч ирээгүй.

Тэгэхээр албан тоотын хариу ирлээ гээд хэрэгжилт биш. Яг үнэн. Нотлох баримтыг нь авах ёстой. Нотлох баримтыг нь дүгнэж буцаад бид тэр нотлох баримт дээр үндэслэж дүгнэлтээ энэ дээр... /минут дуусав/

**П.Ганзориг:** О.Батнайрамдал гишүүн үг хэллээ. Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүд байна уу? О.Батнайрамдал гишүүнээр тасаллаа.

А.Ариунзаяа гишүүн асуулт асууя.

**А.Ариунзаяа:** Надад нэг санал байгаа юм. Санал юу вэ гэхээр 24 дүгээр илтгэлийн дагуу гарсан Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн араас яг манай Байнгын хороонд харьяалагдах асуудлыг авч үзэж араас нь явах шаардлагатай гэж үзэж байна.

Жил болгон зузаан зузаан илтгэл гаргаад, тэр нь ямар ч үр дүнгүй байж болохгүй.

Хоёр дахь нь, хүүхдийн амьд явах эрхийг хөндөж тавиач гэдэг хүсэлтийг хэвээрээ дахиад гаргаж байна.

Хүний эрхийн комисс энэ илтгэлээ жил болгон өөр өөр сэдвээр явмааргүй байна. Өмнөх жилийн яг энэ хүний эрхийн талаар Үндсэн хуулиар заагдсан байгаа ердийн байх ёстой тэр эрх нь хангагдаж байгаа эсэх талаар жил бүрийн ажил нь сайжраад байгаа юм уу, муудаад байгаа юм уу гэдгийг үнэлэхийн тулд жил бүрийн үнэлгээ хэрэгтэй байгаа байхгүй юу.

Тэгэхээр наад захын ойлгомжтой асуудлуудыг тоон мэдээллээр нь дүгнэмээр байна. Тэгэхгүй бол жил болгон ийш тийшээгээ савчаад, сүүлдээ бүр төрийн албан хаагчдын цалин хөлсний асуудлыг яримааргүй байгаа байхгүй юу даа. Би гуяа.

---

Тэгээд хүний эрхийн асуудлаар. Энэ хүүхдийн амьд явах эрхийг яагаад яриач гээд байгаа юм бэ гэхээр би гэмтлийн гаргасан эмхэтгэлийг өнгөрсөн жил аваад. Энэ сүүлийн 5 жилээр нь гаргасан байгаа. 2019-2023 оны хооронд осол, гэмтэлд эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн осол, мэдээллийн талаар.

Тэгээд үүн дээр юу байна вэ гэхээр осол, гэмтлийн шалтгаант хүүхдийн өвчлөл 2019-2023 онд нийтдээ 323 мянга 340 эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн. Бүртгэгдээгүй хэд байгаа бол доо. Тийм ээ.

Том хүнийх болохоор 844 мянга байхгүй юу.

эгэхээр нэг жилд 65 мянган хүүхэд осол, гэмтлийн шалтгааны улмаас эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдэж байгаа.

Тэгвэл осол, гэмтлийн шалтгааны улмаас нас баралт 2019-2023 онд нийтдээ 1621 хүүхэд нас барсан. Эдгээрээс 1000 гаруй хүүхэд нь эрэгтэй хүүхэд байна. 60 хувь нь эрэгтэй хүүхэд байна.

Үүнийг жилд буулгах юм бол жилд 350 орчим хүүхэд осол, гэмтлийн шалтгааны улмаас нас барж байгаа байхгүй юу. Энэ дотроо томчуудын буруу юу байна вэ гэдгийг бид харах ёстой.

- Зам тээврийн осол байгаа юм уу.
- Давтамжтай ослууд байгаа юм уу.
- Явган явж байгаад осолд өртөөд байгаа юм уу.

- Хүчирхийллийн шалтгаант өвчлөл нь бас тусдаа байгаа шүү.

Хүчирхийллийн шалтгаант өвчлөл 2019-2023 оны хувьд нийт 83 мянган хүн эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн.

→ Бүртгэгдээгүй цаана нь хэд байгаа бол оо? Үүний –

- 60 мянга нь эрэгтэйчүүд,
- 20 мянга нь эмэгтэйчүүд.

Эдгээрийн жилд 1500 хүүхэд хүчирхийллийн шалтгааны улмаас гэмтээд эрүүл мэндийн байгууллагад хандаж байгаа.

→ Эрүүл мэндийн байгууллагад хандаагүй хэчнээн хүүхэд хүчирхийллийн улмаас гэмтэж байгаа бол оо?

Ийм л асуудлыг бид ярих ёстой байхгүй юу.

Тэгээд үүндээ суурилж бодлого маань ч гэсэн явах ёстой юм.

Тэгэхээр хүүхдийн амьд явах эрхийг бид хангаж чадаж байна уу, үгүй юу гэдгийг л ярих ёстой болохоос биш байдлаар Та хэдийн оруулсан илтгэл шиг. Уучлаарай. Энэ жилийнхийг би үнэхээр жоохон чамлаж байна.

Ирэх оныхыг үнэхээрийн хүүхдүүдийн амьд явах эрх, хүмүүсээ ч гэсэн амьд явах эрх хангагдаж байна уу, үгүй юу гэдэг дээрээ л анхаарч, бид юу буруу хийгээд байна уу. Энэ зөвхөн төр засгийн асуудал биш шүү дээ. Томчууд, ер нь Монгол Улсын иргэн бүр юу буруу хийгээд байна вэ гэдгийгээ нэг анхаарч ярихгүй болохгүй нь гэсэн л ийм байр суурийг илэрхийлж байна. Баярлалаа.

**П.Ганзориг:** О.Саранчулуун гишүүн үг хэлье.

**О.Саранчулуун:** Баярлалаа. Хүний хөгжлийн илтгэлтэй ерөнхийдөө бүхэлд нь танилцаад доторх гаргаж байгаа дүгнэлтүүдийг харахаар –

- хууль хэрэгжихгүй байна;
- бүтэц хоорондын уялдаа огт байхгүй;
- төсөв нь зорилтод бүлэгтээ хүрээгүй;
- хяналт байхгүй;
- стандарт мөрдүүлэх механизм огт ажилладаггүй;
- салбарууд нь хариуцлагаа бие бие рүүгээ шилжүүлдэг –

-системийн доголдлууд байгаа гэдгийг л ерөнхийдөө харж байна л даа.

Тэгэхээр би эндээс зөвхөн хүүхдийн амь нас, эрүүл мэндтэй холбоотой асуудал, хүртээмжийн асуудлыг нь түүж харлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлыг түүж харлаа.

Бид хүн амыг “эрсдэлт бүлэг” гэж нэрлэдэг. Тэр нэрээр олон хүмүүс ярьж байгаа. Одоо бид ер нь дахиад нэг шинэ нэршил нэмье дээ. “Давхар эрсдэлт” бүлэг гэж гаргая даа.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орно.
- Бага орлоготой ахмадууд орно.
- Өнчин өрөөсөн хүүхдүүд, хараа хяналтгүй хүүхдүүд тэр бүлэгт чинь орно.

Тэгээд бүгдээрээ нэг тогтолцоо ярья. Тэгэх үү. Эхний эрсдэлд орсон байгаа хүмүүсээ хоёр дахь эрсдэлээс яаж хамгаалах вэ гэдгийг ярья.

Яагаад гэвэл нийгмийн халамжийн зарцуулж байгаа төсөв чинь анхны эрсдэлд орсных нь дараа нэг мөнгө өгч аргацаагаад, өөрөө учраа ол гэдэг ийм л

тогтолцоо. Мөнгөн үйлчилгээ л яваад байгаа байхгүй юу. Тэгээд дараа нь яах вэ гэдэг юм огт байхгүй байгаа.

Би сая хүүхдийг хүлээд морин дээр уралдуулсан тухай кэйс сонслоо. Би зөв сонссон уу? Тийм ээ. Би үүнийг зөв сонссон гэж ойлголоо.

Тэгээд нэг хүүхдийг уяачид дамжуулаад бүр морио унуулсан гэдэг кэйс сонслоо.

Дэлхий дээр алдартай нөгөө Эфштэйн (Jeffrey Epstein) цаашаа юм биш үү. Манай энэ хэргийг хийсэн нөгөө уяач нар чинь. Хүүхдийн амь насаар наадаж байгаа гэдэг чинь бараг юун Эбштейн, юун нөгөө сериал киллерүүд вэ. Ингэж зугаацдаг.

Тэгээд дээрээс нь нийгмийн ажилтны тухай асууж байна л даа. Нийгмийн ажилтны үгэнд ордог уяачид байдаг уу? Тийм ээ. Сургуулийн нийгмийн ажилтан юу хийх юм бэ? Гар хоосон тэр хүн яах юм? Мөнгөтэй хөрөнгөтэй Засаг дарга нь өөрөө уяач байвал тэр хүн яах вэ? Тэр хүний өөдөөс. Тэгээд хууль тогтоомж зөрчөөд.

- ▷ Нэгдүгээрт, хууль зөрчиж байгаа юм.
- ▷ Хоёрдугаарт, хүүхдийн амьд явах эрхээр наадаж байна шүү дээ.

Энэ дээр үнэхээр харамсалтай байна.

Одоо би хүүхдийнхээ амь насыг хамгаалаач гэж яримаар байхад, одоо битгий зугаа цэнгэлээ хэтрүүлээч гэж ярих ёстой юм уу, хаашаа юм.

Ийм тайлантай, ийм мэдээлэл сонсож байна. Маш харамсалтай байна.

Дараагийн асуудал нь, “хүртээмж”, “хөгжлийн бэрхшээлтэй хүн”-ий асуудлууд байгаа. Бүх газар хүртээмжгүй байна гэдэг тайланг сонслоо.

Эрүүл мэндийн хүртээмж байхгүй юм байна. Байнгын хэрэглээтэй эмийг авах хэрэгтэй. Нөгөө давхар эрсдэлтэй хүн чинь унаж татдаг болохоор эмээ авах гэж бөөн юм болж байна шүү дээ.

Зарим эм нь хотод байхгүй, хөдөө байхгүй. Эмээс эмийн хооронд эм нь таслахаар энд тэнд ухаан алдаад унана. Ухаан алдаж унахаараа дахиад хүчирхийлэлд өртөнө. Хулгайд өртөнө. Давхар эрсдэлтэй байхгүй юу.

Тэгэхээр энэ юмныхаа араас үргэлжилж явсан ажлыг л хиймээр байгаа байхгүй юу.

Тэгээд би энэ дээр үнэхээр харамсалтай байна. Ялангуяа өндөр эрсдэлтэй байгаа –

- хүүхдүүдийн асуудал,
- хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал,
- ахмадуудын асуудлаар тун бага байна.

Тэгээд хоёр, гурван жилийн өмнө гарсан тайлангийн мөрөөр эргээд яасан бэ гэдэг дээр дахиад байхгүй. Өөр чиглэлээр ороод ирэхээр юм юмнаас амсуулсан богинохон богинохон агуулгатай байхаар араас нь ямар тогтоол, зөвлөмж өгөх вэ. Байнгын хорооны зүгээс яах вэ. Гишүүд энэ дээр яаж ажиллах вэ гэдэг дээр өшөө жоохон үргэлжлүүлж тайлан мэдээллээр хангасан ийм ажил болгомоор байна. Ийм саналтай байна.

**П.Ганзориг:** О.Батнайрамдал гишүүн үг хэлье.

**О.Батнайрамдал:** Хүний эрхийн Үндэсний Комиссоос гомдол гарсан бол тэр 100 хувь хэрэгжиж байх ёстой.

Хүний эрхийн Үндэсний Комисс тэр кэйс дээр ажиллахад мэргэжлийн олон юм хийдэг юм билээ. Энэ хэрэгжихгүй бол хариуцлагын асуудал яригдах ёстой л байхгүй юу.

Өнөөдөр хариу ирүүлээгүй байгууллага гээд жагсаалт дараагийн илтгэл дээр баймааргүй байгаа юм.

6 байгууллага дурдсан. Бүгд боловсролын салбартай холбоотой.

- Боловсролын сайд,
- Боловсролын ерөнхий газар,
- Монгол Улсын Их Сургууль,
- Монголын Үндэсний их сургууль,
- Дорноговь аймгийн Засаг дарга –

дотор яг л нөгөө л нэг нийгмийн ажилтан, уралдаант хүүхдүүдтэй холбоотой асуудал.

Энэ дээр хэрвээ хууль зөрчиж байгаа бол хуулийн хариуцлага хүлээх ёстой шүү дээ.

Хариуцлагын асуудал явсан уу. Энэ чинь хүний эрх зөрчигдөж байна. Тэр дундаа боловсролын салбар дээр дандаа хүүхдүүдийн эрх зөрчигдөж байгаа шүү.

Хэрэгжилт нь гээд нэг албан тоот явуулахаар, тэрийг нь авмааргүй байна. Тэр зөв. Нотлох баримтыг нь авах ёстой. Хэрвээ хэрэгжүүлэхгүй байгууллага байх юм бол тэрийг нь орон даяар зарлах хэрэгтэй шүү дээ.

- Яагаад хэрэгждэггүй юм.
- Яагаад тэн дээр хариуцлага яригддаггүй юм.
- ▶ Комиссын гишүүний зөвлөмжийн хэрэгжилт 2025 оны байдлаар багцлаад харах юм бол хувийн хэвшил хамгийн өндөр буюу 100 хувийн хэрэгжилттэй гарсан байна.
- ▶ Хамгийн муу хэрэгжилттэй нь –
  - Засгийн газар,
  - яам,
  - агентлаг,
  - түүний салбар нэгж 60.6 хувьтай гарч байна.

Засгийн газар уг нь гүйцэтгэх засаглал. Дийлэнх хэрэгжилт нь Засгийн газар дээр явдаг.

Тэгэхээр Засгийн газрын 60 хувийн хэрэгжилтийг бид ядаж дундаж руугаа аваачих хэрэгтэй. Эндээс дундаж нь энэ чинь 80-аас 85 хувьтай байна шүү дээ.

Хувийн хэвшил 100 хувийн хэрэгжилттэй байна.

Тэгэхээр ийшийгээ дараа жилийн илтгэл нь энэ хэрэгжилт муу байгаа газар луугаа илүү гүнзгий орох ёстой юм болов уу. Засгийн газар яам, агентлаг, түүний салбар нэгж дээр нийтдээ 28 зөвлөмжөөс –

- хариу өгөөгүй,
- хэрэгжээгүй,
- хэрэгжих шатандаа –

гээд хэрэгжсэн нь 60 хувьтай л юм байна. Хамгийн бага нь байна. Үүнийгээ бүгдээрээ шийдэх хэрэгтэй.

2024 онтой харьцуулаад үзэхэд хэрэгжилт нь буурсан байна шүү дээ.

- 2024 онд 87 байсан чинь,
- 2025 онд 81 болоод буурч. Энэ муу үр дүн шүү дээ.

Доошилж байгаа үр дүн харагдаж байна.

---

Үүнийг яаж дээшлүүлэх вэ. Энэ дээр Улсын Их Хурлын зүгээс бид ямар шахалт үзүүлэх ёстой юм, юу хийх ёстой вэ.

Яг эндээс асуудлаас нь харах юм бол энэ чинь дандаа хүүхэд. Өнөөдөр бид хүүхдийнхээ эрхээ хамгаалж чадахгүй ийм байдалтай. Тэр дээр нь 60 хувийн хэрэгжилттэй гэдгийг олигтой ч ярихгүй. Ийм байдалтай байж болохгүй байна.

Би өөрөө Хүний эрхийн комисст өөрөө хандаж байсан хүний хувьд Хүний эрхийн Үндэсний Комисс үнэхээр сэтгэлтэй хүмүүс байна лээ.

Хүн асуудал үүсээд аргаа бараад л Хүний эрхийн Үндэсний Комисс руу ханддаг юм билээ.

Би ч гэсэн Оюу Толгойн сонсголын үеэр аргаа бараад л Хүний эрхийн Үндэсний Комисс руу хандаж байсан. Тэр доор нь хүлээж аваад албан тоот хэд хэдэн удаа явуулсан боловч хариуцаж байсан төрийн байгууллагуудаас нэг ч хариу ирээгүй. Одоо 6 сар болж байна. Одоо ч хүртэл хариу байхгүй.

Улсын Их Хурлын гишүүн хандаж байхад хариу ирүүлэхгүй байгаа бусад уг нь мэдэхгүй ээ. Энэ чинь ноцтой асуудал шүү дээ.

Тэгэхээр энэ асуудлуудыг бид шийдэх хэрэгтэй. Энэ дээр яг үнэнийг хэлэхэд бид анхаарлаа байнга хандуулах ёстой байхгүй юу.

**П.Ганзориг:** Хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 25 дахь удаагийн илтгэлийг сонслоо.

Мэдээж Монгол Улсын Их Хурлын хэмжээнд яригдаж байгаа асуудлууд, Засгийн газрын бүх салбарын чиглэлүүд гээд энэ олон асуудлыг ганц Хүний эрхийн Үндэсний Хороо хариуцаж бүх шатад нь анхаарна гэдэг боломжгүй зүйл.

Хүний эрхийн Үндэсний Комисс өөрөө яг тухайн жилийн асуудал хаашаа чиглэх вэ, хаашаа анхаарах вэ гэдэг жил болгон гол гол чиглэлүүд рүү анхаараад явж байгаа.

Энэ дээрээ төр засгийн шийдвэрүүд, Их Хурлын түвшинд ямар хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх вэ гэдгийг чиглүүлж явах л учиртай байгууллага.

Тэгээд өнөөдрийн хувьд гишүүдээс олон саналууд гарлаа.

Энэ саналуудыг Байнгын хорооны санал, дүгнэлтэд ороод Хууль зүйн байнгын хороогоор орж хэлэлцэгдэнэ.

Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүд Хууль зүйн байнгын хороон дээр орж саналуудаа, ялангуяа Улсын Их Хурлын тогтоолын төсөл гарч Их

Хурлаар орох ёстой. Тэнд саналуудаа оруулаад явах боломжтой шүү гэдгийг давхар дуулгая.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороонд танилцуулах гишүүнээр Хууль зүйн байнгын хорооны давхар гишүүн манай Байнгын хорооноос ганц байгаа юм байна. Тэгээд М.Нарантуяа-Нара гишүүнийг томилъё. /алх цохив/

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Дараагийн асуудалдаа оръё.

---

**Хоёр.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл**  
/Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүн  
2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
хэлэлцэх эсэх/

---

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг явуулна.

Ингээд хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн танилцуулна.

**М.Бадамсүрэн:** Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийн талаар танилцуулъя.

Нэг.Хуулийн төслийн ерөнхий агуулга зохицуулах харилцааны талаар.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон “Алсын

---

хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор –

- хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн олон үндэстний гэр бүлээс гаралтай хөгжлийн бэрхшээлтэй шилжин суурьшихад эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана.
- Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ.
- Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- Сургууль бүрд спорт, урлагийн заал, номын сан бүхий хүүхдийн цогц хөгжлийн төвийг үе шаттайгаар байгуулна.
- Биеийн тамирын бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал, хэвшил төлөвшүүлэх, насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ хэмээн тусгасан.

Мөн

- ➔ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ.
  - ➔ Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.
  - ➔ Сум, хороо бүрт хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ.
  - ➔ Хүүхэд харах үйлчилгээ өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие, эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуй, эдийн засгийг дэмжих бодлого баримтална.
  - ➔ Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нар санхүүжилтийн болон байр тоног төхөөрөмж дэмжлэг үзүүлнэ гэж тодорхой заасан байна.
-

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнө болон ерөнхий боловсролын тухай хуулиар хүүхдийн эрх хамгаалал, боловсрол, хүүхдийн хөгжлийг дэмжих зорилго, ерөнхий чиг үүрэг тусгасан хэдий ч хэрэгжилтийг хангах механизм дутмаг, тодорхойгүй байна.

Хүүхдийн оролцоонд суурилсан хөгжлийг дэмжих, нас насанд нь тохирсон хөгжлийн үйл ажиллагаанд хөгжлийн ялгаатай байдал, олон янз байдлыг харгалзан үзэж тэгш хамруулах, үүнтэй уялдаатайгаар хот ба хөдөөгийн ялгааг арилгах, багш, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх зэрэг олон асуудал шийдэл хүлээж байгаа бөгөөд эдгээрийг салбарын бодлогоор бус салбар дундын, улсын хэмжээнд хэрэгжүүлэх нэгдсэн зохицуулалт бүхий хууль зүйн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа тул хүүхэд бүр хөгжлийн үйл явцад тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэх, хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагааг төрөөс дэмжих, санхүүжүүлэх, зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 5 бүлэг, 20 зүйлтэй бөгөөд дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- **1 дүгээр бүлэг.** Хуулийн зорилт. Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн зорилго, хуулийн үйлчлэх хүрээ, хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд баримтлах зарчим, хуулийн нэр, томъёоны тодорхойлолт зэргийг тодорхойлно.
  - **2 дугаар бүлэг.** Хүүхдийн хөгжлийг дэмжих, хичээлээс гадуурх хөгжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагааны зохион байгуулал, чиглэл, хүүхдийн оролцоо, эцэг, эх асран хамгаалагчийн эрх үүрэг оролцоо зэрэг асуудлыг тусгана.
  - **3 дугаар бүлэг.** Төрийн байгууллага болон оролцогчийн эрх үүргийг тодорхойлно.
  - **4 дүгээр бүлэг.** Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг дараах эх үүсвэр, түүний зарцуулах журмын зохицуулалтыг заана.
  - **5 дугаар бүлэг.** Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болгох зэргийг тус тус тодорхойлно.
-

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизм бүрдэж, хүүхдийн хөгжлийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Мөн нөгөө талаар биеийн тамир, урлаг, спорт болон олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийг бие даасан хувь хүн болгон төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улмаар хувь хүн болон нийгэм, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдэх билээ.

Мөн нөгөө талаар биеийн тамир, урлаг, спорт болон олон төрлөөр өөрийгөө хөгжүүлэх нь хүүхдийг бие даасан хувь хүн болгож төлөвших, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэж, улмаар хувь хүн болон нийгэм, эдийн засгийн хэмнэлт гаргах нөхцөл бүрдэх билээ.

Хүүхэд чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулах тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгөтэй болж, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд боловсрол, сургалтын байгууллагын хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Товч танилцуулгыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

**П.Ганзориг:** Танилцуулга хийсэн М.Бадамсүрэн гишүүнд баярлалаа.

Би ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Л.Бадамцэцэг Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга, М.Отгонгэрэл Хүүхдийн эрхийн улсын байцаагч, О.Энхмэнд Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Б.Энхчимэг Justice & Equality Consulting-ийн гүйцэтгэх захирал. Тэгэхээр энэ зөвлөх гэсэн үг үү. Хуулийн зөвлөх нь юм байна. Тийм ээ.

Ингээд танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Ж.Галбадрах гишүүнээр тасаллаа. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа юм.

Яагаад гэвэл хууль гарах цаг нь болсон. Яагаад вэ гэвэл өнөөдөр хүүхэд сургууль, гэр хоёрын хооронд л явдаг.

Өөрийгөө хөгжүүлэх, хамтдаа найзалж тоглож нөхөрлөх, янз янзын спорт урлагаар хичээллэх гуравдагч орчин байхгүй. Ерөөсөө гэртээ хариад л дөрвөн

ханан дунд. Эсвэл фэйсбүүкийн орчин, SNS (Social Networking Service) буюу. Тийм ээ. TikTok-ийн орчинд л орлоо шүү дээ.

Тэгэхээр энэ хууль цагаа олжээ гэж харж байна.

Хуулийн бичилттэй холбоотой зарим нэгэн зүйлийг тодруулж асууя гэж бодлоо. Яах вэ, хуулийн 4.1.5 дээр “хөгжлийн үйл ажиллагаа зохион байгуулагч” гээд. Энэ үгийг цаашаагаа хэрэглээгүй байна лээ. Хэд хэдэн өөр өөр үгүүдээр гарч ирээд байна лээ. Үүнийгээ жигдлэх хэрэгтэй шүү гэдэг нэг санал байна.

Хоёрдугаарт, Боловсролын ерөнхий хуулиар угаасаа “боловсролын сургалтын байгууллага” гэдгийг тодорхойлоод хаясан.

Тэгэхээр энэ дээр дахин тодорхойлох хэрэггүй. Зүгээр Боловсролын ерөнхий хууль дээр байгаа тодорхойлолт гээд л, тэдийн тэд гэсэн байдлаар заах хэрэгтэй санагдсан.

Тэгээд хамгийн гол нь улсын төсөв, Үндэсний баялгийн сан хоёрын харьцаа нь хэд байх юм? Одоо энэ санхүүжих нь баялгийн сангаас тэр хүүгийн орлогын 50 хувь гээд орж ирж байгаа. Тэр нь хэр зэрэг хэмжээний санхүүжилт болох юм? Энэ талаарх тооцоо юмнууд нь байхгүй байна лээ. Би хуулийн төслийг бүтэн уншаад үзэхэд танилцуулга дээр нь харагдахгүй байна лээ. Улсын төсөв гэсэн үг хэд хэд гарч ирээд байгаа.

Тэгээд энэ үндэсний баялгийн сангаас чухам хэдэн хувийг нь санхүүжүүлж, улсын төсөв нь хэдэн хувийг санхүүжүүлэх юм бэ гэдэг нэг ийм асуудал байгаа. Үүнийг тодруулж хэлж өгөөрэй.

Хуулийн төслөөр хүүхдийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гурван үндсэн чиг үүрэг хүлээнэ гээд заасан байгаа. Гурван үндсэн чиг үүргийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж ойлгож болох уу? Үүнийг асууя.

Эсвэл яг энэ асуудлыг хариуцсан ахиад өөр яам байгуулна гэсэн юм байхгүй байлгүй дээ. Би тэрийг бас нэг тодруулж асуумаар санагдсан.

Түүний зэрэгцээ энэ дээр хамгийн гол нь “Хүүхэд хөгжлийн төв” гэдгийг барилга, байгууламжийг хэлнэ гээд одоо яг энэ 4.1.3 дээрээ заасан байгаа юм. Тэгвэл тэр “Хүүхэд хөгжлийн төв” дээр юу явах вэ гэсэн чинь яг энэ “Хүүхэд хөгжлийн төв” бусад энэ дээр заасан 9 үйл ажиллагаа. Тийм ээ.

- > Шинжлэх ухаан,
  - > инженерчлэл,
  - > математик,
  - > технологи,
-

- > гадаад хэл,
- > спорт, биеийн тамир гэх мэт.

9 үйл ажиллагаа тэнд явах юм байна.

Гэтэл үүнийгээ энэ хуулийн 13.3 дээр “хувь хүн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хүүхэд хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулж болно.” гээд заасан.

Тэгэхээр би юу гэж бодоод байсан бэ гэхээр яах вэ “Хүүхэд хөгжлийн төв”-ийг байгуулж болно. Хамгийн гол нь төрийн байгууллагууд хийж байгаа биш хувийнхан, хувийн хэвшлийнхэн жишээлбэл нэг хэлний төв ч байдаг юм уу, жишээлбэл нэг балет заадаг ч юм уу, ийм төвүүд байлаа гэхэд тэд төртэй гэрээ байгуулаад тендерээр оролцоод, шалгараад, тэгээд гэрээ байгуулаад тэр үйл ажиллагаагаа өөрсдийнхөө сургалтын төв дээр ч явуулж болно шүү дээ.

Гэтэл... /минут дуусав/

**П.Ганзориг:** П.Наранбаяр гишүүнд нэмэлт минут өгье.

**Д.Наранбаяр:** Гэтэл энэ хуулийн заалтыг харах юм бол заавал тэр хөгжлийн төв дээр үйл ажиллагаа явуулах юм шиг ойлгогдоод байгаа.

Мөн хуулийн төслийн 6.3 дээр хүүхэд хөгжлийн төв, сургалтын төв, дугуйланд заасан чиглэлийн сургалтад жилд 6 сараас доошгүй хугацаанд хамрагдаж болно гээд заасан.

Тэгээд энэ хүүхэд болгон орох юм шиг ойлгогдохоор жишээлбэл хуулийн 15.5-ыг харахаар тэгж орж ирээд байгаа юм. Хүүхдийн хөгжлийг дэмжих ажиллагааны гадна хүүхэд хамрагдахгүй байхаас урьдчилан сэргийлж хамтарсан багийн гишүүдтэй хамтран ажиллана гээд.

Тэгэхээр зэрэг ухаандаа гэртээ хариад амраад байх хүсэлтэй хүүхэд байлаа гэхэд заавал дугуйлан, хүүхдийн хөгж зөрчлийн төв рүү яв гэдэг ийм шаардлагыг тавьж эхэлж байна уу гэсэн нэг асуулт байна.

Тэгээд эцэст нь хуулийн төслийн 19.2 дээр Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр заасан. Би энэ хуулийг уншаад байхаар эрүүгийн хуулийг дурдаад байх хэрэггүй санагдаад байгаа юм. Зөрчлийн хууль байхад болохоор харагдаад байна. Энэ дээр Та бүхэн яагаад Эрүүгийн хуулийг энэ хууль руу татаж оруулж ирсэн юм бэ гэдгээ тайлбарла. /минут дуусав/

**П.Ганзориг:** Хууль санаачлагч М.Бадамсүрэн гишүүн хариулъя.

**М.Бадамсүрэн:** П.Наранбаяр гишүүний асуултад хариулъя.

Боловсролын хуульд байгаа заалтуудыг эшлээд аваад сайжруулаад явах боломжтой.

Хоёрдугаарт, Үндэсний баялгийн сангийн Ирээдүй өв санд одоогоор 6 их наяд төгрөг хуримтлагдсан байгаа юм билээ. Ашигт малтмалын нөөц гэсний төлбөрт Монгол Улсын хэмжээнд жилдээ нэг 4-өөс 6 их наяд төгрөг төвлөрдөг. Үүний 65 орчим хувь нь Ирээдүйн өв санд зөвхөн төвлөрч байгаа.

Энэ хөрөнгө жил болгон нэмэгдээд явна. Ирэх онд гэхэд 8, 9 их наяд болдог юм уу нэмэгдээд явна. Энэ хөрөнгийг гадаадын санхүүгийн хэрэгсэлд оруулах буюу олон улсаас бонд худалдаж авдаг юм байна лээ. Одоогоор хүү нь 4.1 хувийн хүүтэй бонд худалдаж авч байна.

Тэгэхээр 6 их наяд төгрөгийн 4.1 гэхэд 240 гаруй тэрбум төгрөг жилдээ хүүгээр зөвхөн энэ оны түвшинд тооцоход. Ирэх онд энэ нэмэгдэнэ.

Тэгэхээр үүний 50 хувиас доошгүй гэхээр 100-аад тэрбум төгрөг жилдээ орох юм байна гэж.

Яагаад ингэж тооцсон гэхээр төсвөө санхүүжүүлнэ гээд орхиоор яг энд тийм тодорхой тогтолцоо болж чадахгүй байгаа юм. Тухайн үедээ төсвийн байдлаасаа хамаараад тийм тогтвортой бус санхүүжилттэй болох гээд байгаа юм. Жишээлбэл, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Ахмадын хөгжлийг дэмжих тухай хууль гээд байдаг боловч энэ санхүүжилтийн тогтолцоо нь өөрөө хамтад нь шийдээгүйгээс болоод төсвөөс болон ямар нэгэн төсвийн захирагч, албан тушаалтнаас хамааралтай болоод байгаа учраас хамааралгүй болгоё гэсэн зорилгоор үүнийг тооцсон.

Хариуцах төрийн захиргааны төв байгууллага нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

Өөрөөр хэлбэл хүүхдийн асуудлыг хариуцдаг. Гэхдээ аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга орон нутагтаа хүүхдийн төлөө зөвлөлийг нь тэргүүлдэг учраас салбар хоорондын уялдаа холбоог хангаж эндээ төсвөөс олгож байгаа санхүүжилтийг худалдан авах ажиллагаа, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулаад явах.

Өөрөөр хэлбэл гэрээгээр ажил гүйцэтгүүлэх. Бараа, ажил, үйлчилгээг төсөвт тусгагдсан хэмжээгээр тооцно гэж оруулсан.

Төрийн захиргааны төв байгууллага буюу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа хүүхдийн асуудал хариуцсан агентлаг, төрийн захиргааны байгууллагын хувьд үүнийг хяналт тавих мэргэжлийн нэгдсэн

удирдлагаар хангах, мөн нэгдсэн цахим сан үүсгэх зэрэг бодлогын зүйл дээр нь дэмжиж ажиллахаар ингэж тооцсон байгаа.

Хүүхэд хөгжлийн төв гэдгийг ойлголт нь тийм салаа утгатай байвал үүнийг залруулж болно. Энэ хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр бүрэн боломжтой.

Ер нь сая Ерөнхий сайд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүний хувьд манай баруун талын “Их засаг” танхимд хуралдаж байна.

Тэгээд хотын захиргааны хуучин байрыг “Хүүхдийн ордон 2” болгож байна гээд.

Тэгээд энэ бол хамгийн зөв. Яагаад гэвэл хүүхдийн хөгжлийн хамгийн сайн сургууль, цэцэрлэг бол гэртээ ойр гэж хэлж байгаа юм. Түүн шиг хүүхдийн ордон заавал автобусаар, таксигаар ирдэг биш аль болох гэртээ ойрхон байх. Хамгийн сайн хувилбар нь бүх сургуулийг нэг ээлжид шилжүүлж үдээс хойш нь сургууль маань өөрөө хөгжлийн төв болдог л ийм л зарчмаар явах ёстой учраас Хүүхэд хөгжлийн төвийг аль болох олон болгох шаардлага байгаа.

Тэр заавал хамруулахын тухайд үүнийг албадна гэж байхгүй. Сайн дурын үндсэн дээр. Ямар утгаар оруулсан гэхээр хүүхэд хамгааллын хамтарсан багууд эрсдэлт нөхцөлд байгаа, эсвэл энд мэдээлэл багатай байгаа хүүхдүүдэд санал болгох хэлбэрээр явна гэж.

Яагаад гэвэл олон улсад оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг гэдэг ерөнхий зарчимтай учраас аль болох хүүхдүүдийг чөлөөт цагаа дэлгэцээс хол, аль болох чөлөөт цагаараа сэлгүүцэхгүй өөрийгөө хөгжүүлэх энэ үйл ажиллагаанд оролцох боломжоор хангая гэдэг бодлоор ингэсэн.

Эрүүгийн хуулийг манай хуульч, хуулийн багийн ахлагчаас хариулах нь зөв... /минут дуусав/

**П.Ганзориг:** Ажлын хэсгээс нэмэлтээр хариулъя. Индэрээс хариулах уу? Хэн нь хариулах юм? Хуулийн зөвлөх. Индэр дээрээс хариулъя.

Саяын тэр хувийн хэвшлийн оролцооны талаар нэмээд хариулчхаарай.

**Б.Энхчимэг:** Эрүүгийн хуулийн зохицуулалтыг хасаад Зөрчлийн хуулийн зохицуулалтаар зохицуулалт хийх бүрэн боломжтой байгаа.

Хувийн хэвшлийн оролцооны хувьд хөгжлийн төв гэдгийг яг барилга байгууламжийн хувьд хүүхдийн хөгжлийг дэмжих барилга байгууламж байна гэдэг байдлаар зохицуулалтыг оруулж өгсөн. Энэ нь өөрөө заавал төрийн

байгууллага биш, хувийн болон төрийн хэвшлийн бүхий л байгууллага байх байдлаар зохицуулалт орсон байгаа.

Ажлын хэсгийн гишүүн хуульч Б.Энхчимэг.

**П.Ганзориг:** П.Наранбаяр гишүүн тодруулъя.

**П.Наранбаяр:** Тэгэхээр зүйтэй зүйтэй. Энэ Эрүүгийн хуулийг авч хаях нь зүйтэй. Энэ дээр ямар нэгэн тийм эрүүгийн харилцаа үүсэхгүй шүү дээ.

Хоёрт, сая хариулж байна. Ялангуяа барилга, байгууламжийг хэлж байгаа тохиолдолд энэ чинь сургууль ч орно, янз янзын байгууллагууд орно, хувийн хэвшил ч орж болох юм байна гэдгийг ойлголоо. Жишээлбэл, нэг жишээ хэлэхэд EDU Park гээд Солонгосын Элчин сайдын яамны хажууд яг хувийн хэвшлийн оролцоотойгоор хүүхдийн иж бүрэн хөгжлийн төвүүд үйл ажиллагаагаа хувийн хэвшил өөрөө санаачлаад явуулж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр 100 гаруй тэрбум төгрөг ер нь хүүгээс нь орж ирээд ийшийгээ төр оролцож эхлэх юм байна. Энэ дээр механизмыг нь аягүй сайн хийх хэрэгтэй. Механизмыг нь их сайн хийж чадаагүй байна гэж би хараад байгаа учраас яриад байгаа юм.

Жишээлбэл, хүүхдийн хөгжилд хувийн хэвшил орж ирсэн тохиолдолд санхүүжилтийн механизм нь яаж, хариуцлагыг нь яаж тогтоох юм. Энэ чиглэлийн юмнууд нь нэлээн нарийн тусах ёстой юм байна гэж хуулийн төсөл дээр ярьсан. Энэ чиглэл дээр яг нарийн ямар ямар заалтууд... /минут дуусав/

**П.Ганзориг:** Хууль санаачлагч М.Бадамсүрэн гишүүн хариулъя.

**М.Бадамсүрэн:** Тийм. Санхүүжилтийн механизмын хувьд ингэж байгаа. Хүүхдийн эрхийн тухай хууль дээр хүүхдийг хөгжүүлэхэд зориулж нэг хүүхдэд ногдох зардлын нормативыг Засгийн газрын 3 гишүүн хамтарч батална гэсэн заалттай байгаа. Үүнийг эшлэл болгож авч байгаа. Энд –

- ▶ Сангийн сайд,
- ▶ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
- ▶ Боловсролын сайд хамтарч батална.

Тэгээд энэ батлагдсан хэмжээнийхээ хүрээнд тухайн хүүхдийн тоо.

- Нийслэлд хэдэн хүүхэд байна.
- Тухайн аймгуудад хэдэн хүүхэд байна –

гэдгээр нь нормативыг нь тооцоод зардлыг нь аймаг, нийслэлийн төсөв рүү шилжүүлбэ.

Яагаад гэвэл орон нутаг буюу аймаг, сум, нийслэлийн Засаг дарга хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн бөгөөд салбар хоорондын уялдаа холбоог зохицуулж байгаа учраас энэ нь хамгийн оновчтой шийдэл болов уу.

Нөгөө талд нь хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага нь хяналтаа тавиад явъя гэдэг механизмыг сонгосон байгаа.

**П.Ганзориг:** Тийм. Хоёр тодруулсан билүү? Тэгвэл П.Наранбаяр гишүүн тодруулъя.

**П.Наранбаяр:** Санхүүжилт аягүй чухал юм.

Тэгэхээр Ирээдүйн өв сан чинь гадаадад байршаад байгаа. Тийм ээ. Ирээдүйн өв сан Монгол Улсын зээлжих эрхийг дээшлүүлэхэд их онцгой үүрэг гүйцэтгээд байгаа шүү дээ. Тэнд чинь хэдэн их наядаар тоологдох хөрөнгө гадаадын яг хаана байрладагийг би мэдэхгүй юм байна. Тэр Нидерланд, Лондонд ч гэлүү. Тэр гадаадад байрлаад.

Тэр нь Монголын зээлжих санг дээшлүүлэхэд их хэрэглэгддэг гээд.

Ирээдүйн өв санг бид чинь хэрэглэхгүй гээд нэг цоожилсон байгаа шүү дээ. Тэр нь хэзээнээс билээ. 2030 он хүртэл. Тийм ээ. Цоожилсон үед үүнийг бид чадах уу гэж асууя.

Улсын Их Хурал хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтын үйл ажиллагаанд зарцуулах нийт санхүүжилтийн хэмжээг батална гээд хэлсэн байгаа.

→ Тэгэхээрээ 2030 он хүртэл цоожилсон байгаа энэ цоожийг яаж эвдэх вэ? Хүүхдийн төлөө хэрэглэмээр байдаг.

Гэтэл 2030 он гэсэн хатуу заалттай. Цаана нь Монгол Улсын зээлжих эрхийн асуудал яригдаж байгаа. Үүнийг асуух гэсэн юм.

**П.Ганзориг:** М.Бадамсүрэн гишүүн хариулъя.

**М.Бадамсүрэн:** Энэ гарцаагүй асуух ёстой асуулт.

Өөрөөр хэлбэл Үндэсний баялгийн сангийн хуульд зааснаар Улсын Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд энэ сангийн зарцуулалт, тухайн жилийн төсвийг нь баталж байгаа. Тийм.

---

Хоёрдугаарт, Ирээдүйн өв сангийн хуримтлагдаж байгаа, нэмэгдэж байгаа мөнгөнийх нь зөвхөн хүүгийн орлого нь гэж байгаа. Өөрөөр хэлбэл хүмүүс хадгаламждаа мөнгө байршуулаад, хүүг нь хэрэглэдэг гэдэг байгаа. Тийм.

Хоёрдугаарт нь, санхүүжилтийн механизмыг нь таны хэлдгээр тодорхой болгохгүй бол тэгээд төсвөөс санхүүжүүлнэ гээд л орхидог. Энэ хэзээ ч биелэгдэхгүй нь олон практик дээр нотлогдсон.

Ер нь уул уурхай буюу газрын хэвлийн баялгийн өгөөжийг бүх иргэнд хүүхэд болон гэр бүлээр нь дамжуулж хүргэх гэдэг энэ зарчимтай энэ нийцэж байгаа. Дээр нь Их Хурал өөрөө энэ дээр тодорхой шийдвэрээ гаргаад явах боломжтой учраас... /минут дуусав/

**П.Ганзориг:** Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууя.

**Ж.Ганбаатар:** Өдрийн мэнд. Энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа.

Өнөөдөр манай Монголын боловсролд хамгийн орхигдоод байгаа зүйл бол хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хүүхдийн төлөвшил, хандлагад чиглэсэн арга хэмжээнүүдийг үнэхээр сургуулийнх нь даац нь ихэдсэн, хүртээмжгүй байдал, анги танхим бэлэн биш. Энэ байдлаас бид ерөөсөө хичээл оруулаад л гаргаад байгаа.

Тэгээд үүнийг яаж нөхөх вэ гэдэг арга замыг л бодож олж, гаргаж ирээд байгаа хууль гэдэг тэр үзэл баримтлалаар нь дэмжээд байгаа.

Одоо яг хийх арга, аргачлалыг нь бодоод үзэхээр бид нэлээн л их сайн бодож байж. Бэлтгэл ямар байна гэхээр мэдээж бэлтгэл хангая гэвэл зөндөө цаг алдана. Одоо энэ дээрээсээ хийе гээд.

Та Дорнод аймагт хийсэн. Манай Дорнод аймаг өөрчлөлт гарсан гэж хэлж байсан.

Тэгэхээр Дорнодынхоо жишээг тодорхой. Жишээлбэл, ямар хүмүүсийн хүч нөөц боломж. Одоо ялангуяа энд чинь барилга байгууламж, тэгээд тоног төхөөрөмж. Зүгээр хоосон нэг заал байж болохгүй шүү дээ.

Түүн дотор чинь гимнастик хийе гэдгээс эхлэхэд. Балет хийе гэхэд, шатар тоглуулья гэхээс эхлээд зөндөө зүйл гарах байх. Урлаг, хөгжмийн, тэр соёлын төвүүдийг ашиглана гэж та өчигдөр хэлж байсан.

Тэгэхээр энэ талынх нь юмнуудаар яах юм. Ийм бодит хөрөнгө оруулалтуудын энэ асуудал яах вэ? Өнөөдөр бид нэг хүүхдийн ваучер гэдэг шиг

л юм яригдаад байгаа шүү дээ. Энэ маань саяын тэр Ирээдүйн өв сангаас ч юм байна, улсын төсвөөс ч, орон нутгийн төсвөөс нэг хүүхдэд гэсэн нэг юу гаргах нь.

Тэгээд хүүхдийн тоогоор өгнө гэхээр чинь бүх хүүхэд хамрагдах болоод байна.

→ Тэгээд ер нь хамрагдалтын хэмжээг нь хэдэн хувиар харж байгаа юм?

Би бүх хүүхдээ хамруулаад ирье гэж байгаа нөхцөлд үүнийг хуулийн юуг нь үзэхээр сургуулиас гадна орчинд, сургуулиас нэлээн таслаад байгаа юм шиг харагдаад байгаа юм.

Би үүнийг хэрэгжүүлэхдээ сургуулийнх нь нөөц боломжийг нь, сургууль дээр нь суурилад, үнэхээр сургууль нь хүрэхгүй нөхцөлд ямар юм байх вэ. Жишээлбэл, аймаг, орон нутаг, суман дээр соёлын төв гээд байж болно. Тэгвэл Толгойтод байж байгаа 3 сургууль. Дундаасаа тэр 3 сургууль би өчигдөр жишээг нь хэлээд байсан. 65 дугаар сургууль, 152, 162 гээд ачаалал их байж байгаад нэг сургууль байснаа 3 болсон. Одоо хүүхдээ хөгжүүлмээр байна гэдэг асуудлыг бодитоор тавиад байгаа. Үүнийг хүсээд байна.

Яг тэр үед бид тэр хавьд. Тэр чинь нэг аймгийн төв шиг соёлын төвийг ашиглана гэхгүй. Тэр Сонгинохайрхан дүүрэгт тойрсон тийм Соёлын ордон гэдэг шиг тийм зүйлийг бид яаж тэрийг гаргаж ирэх вэ? Тэрийг ямар нөөц бололцоогоор гаргах вэ?

Мэдээж энэ дотор төсөв мөнгө нь суугдаад яахгүй л байх л байх л даа.

Тэгэхдээ ер нь зүгээр ямар үе шаттайгаар явах вэ?

**П.Ганзориг:** Ж.Галбадрах гишүүн нэмэлт минут өгье.

**Ж.Галбадрах:** Энэ хууль батлагдаад гарлаа гэхэд ямар үе шаттайгаар үзэж байгаа вэ? Эхлээд хэдэн хувийг нь ямар нөөц бололцоог ашиглаад. Бид бүх хүүхдийг энэ дээр хамруулна гээд үзэх юм бол одоо үнэхээр энэ маань фэйлдэх байх л даа.

Тийм учраас бид ямар үе шаттайгаар ямар газруудад нь явах вэ. Тэгэхийн тулд ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуудлуудыг би сонирхож асуух өгөхийг хүсэж байна.

**П.Ганзориг:** Л.Мөнхбаясгалан гишүүн хариулъя.

**Л.Мөнхбаясгалан:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ хуулийн төсөл зөвхөн Европт хийснээрээ, 1998 онд Исланд Улсаас эхэлсэн.

Тэгээд Европын 9 орноор биечлэн явж судалгаа хийсэн анхны хууль байхаа гэж би бодож байна. 2019 оноос хойш.

Энд Ж.Галбадрах гишүүний асуултад хариулахад одоо улсын хэмжээнд нийт 1219 заал тоологдож байгаа. Спортын заал. Үүнээс –

- 356 буюу 29.3 хувь нь Улаанбаатар хотод байгаа.
- 863 буюу 70.7 хувь нь хөдөө, орон нутагт тоологдсон байна.

Эндээс өмчлөлийн хэлбэрийг нь үзэх юм бол –

- 91.9 хувь нь төрийн өмчийн;
- 4.7 хувь нь орон нутгийн өмчийн;
- 1.6 хувь нь иргэний өмчийн;
- 1.8 хувь нь –

- төрийн өмчийн оролцоотой,
- хамтарсан,
- орон нутгийн оролцоотой,
- аж ахуйн нэгж, байгууллага,
- гадаад улсын аж ахуйн нэгжтэй холбоотой гээд.

Ийм сургууль, биеийн тамирын талбайнууд бүртгэгдсэн байгаа юм л даа.

Энэ дээр ерөнхийдөө яг тодорхойлж байгаа нь –

- ♣ сагсан бөмбөг,
- ♣ жүдо,
- ♣ хөл бөмбөг,
- ♣ шатар,
- ♣ волейбол,
- ♣ оюуны спорт,
- ♣ урлагийн гэдэг байршлаар –

аймгуудаар нь энэ заал, хүртээмжийг тооцож үзсэн. Энэ боломжийн дүн гарсан.

Хэрвээ шаардлагатай бол Танд би үүнийг хувийн болон орон нутгийн, төрийн өмчит сургуулиар нь хүргэж болно.

Тэгээд энэ дээр гол түшиглэх юм нь Биеийн тамир спортын улсын хорооны хажууд дэмжих сан байгуулаад, мэргэжлийн спортын холбоодоо татан оролцуулах юм бол энэ ерөөсөө болохгүй юм байхгүй байгаа юм. Жишээ нь,

- Гурвыг харьцах гурав сагсан бөмбөгийн холбоо,
- Монголын жүдо бөхийн холбоо,
- Монгол хөлбөмбөгийн холбоо,
- Монголын шатрын холбоо,
- Монголын волейболын холбоо гэх мэтчилэн.

Ингэж болно. М.Бадамсүрэн гишүүн өөрийнхөө Дорнод аймагт хэрэгжүүлснээр тайлбарлах байх. Ж.Батсуурь гишүүн бас үүнийг Сүхбаатар аймагт тун амжилттай хэрэгжүүлсэн байдаг.

Дэлхий даяар, ер нь ямар юмыг, ямар учиртай хуулийг бид хуулбарлаад байна гэхээр 90-ээд оны эхэн үед Исланд Улсын өсвөр насны залуус болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ гэж аймшигтай тоо гарч байсан л даа.

- Өдөр бүр тамхи татдаг хүүхдийн тоо 21 хувьд хүрч байсан.
- Архи, согтууруулах ундаа хэрэглэдэг хүүхдийн тоо 42 хувьд хүрсэн.
- Мансууруулах ургамал, мансууруулах бодисын хэмжээ 17.4 хувьд хүрч байсан.

Үүнээсээ Исланд Улс болохоо байгаад хүүхэд хорионы хуулийг баталж байсан. Орой 20.00 цагаас хойшоо хүүхэд гаргахгүй.

- 12 наснаас дээш насны хүүхэд 20.00 цагаас хойшоо гадаа гарахыг хориглодог.
- 13-аас 16 насны хүүхэд 22.00 цагаас хойш гадаа гарахыг хориглосон ийм хуулийг хэрэгжүүлж эхэлсэн.

Энэ үр дүнгүй байсан. Энэ гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж эхэлсэн.

Эд тэгээд юу болсон бэ гэхээр ерөөсөө энэ Хүүхэд хөгжлийн хуулийг олж санаачилж хийсэн.

Хүүхдийг эрүүл мэнд, бие бялдар, оюуны хөгжил, урлагийн зам руу, энэ дасгал сургууль руу татан оролцуулсан байна л даа. Ингэснийхээ дараа 5-хан жилийн дотор үр дүнд хүрсэн. Үүнийг дэлхий нийтээрээ харсан байдаг.

Хэзээ харсан бэ гэхээр 2018 онд Оросын Холбооны Улсад болсон хөл бөмбөгийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Исланд Улсын баг гэнэт

шигшээ багт шалгарсан. Английн шигшээг хожсон. Ингээд гайхамшигтай юм болсон.

Ингээд дэлхий даяар энэ улсыг судалсан. Энд юу вэ гэвэл эд хүүхэд хөгжлийн бодлогыг хуулиараа гаргасан байна. Ингээд Европын орнуудаар хэрэгжиж байгаа.

Манай хуулийн судалгааны багаас Исланд, Норвег, Швейцар, Унгар, Австри, Латви... /минут дуусав/

**П.Ганзориг:** Ж.Галбадрах гишүүн тодруулах уу? М.Бадамсүрэн гишүүн Дорнодын жишээ дээр тодорхой тайлбар мэдээлэл өгөөч гэж байна.

**М.Бадамсүрэн:** Баярлалаа. Миний бие Дорнод аймгийн Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн даргаар ажиллаж байхдаа “Хүн болох багаасаа” гээд нэртэй төслийг санаачлан хэрэгжүүлсэн.

Энэ бол маш амжилттай хэрэгжсэн. 2023 оноос эхлээд. Энд –

- орон нутгийн уул уурхайтай байгуулсан гэрээний дагуу орж байгаа хөрөнгөөс жилдээ **1.8 тэрбум төгрөгийг**,
- аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас **30 мянган төгрөгийг**,
- эцэг, эх нь хүүхдийн мөнгөнөөсөө **20 мянган төгрөгийг** гээд –

хоёр талын оролцоотой санхүүжилттэй 50 мянган төгрөгөөр нэг сарын төлбөр нь, 6 сарын туршид суралцдаг ийм зохицуулалтаар явж ирсэн.

Энэ бол хамгийн үр дүнтэй байгаа. Үүний үр дүн яаж гарч байна гэхээр Дорнод аймгийн хэмжээнд секц, дугуйлангийн тоо 60 хувиар нэмэгдсэн. Хамрагдаж байгаа хүүхдийн тооны хувьд бага, дунд ангид энэ төсөл хэрэгждэг. Бага, дунд ангийн нийт хүүхдийн 45 хувь нь энд хамрагдаж байгаа. Гэхдээ эцэг, эхчүүдийн оролцоо маш сайн байгаа.

Ер нь бид зөв зүйл рүү эцэг, эхчүүдийг уриалж явах нь чухал юм билээ.

Дээр нь багийн спортоор маш өндөр амжилт гаргаж байгаа. Дорнодын хүүхдүүд өсвөр үе... /минут дуусав/

**П.Ганзориг:** Ж.Галбадрах гишүүн тодруулъя.

**Ж.Галбадрах:** Баярлалаа. Дорнод аймгийг мэдэж байгаа. Би аймгаар тойроод явж байхад Дорнодод хүүхдүүдийн хөгжсөн байдал харагдаж байсан л даа.

Энэ бол сайн жишиг. Хэдүүлээ харин яаж бэлтгэлээ хангаж, яаж үр дүнтэй явуулах гэдэг талаас нь, тэрийгээ хуульдаа яаж тусгаж өгөх гэдэг талаас асуугаад байгаа юм.

Спорт заалны хувьд мянга гаруй заал байна шүү дээ. Энд сургуулийн заал орсон уу? Орохоор тэр сургуулийн чинь хичээл сургалтын үйл ажиллагаа хоёр ээлжээрээ явна. Тэнд дугуйлан секц орох боломж нь байхгүй юм биш үү гэдэг нэг юм байна.

Багшлах боловсон хүчний асуудлуудыг хэдүүлээ юу гэж харж байна? Багшлах боловсон хүчин маань дугуйлан секцээ заагаад эхэлдэг. Тэгээд долоо хоногт нэгхэн явах уу. Нөгөө хүүхдийнх нь тоо нь. Одоо ингээд маш олон хүүхэд хамрагдаад ирвэл үндсэн хичээлээ заана гэхээсээ илүү нөгөө төв дээрээ ажилладаг багш нар маань дутагдах билүү? Энэ тооцооллыг ер нь хэр хийсэн бэ?

**П.Ганзориг:** Хууль санаачлагчаас Л.Мөнхбаясгалан гишүүн хариулъя.

**Л.Мөнхбаясгалан:** Боловсон хүчнийг бодолцож үзсэн. Боловсон хүчин одоо багшилж байгаа багш нар болон чөлөөнд гарсан ахмад багш нар. Энэ чинь зөвхөн багш мэргэжилтэй байх албагүй шүү дээ.

Спортын дасгалжуулагч байна. Урлагийн хүн байна. Тамирчин байна. Энэ хүмүүсийг бүгдийг нь татан оролцуулахад боломжгүй юм байхгүй гэж гарсан.

Өдоогоор манай улсад хамгийн сайн хэрэгжих нь жүдо юм билээ. Аймаг болгон жүдогийн татамитай тийм сургалтын төвтэй. Энэ дээр 6 бүс дээр нийтдээ 53 дасгалжуулагч, тэгээд 40 тамирчин бэлтгэе гэж үзэх юм бол ерөөсөө хоёрхон жилийн дотор л хийхээр ийм дүн гарч байсан.

Одоо манай улсад жишээ нь Толгойтод гэхэд сайн санааны аянаар хүүхэд хөгжлийн төв байгуулсан хүн байгаа байхгүй юу. Япон Улсаас хөрөнгө оруулалт татаад ийм хүүхэд хөгжлийн төвүүдийг сайн санааны түвшинд байгуулсан. Тэрийг нь цааш нь аваад явах боломжгүй болсон.

**П.Ганзориг:** Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууя.

**Ж.Чинбүрэн:** Зөвхөн боловсрол, халамжийн асуудал биш. Монгол Улсын ирээдүйн хүний хөгжлийн суурь бодлого гэж харж байна. Энэ хууль цаг үеэ олсон хүүхдийн эрхийг хамгаалах өдөртэй ч гэсэн уялдаж байгаатай чухал байна.

Тэгэхээр бид өнөөдөр нэг ноцтой үнэнтэй нүүр тулж байна. Өнөөдөр бас энэ хүүхдийн эрхтэй холбоотой олон ч асуудлууд яригдаж дурдагдаж байна. Тухайлах юм бол хүүхдүүдийн дунд –

• хөдөлгөөний дутагдал,

- таргалалт,
- цахим хамаарал,
- сэтгэлийн хямрал,
- ганцаардал,
- амиа хорлох эрсдэл эрчимтэй нэмэгдэж байна.

Хүүхэд зөвхөн хичээлээр хөгждөггүй. Хүүхэд биеэрээ хөдөлж, багаар тоглож, нийгэмшиж, сэтгэл зүйн дархлаатай болж байж эрүүл иргэн болон төлөвшдөгийг бид бүгдээрээ мэдэж байгаа.

Тиймээс энэ хуульд дараах хэдэн асуудлыг маш тодорхой тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Тэгэхээр дэмжигдээд, ажлын хэсэг байгуулагдвал бид дараах хэд хэдэн асуудлыг онцгой анхааръя.

Үүнийг манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо анхааралдаа авч ажлын хэсэг байгуулахдаа энэ асуудлуудыг хөндөөсэй гэж хүсэж байгаа.

- ▷ **Нэгдүгээрт**, хүүхдийн бие бялдрын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын түвшинд асуудал гэж харах ёстой. Тийм ээ. Өдөр бүр тогтмол хөдөлгөөнтэй байх, спорт, нийтийн биеийн тамирын хүртээмжийг нэмэгдүүлэх, сургууль бүрийг хүүхэд хөдөлдөг орчин болгох хэрэгтэй.

Өнөөдөр хөдөлгөөнгүй хүүхэд маргааш чихрийн шижин, даралт, сэтгэлийн хямралтай насанд хүрэгч болж хувирах эрсдэл байгаа.

- ▷ **Хоёрдугаарт**, нийгмийн биеийн тамирын бодлого хүүхэд рүү чиглүүлэх шаардлагатай. Зөвхөн тамирчин бэлтгэх биш. Хүүхэд хөдөлгөөнтэй байх орчныг бий болгох ёстой. Хашаа бүрт тоглох талбай, сургууль бүрт хүртээмжтэй спортын орчин хэрэгтэй. Энд бүр зориуд дурдаж хэлмээр байгаа юм.
- ▷ **Гуравдугаарт**, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг энэ хуульд маш хүчтэй оруулах хэрэгтэй.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн –

- сэтгэл гутрал,
  - айдас,
  - цахим дарамт,
  - ганцаардал,
  - амиа хорлолтын оролдлого ноцтой хэмжээнд болсон талаар статистик мэдээнүүд.
-

5 хүүхэд тутмын нэг нь энэ тухай бодож байсан гэсэн тоо бариад яриад байна л даа.

Бид хүүхдээ зөвхөн шалгалтын оноогоор хэмждэг биш сэтгэл зүйн хувьд аюулгүй орчинд өсөж байна уу гэдгийг төр бодох цаг болсон.

Тийм учраас сургууль бүрт сэтгэл зүйн зөвлөгөө, эрт илрүүлэг, үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг тогтолцоо, цахим орчин, эрсдэлийн боловсрол, эцэг, эхийн оролцооны механизм тодорхой байх ёстойг энэ хуульдаа тусгаж өгье.

Тэгэхээр хүүхэд амиа хорлоно гэдэг ганц гэр бүлийн асуудал биш. Энэ бол нийгмийн дохио, төрийн бодлогын дохио байна шүү гэдгийг бидэнд анхааруулж байна.

Тэгээд эцэст нь бид хүүхдэд хайртай гэдгээ үгээр биш бодлогоороо харуулах ёстой.

Тийм учраас энэ хуулийг дэмжиж, манай Байнгын хороо бүр тусгайлан дэмжиж явуулах нь зүйтэй гэж харж байна. Баярлалаа.

**П.Ганзориг:** Үг хэллээ. Тийм ээ. Ж.Чинбүрэн гишүүн хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийллээ. Чухал үгүүд хэллээ.

Тэгээд энэ дээр бид хүүхдийн хөгжлийн асуудал ярьж байгаа бол ганцхан боловсролын талаас нь биш, эрүүл мэндийнхэн ч гэсэн асуудлуудаас оруулж болох цар хүрээг тодорхойлох нь зөв байх гэж бодож байна. Тухайлбал, хоол тэжээлийн асуудал хүнд байгаа шүү дээ.

Яг эрүүл хүүхэд өсөхөд авах ёстой хэмжээний хоол тэжээл калорио авч чадаж байна уу, үгүй юу гээд. Эрүүл, боловсролтой Монгол хүн л Монгол Улсын баялаг байна.

Үндэсний баялгийн сан, Ирээдүйн өв сан, дахиад Монгол Улсын ирээдүй болсон тэр баялгийг өөрөө бүтээж байх ёстой. Эрүүл Монгол хүн, боловсролтой Монгол хүнийг бий болгож байх ёстой.

Тэгэхээр эрүүл мэндтэй холбоотой зарим асуудлуудыг нь тооцоо судалгаа хийж байгаа. Боломжтой энэ дээр оруулаад явах нь илүү чухал болов уу гэж бодож байна.

Л.Мөнхбаясгалан гишүүн хариулъя.

**Л.Мөнхбаясгалан:** П.Ганзориг дарга, Ж.Чинбүрэн гишүүнд баярлалаа. Энэ талаар судалгаа хийсэн.

---

Хүүхдийн цаг ашиглалт дээр бид судалгаа хийж үзсэн.

Тэгээд өдөрт нэг хүүхэд жишээ нь,

- Facebook гэхэд 59.2 минут,
- Тоглоом тоглоход 46.8 минут,
- YouTube хэрэглээнд 41.4 минут –

гэх мэтчилэнгээр хүүхдийн цаг ашиглалт дээр тооцоо хийж үзсэн.

Эрүүл мэнд дээр судалгаа хийж үзсэн.

Нас баралтын шалтгаан, өвчлөлийн шалтгаан хоёр дээр

- › 5-аас 9,
- › 10-аас 14,
- › 15-аас 19 насны хүүхдүүдийн дунд судалгаа хийсэн.

Ингээд хүүхдийн чийрэгжилт муу байгаа нь өвчлөлийн шалтгаан болсон. Энэ нь 48 хувьтай гарсан.

- ➔ Амьсгалын тогтолцооны өвчин,
- ➔ мэдрэлийн тогтолцооны өвчин,
- ➔ яс, булчингийн тогтолцоо ба холбох эд гэмтэл,
- ➔ бусад шалтгаант өвчин гэдэг дээр гарсан.

Нас баралтын шалтгаан дээр бүр ноцтой. Чийрэгжилт муу байгаагаас 35 хувь. Хөдөлгөөний дутагдалтай холбоотой өвчний шалтгаант нас баралт гэдэг дээр зүрх судасны өвчнөөр 18... /минут дуусав/

**П.Ганзориг:** Асуулт асуух гишүүдийн жагсаалтад О.Саранчулуун гишүүн, Д.Рэгдэл гишүүн хоёрыг нэмье.

Ингээд Доржзовдын Мөнхтуяа гишүүн асуулт асууна.

**Д.Энхтуяа:** Монгол Улсад 1.3 сая хүүхэд байна.

- 2016 онд Хүүхдийн эрхийн тухай хууль,
- 2024 онд Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсан байгаа.

Тэгэхээр хүүхэд хөгжлийн тухай анхдагч хуулийн төсөл орж ирж байна.

Энэ онгорхой байгаа цонхыг нөхөх юм байна гэж үзэл баримтлалын хувьд би дэмжиж байна.

Ер нь хүүхэд хөгжлийн асуудал энэ олон хуулиудад ерөнхийдөө энд тэнд тараан байршсан маягаар явж байгаа учраас тусгай хуультай болох юм байна гэж ойлгож байна.

Ардчилсан намын гишүүд ер нь хуулийн төслийг санаачилсан. Уг хуулийн төсөл урьд нь “хүүхэд хөгжлийн карт” буюу “9 сарын 01” гэсэн ийм хуулийн төсөл байсан.

Тэгээд энэ хуулийн төсөл дээр маш тодорхой заасан байсан.

- ▶ Хүүхэд хөгжлийн асуудалд хэчнээн төгрөг суулгах юм.
- ▶ Яаж хэрэгжүүлэх юм

гээд тодорхой заасан байсан. Одоо өнөөдөр хүүхэд болгонд 100 мянган төгрөг өгч байгаа. 100 мянган төгрөг гэр бүлийн ахуйн хэрэгцээнд зарцуулагдаад байна гэсэн судалгаа гарсан байгаа.

Тэгэхээр 100 мянган төгрөг ахуйн хэрэгцээндээ явдаг юм байгаа биз. Ардчилсан намын зүгээс барьж байсан хуулийн төсөл дээр 30 мянган төгрөгийг карт хэлбэрээр зөвхөн бүртгэлтэй байгууллагуудад өгье. Зөвхөн спорт, урлаг, оюуны хөгжилд нь зарцуулъя. Үүнийг яг ингэж зарцуулъя. Тэгээд карт хэлбэрээр хэрэгжье хэрэгжүүлье гэсэн яг ийм зохицуулалт байсан.

Одоо яг энэ орж ирсэн хуулийн төслөөр яг яаж зарцуулагдах гээд байгаа нь тодорхой бус байна л даа. Ирээдүй өв сангийн хөрөнгөөс төсөвт суулгана гэж байна. Түрүүн П.Наранбаяр гишүүний асуугаад байгаа 2030 он хүртэл түгжсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр Ирээдүй өв сан, энэ Баялгийн сангийн хуульд өөрчлөлт оруулахад маш төвөгтэй гэж. Ер нь боломжгүй байх гэж харж байна. Тэгэхээр энэ дээр дахиад тодорхой хариултыг өгөө. Би сайн анзаарч хариултыг сонссонгүй.

Тэгэхээр 6 их наяд төгрөг байна. Хөгжлийн сан хоосон бичигдэж байгаа. Хуримтлалын санд орж байгаа зүйл бол боловсрол, тэгээд нийгмийн хамгаалал, хөгжил гэсэн ийм асуудлууд дээр зарцуулагдаад явж байгаа учраас санхүүжилт тодорхой бус байна.

Тийм учраас л энэ хууль буцах вий дээ гэж санаа зовж байна.

Тэгээд ер нь үзэл баримтлалын хувьд маш зөв хууль болж байна.

Яагаад гэвэл өнөөдөр хүүхэд насанд маш сониуч байдаг. Энэ сониуч санг нь бид хөгжүүлэхгүйгээр хүүхдүүдийг оюуны спорт, спорт, бие бялдрын спортоор

хөгжүүлэхгүйгээс болж өнөөдөр хүүхдүүд маань маш буруу зүйлд татагдаж байна шүү дээ.

Үе тэнгийн дээрэлхэлт л гэдэг зүйлийг бид үндэстнээрээ ярих хэмжээнд очсон байна. Түрүүн Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээлэлд насанд хүрээгүй охидын жирэмслэлт маш өндөр хэмжээнд байна гэсэн ийм маш эмзэглүүштэй мэдээлэл байж байна. Бие бялдрын хувьд... /минут дуусав/

**П.Ганзориг:** М.Бадамсүрэн гишүүн хариулъя.

**М.Бадамсүрэн:** Санхүүжилтийн тогтолцоо хамгийн чухал болоод байгаа юм.

Ямар нэгэн эх үүсвэрийг нь тодорхой зааж өгөөд, хүнээс хамаарахгүйгээр системийн хувьд ажилладаг болгож өгөхгүй л бол яг л ахмадын хөгжлийн, нөгөө ахмадын сангийн 3 хувь бүрдэхгүй байгаа, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хэрэгжихгүй байгаатай л адилхан болох гээд л.

Тэгээд судалж судалж байгаад газрын хэвлийн баялгийг ирээдүй үеэсээ зээлж хэрэгжиж байгаа учраас ирээдүй үедээ зарцуулна гэдэг Ирээдүйн өв сангийн зарчмын дагуу эндээсээ зарцуулаад явъя. Гэхдээ үндсэн хөрөнгөд нь, арвижиж байгаа хөрөнгөд нь огт хүрэхгүй. Зөвхөн хүүгээс нь гээд.

Эсвэл хүүхдийн мөнгө гээд 1.8 их наяд төгрөг зарцуулж байгаа.

Энэ дээр 200 тэрбумыг юм уу, яг хууль дээр тусгаж нэмээд, энэ нь таны хэлдгээр яг хүүхдийн мөнгө ахуйн хэрэгцээндээ голцуу зарцуулагдаад байна. Нэг хүүхдийн 100 мянган төгрөг. Тэгвэл яг хөгжилд нь зарцуулахын тулд үүнийг нь тусад нь хүүхдийн мөнгө гэдэгтэй адилтгах хэлбэрээр төсөв дээр тусгайлан яг нэг хүүхдэд тэдэн төгрөг гэж тодорхой зааж өгөөд оруулбал боломжтой гээд нэг хувилбар байгаа.

Тэгэхдээ тэр нь хүнээс, албан тушаалтнаас хамаарахгүй хэрэгждэг л байхгүй бол энэ ерөөсөө явахгүй. Хуурай хууль болох гээд байгаа байхгүй юу.

Нэг хууль гаргадаг. Тэр нь хэрэгждэггүй. Дахиад л 6 сарын 01 болдог. Дахиад л хүүхдийнхээ тухай зүйлээ ярьдаг. Ийм байдлаар их олон жил явж ирсэн учраас үүнийг тодорхой болгоод өгье.

Яагаад гэвэл Дорнод аймагт газрын хэвлийн баялгаас, уул уурхай, орон нутгийн гэрээгээр өөрийнх нь бие даасан иргэдийн хурлын шийдвэрийг байгуулсан гэрээний дагуу орж байгаа мөнгөнөөс 1.8 тэрбум төгрөгийг жилд зарцуулахад үүгээр 7500-аас 9000 хүүхэд хүссэн секц, дугуйландаа хичээллэж эцэг, эхийн тэр орлогын байдлаас үл хамаараад. Эцэг, эх нь 20 мянган төгрөг л

төлнө. Асран хамгаалагч нь. Тэгээд аймгийн төсвөөсөө 30 мянган төгрөг шилжүүлж байгаа. Яг таны нөгөө карт гэдэгтэй адилхан. Тийм ээ.

Ийм тогтолцоо нь их амжилттай хэрэгжсэн учраас хэрэгжсэн зүйл дээрээ үүнийг зөвхөн нэг аймагт биш, энэ туршигдсан зүйлийг улсын хэмжээнд нэвтрүүлье л гэж бодож Улсын Их Хурлын гишүүд бид хамтарч санал нэлээн удаан солилцож байгаад үүнийг өргөн барьсан.

Ер нь энэ хуулийн төслийг бараг 2 жил боловсруулсан. Өнгөрсөн оны 6 сарын 01-нд боловсруулж байгаа тухайгаа мэдээлсэн.

Түүнээс хойш нэг жилийн хугацаандаа гадаад, дотоодын туршлага, Л.Мөнхбаясгалан гишүүний хэрэгжүүлж судалсан тэр туршлагаудтай, онолын. Тийм ээ. Бусад орны туршлагыг судаллаа. Орон нутагт хэрэгжүүлсэн энэ зүйлийг судаллаа.

Тэгээд их олон талаас нь бодож боловсруулж байгаад ингэж төлөвлөж оруулсан байгаа. Хэрэгжилтийн механизмын хувьд түрүүн хэлсэн. Тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга хүүхдийн төлөө зөвлөлийн буюу салбар хоорондын уялдааг хангадаг төсвийн ерөнхийлөн захирагч учраас тэнд шилжүүлж өгөөд батлагдсан хөрөнгийг тэнд нь өөрөө хуваарилаад явна.

Одоо манай ерөнхий боловсролын сургуулийн нормативт зардал, эрүүл мэнд чинь яг зарчмаар явдаг шүү дээ.

Тухайн аймаг, нийслэлийнх нь төсвийн ерөнхийлөн захирагч руу очоод тэндээсээ зохих журмын дагуу нормативын дагуу хуваарилагдаад л явна. Энэ дээр тэр хүн зөвхөн дамжуулж төсвийг зарцуулж хяналтаа тавьж байгаа гэсэн үг. Газар нутгийн байршлын хувьд ойрхон гэдэг энэ утгаараа явж байгаа.

Баялгийн сангийн хөрөнгө нэгдүгээрт нь Ирээдүйн өв сан хүүхдүүддээ хуримтлуулж байгаа мөнгө.

Тэгээд Монголбанкнаас ямар дүгнэлт гарсан гэхээр энэ Ирээдүйн өв санд орж байгаа болон Үндэсний баялгийн санд орж байгаа бүх мөнгө монгол төгрөгөөр АМНАТ-ийн төлбөр төлөгддөг. Гэхдээ дотоодын зах зах зээлээс дахиад валют худалдаж авдаг.

Тэгэхээр үүнийг бүгдийг нь валют худалдаж авах нь тийм оновчтой биш байна гэдэг дүгнэлтийг бас гаргасан.

Мөн энэ гадаадад банканд хадгалагдаагүй. Монголбанк удирдаад гадаадаас бонд худалдаж авч байгаа. Монголбанканд дээрээ байгаа л гэсэн үг. Тэгэхдээ гадаадаас бонд аваад эргэж төлөгдөөд, дахиад гэрээ хийгээд явдаг. Ингээд арвижаад явж байгаа ийм л... /минут дуусав/

**П.Ганзориг:** Д.Энхтуяа гишүүн тодруулъя.

Тэгэхдээ Монголбанкнаас Үндэсний баялгийн сангийн үлдэгдэл болох хуримтлагдсан. Одоогоор 2.3 тэрбум доллар байгаа байх. Тэрийг гадаадын 4, 5 банканд хадгаламж хэлбэрээр жилийн 4 орчим хувийн хүүтэйгээр хадгалж байгаа гэж мэдээлэл өгч байгаа юм.

Нөгөө талдаа Үндэсний баялгийн сангийн энэ хөрөнгийг Монголбанкны гадаад валютын албан нөөцөөр бүртгэж байгаа. Хэрвээ бонд авч байгаа тохиолдолд гадаад валютын албан нөөцөөр бүртгэх боломжгүй байх ёстой.

Тэгэхээр үүнийг сайн тодруулж хууль санаачлагч хариулахыг хүсье. Тэгээд Д.Энхтуяа гишүүн тодруулъя.

**Д.Энхтуяа:** Зөв өө зөв. Ер нь Ирээдүйн өв сан, Баялгийн сангийн хүүхдүүддээ зарцуулах ёстой мөнгийг хүүхдүүддээ зарцуулах нь зөв.

Тэгэхээр бид ямар арга хэлбэрээр, ямар арга замаар энэ хуулийг батлуулах вэ гэдэг чинь аягүй чухал байхгүй юу. Тийм ээ.

Тэгэхээр яг тодорхой байх ёстой байхгүй юу. Та сая хэллээ. Тэр төсвийн далай руу ороод алга бол вий дээ. Маш олон зүйлүүд хүүхэд рүү чиглэсэн юмнууд байгаа хэрнээ төсвийн далай руу ороод л хэн нэгэн албан тушаалтны өөрийн үзэмжээр яваад хүүхдүүддээ хүрэхгүй байгаа байхгүй юу. Тэрний гол үр дүн нь гэдэг юм уу, хохирогч нь хүүхдүүд болоод байгаа байхгүй юу. Бид хүүхэд хамгаалал гээд л яриад байна. Энэ хүүхдийн эрх гээд л яриад байна. Харамсалтай нь хөгжил рүү чиглэсэн энэ мөнгө ерөөсөө хүүхдүүддээ очихгүй байгаа гэдэг дээр 100 хувь би санал нэг байна.

Тийм учраас ваучер хэлбэрээр өгөх юм уу, яг тэр тусгай зөвшөөрөгдсөн байгууллагуудад энэ ваучерыг хэрэглэдэг тусгай зохицуулалтыг л энэ хуульдаа нарийн оруулж өгөх ёстой.

**П.Ганзориг:** Үг хэллээ. Асуулт асуух гишүүдийн жагсаалтад Г.Хосбаяр гишүүнийг нэмье.

**О.Саранчулуун** гишүүн асуулт асууя.

**О.Саранчулуун:** Нэг зүйл тодруулъя.

Монгол хөгжлийн бэрхшээлтэй 0-ээс 18 насны 13 мянга гаруй хүүхэд байдаг. Ялангуяа сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгт 60 хувь нь л хамрагддаг гэсэн тооцоотой байдаг.

Өөрөөр хэлбэл 10 эцэг, 10 ээж тутмын 4 нь хүүхдээ цэцэрлэгт явуулж чаддаггүй гэсэн үг. Дунд сургууль руу ороод ирэхээр энэ тоо 5 болдог гэсэн үг.

Тэгэхээр 10 ээж өнөөдөр гэртээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлээд гэртээ хүүхдээ харах, ихэвчлэн ээжүүд гэртээ хүүхдээ харахаас өөр аргагүй болдог байхгүй юу.

Тэгэхээр орон нутагт хүүхэд хөгжлийн хөтөлбөр дотор нэг орхигдоод байдаг зүйл бол энэ ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдэд чиглэсэн үйлчилгээ дутагддаг.

Би энэ хуулийн төсөлтэй холбогдуулан “Хүн болох багаасаа” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ер нь хэр хамрагдаж байсан бэ гэдгийг тодруулгыг авъя.

Хоёрдугаарт нь, энэ хуулийн төсөлд багшийг жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургах арга барилд сурах нэг том асуудал байдаг. Дээрээс нь тэр хүүхдийн хөгжлийн сургалтын төв байдаг юм уу, тэр үйл ажиллагаа нь өөрөө орчны болоод мэдээллийн тийм хүртээмжтэй байх асуудлыг дурдаж байгаа.

Тэгэхээр энэ асуудлууд ер нь хэр тусгагдах боломжтой вэ гэдэг хоёр асуултыг асууя.

**П.Ганзориг:** Хууль санаачлагч М.Бадамсүрэн гишүүн хариулъя.

Асуулт асууж дуусаад, гишүүд үг хэлээд санал хураалт явагдана. Хүүхдийн хөгжилтэй холбоотой маш чухал хууль хэлэлцэх гэж байгаа тул гишүүд танхимдаа орж ирэхийг хүсье.

М.Бадамсүрэн гишүүн хариулъя.

**М.Бадамсүрэн:** О.Саранчулуун гишүүний энэ маш чухал асуудал.

Тэгэхээр одоо жишээлбэл Дорнод аймагт энэ төсөл хэрэгжсэнээр тусгай хэрэгцээт болон эмзэг бүлгийн хүүхдийн 21 хувь нь одоогийн байдлаар хамрагдсан байна. 21 хувь нь.

Хуулийн төсөл дээр тодорхой хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд хандсан тусгай заалт орсон байгаа.

Ер нь энэ дээр илүү онцгой анхаарч явна. Тэгээд хууль маань батлагдсаны дараа үүнийг хэрэгжүүлэх механизм дээр үүнийг бүрэн хэрэгжээд явах боломжтой гэж үзэж байгаа.

---

**П.Ганзориг:** Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Их чухал хууль гэж харж байгаа.

Тэгээд мэдээж анхдагч хууль болохоороо наанатай цаанатай юм байгаа л байх. Ажлын хэсгийн гишүүд бас ч чамгүй. Их төлөв Европын өндөр хөгжилтэй орноор яваад хүүхдийн хөгжлийн төвтэй төстэй бүтэц, байгууллагууд, үйл ажиллагааг нь нэлээн сайн судалсан юм байна.

Ер нь Монголд намайг сургуульд байхад энэ чинь зүгээр байж л байсан юм байгаа юм. Сургуулийн хажууд. Сургууль болгон “үйлдвэр сурган” гэдэг хичээл ордог байсан. Эрэгтэйчүүд нь янз бүрийн чиглэлээр мужаан, дархан. Эмэгтэйчүүдийн чиглэл гээд.

Хуулийн төслийг хэлэлцэх явцад Монголынхоо тэр социализмын үеийн туршлагыг бас судлаад үзээрэй. Яагаад би ингэж хэлж байна вэ гэхээр энэ хуулийг бүхэлд нь хараад үзэхээр сургуулиасаа л жаахан хөндийрөөд байна. Ер нь сургуулиасаа хөндийрөөд байна. Үүнийг ер нь сургуулиас хөндийрүүлмээргүй байгаа юм. Одоо энэ асуудлыг хариуцна төрийн захиргааны төв байгууллага гэхээр сургуулиас хөндийрөх юм бол энэ чинь Гэр бүл, хөдөлмөрийн яам руу ч явдаг юм уу, Хүүхэд залуучуудынхаа яам руу явдаг юм уу. Иймэрхүү юмнууд болоод унахвий. Сургуулиадаа ойртуулмаар байна.

Байрны хувьд хүүхдийн хөгжлийн төв гэж нэг байгууллага хуулийн этгээд байх юм байна. Байрны хувьд нэлээн асуудалтай заалтууд байна. Энэ 12.1.5, 13.2 гээд орон байрны асуудлыг тусгасан байгаа. Хоёулаа адилхан. Яагаад хоёр өөр зүйл дээр хоёр адилхан заалтууд оруулаад байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хөдөө соёлын төвүүд жишээлбэл. Эд нар чинь өвөл ажилладаггүй шүү дээ. Хөдөө сумдаар. 6, 7 сар ажиллахгүй. Яагаад гэвэл халааж чадахгүй. Зардлаа даадаггүй. Түүнд найдаж хэрэггүй.

Зүгээр энэ хуулиараа харин сургуулийн хичээлийн байрны хүртээмж, хангамжийг сайжруулах асуудлыг цуг тавиад явбал, сургуулийн хичээлийн байрын асуудал шийдэгдвэл энэ асуудал чинь аяндаа шийдэгдмээр юм шиг санагдаад байгаа юм.

Санхүүжилтийн хувьд бас асуудалтай. Манай гишүүд их чухал санаанууд хэллээ. Санаачлагчид маань маш сайн анхаараарай. Тэр баялгийн сан энэ тэр лүү оруулаад байвал ер нь бараг л бүтэхгүй тал руугаа орно.

Би албан бус мэдээллээс харж байсан юм. Манай Монголд хүүхдийн мөнгө гэж нэг мөнгө байдаг. Түүнээс нэлээн хэсэг гэр бүл ер нь хүүхдийн мөнгө авах шаардлагагүй гэж хэлдэг гэж байгаа юм. Тэрийг судлаад үзвэл яасан юм бол. Үнэхээр 15-аас 20 хувь нь гэдэг юм. Тийм болбол тэр хүүхдийн мөнгөнөөс илүү

гарсан мөнгө бол нэг хэсэгтээ явмаар санагдаад байгаа юм. Тийм ээ. Үүнийг тэгээд судлах л ёстой. Судлаад үнэхээр тийм байдаг бол энэ бол нэг мөнгө байгаад байна. Би 1 минутаа үргэлжлүүлээд авъя.

Тэгээд явж явж энэ чинь орон байран дээр ирж байгаа юм.

**П.Ганзориг:** Нэмэлт минут өгье. Д.Рэгдэл гишүүн.

**Д.Рэгдэл:** Асуудал хаашаа яаж эргэх вэ гэдэг юмыг хүртэл ярилаа. Багш нарын ялихгүй нэмэлт орлого өгч, хичээл хийсээр байгаад.

Тэгэхээр зэрэг байрны асуудлыг нэлээн тод зааж өгөхгүй бол орон нутагт байгаа, суманд байгаа тэр төрийн өмчит компаниуд ч юм уу, эсвэл төрийн байгууллагуудад тийм сургалт явуулаад байх илүүдэл байр ерөөсөө байдаггүй шүү дээ. Яваад л үзэж байхад.

Тийм учраас үүнийг сургууль руу татаж авчрах суурь нөхцөлийг сайжруулах боломж юу байна вэ? Үүнийгээ Та бүхэн маань бас нэг нэг үзэж харвал их зүгээр байна.

Тэгээд гол асуудал бол энэ хүүхдийн хөгжлийн төв дээрээ цуглаж явах юм байна. Тэгэхээр зэрэг энэ төв маань тусгайлсан мэргэшсэн хүний нөөцтэй байна гээд байгаа юм. Энэ ер нь та нарын бодож байгаагаар дахиад хэчнээн хүний орон тоо энэ рүү нэмэгдэхээр байна вэ? Ийм хоёр ч юм уу даа. Асуулт байна.

**П.Ганзориг:** М.Бадамсүрэн гишүүн хариулъя. Л.Мөнхбаясгалан гишүүн хариулъя. Л.Мөнхбаясгалан гишүүний микрофоныг нээе.

**Л.Мөнхбаясгалан:** Энд Унгар Улсын хэрэгжүүлсэн жишээгээр тухайн дүүрэгтээ, тухайн жижиг хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниуд, төр, хувийн хэвшил хамтран оролцсон.

Энэ дээр яасан бэ гэхээр спортын талбай байгуулж өгсөн юм уу, хүүхэд хөгжлийн төв байгуулж өгсөн компаниудыг татварын хөнгөлөлт үзүүлж эхэлсэн. Тэгэнгүүт энэ заавал сургууль дээр нэг заал байх ёстой юм шиг. Тийм ээ. Сургуулийн гадаа биеийн тамирын талбай байх юм шиг бодохгүйгээр ингэж хийж болохоор байсан.

Тухайн жилдээ тэр компани бид өнөөдөр энд шатрын клуб байгуулж өгье.

Татвар нь хэдэн хувиар чөлөөлөгдөнө. Спортын заал барьж өгье. Ингэж чөлөөлөгдөнө гэдгээр явсан нь маш зөв болсон.

Австрали Улс тэгсэн. Австралид бүр одоо ингээд спортын эрхийн бичгийн хөтөлбөр гэж байдаг. Тэрийг нь аж ахуйн нэгжүүд нь дандаа санхүүжүүлээд явдаг.

Буцаад төрөөс авахдаа татварын хөнгөлөлтөө л авдаг. Иймэрхүү маягаар бас шийдэж болдог.

Одоогийн байдлаар яах вэ 21 аймагт ямар ямар сургууль дээр юу юу байгуулж болох вэ гэдгийг бүр 21 аймгаар нь гаргаад, тухайн туршилтын хөтөлбөр байгуулах боломжийг нь энд судалсан байна л даа.

Одоо жишээ нь Архангай аймаг дээр элит 1 дүгээр сургууль дээр байж болж байна. Эрдэнэт хот дээр лаборатори 8 дугаар сургууль, эсвэл 3 дугаар сургууль дээр ч юм уу гэх маягаар ингээд анхдагч хуулийн төсөл болохоор судалгаа нь маш сайтай. Энэ нь явцын дундаа бас дараагийн ажлын хэсэгт бид хүлээлгэж өгөхөд сайтар хянаад усыг нь шавхаад явах байх гэж бодож байгаа.

Ер нь 2019 оноос Монгол Улсын 5 дахь Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулгын удирдлага доор бид энэ судалгааг маш сайтар хийсэн. Маш сайн хийсэн. Жил болгон шинэчилж байсан.

Тэгээд хоёр намаас М.Бадамсүрэн гишүүнтэй хамтраад хуулиа нэгтгээд нэг болгоод явж байгаа нь энэ юм.

**П.Ганзориг:** Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууя.

**Г.Хосбаяр:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Нэгдүгээрт нь, Ирээдүйн өв сангийн маань мөнгийг Монголбанкныхан Их Хурлын гишүүдэд мэдээлэл өгөхдөө Лондонд банканд байгаа. Тодорхой хэсэг нь алтны нөөцөөр байгаа. Энэ бол Монгол Улсын гадаад валютын нөөцөд тооцогддог гээд нэлээн л тийм серозный юм ярьж байсан.

Үүнийг нэг М.Бадамсүрэн гишүүн нягтлаарай.

Тэгээд яг тэр хүү нь бодогдоод, тэр хүүг нь тэгж үнэхээр жил болгон аваад ашиглаад байж болох юм уу? Ер нь тэгээд энэ чинь 2030 он хүртэл хэрэглэж болохгүй түгжсэн ийм мөнгө, бас нэг ирээдүйнхээ эрсдэлийг хаасан, бас нэг хүмүүст итгэл найдвар төрүүлсэн, баялгийн хувь хишгийг хадгалж болдог бас нэг сан үүсгэсэн л зүйл л дээ.

Тэгээд энэ рүүгээ сүүлийн үед нөгөө орон сууцын ипотекийг ч тийш нь шилжүүлэх бололтой юм яриад л, зарим хэсэг нь гаднаас өндөр хүүтэй зээл авчхаад өөрсдийнхөө байгаа мөнгөө хүү багатай хадгалуулж байна гээд л олон асуудлыг ярьдаг.

Тэгэхээр энэ дээр маш сайн нягталж үнэн зөв мэдээллийг авч ашиглах нь зөв байх гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, хөдөө сумын төвд байгаа хүүхдүүдэд ер нь хэр хүртээмжтэй байлгах вэ? Энэ тал дээр ер нь анхаарч ажилласан уу? Одоо хөдөө суманд байгаа хүүхдүүд чинь. Аймгийн төвийн хүүхдүүд өөр л дөө. Дорнод аймаг жишээлбэл аймгийн төв дээрээ ихэнх хүн амынх нь бараг 70 хувь нь ч билүү байгаа учраас илүү үр дүнтэй байна байх гэж ойлгож байна. Жишээлбэл, манай Өвөрхангай аймаг шиг хүн ам нь тархан суурьшдаг 19 суманд амьдарч байгаа сумын хүүхдүүд яг энэ ваучерыг ашиглаад суман дээрээ үр дүнтэй байхад ер нь яаж нөлөө үзүүлэх вэ? Одоо бас Боловсролын сайд, боловсролын сүүлийн үеийнхний яриад байгаагаар чинь сумдуудыг бүсийн төв болгоод бүсчилсэн хөгжлийнхөө хүрээнд бас зарим сумдын сургуулийг бага сургууль болгох, зарим сумыг бүсийн төв болгох. Энэ чинь 12 жилтэй нь үлдээх гээд олон асуудал яригдаж байгаа.

Тэгэхээр энэ болгонтой уялдаж боловсруулсан уу? Дамаа яг энэ хуулийн төслийг бичсэн хүмүүсээс асууя.

Тэгээд яг хөдөө сумын хүүхдүүдэд үр дүнтэй байх, илүү боломжтой байх тал дээр анхаарахгүй бол зөвхөн аймгийн төвийн хүүхдүүд, хотын хүүхдүүд, төвлөрсөн газрын төв суурины хүүхдүүдэд давуу байдал олгох вий. Одоо хууль санаачлагчийн яриад байгаа байгалийн баялаг бол тэгш хүртээмжтэй, ард иргэд бүгд хүртэх ёстой гэдэгтэй адилхан хэрвээ яг хамрагдах гэж байгаа бол хүүхдүүд бүгдээрээ л хамрагдах ёстой болохоос биш хөдөө сумдын хүүхдүүд хаягдаад, аймгийн төвийн хүүхдүүд, хотын хүүхдүүд илүү давуу байдалтай байж болохгүй шүү гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд мөн энэ хууль хэрэгжсэнээр улсын төсөвт баахан урсгал зардал, халаалтын зардал, барилга байшин, тог цахилгаан, харуул хамгаалалт... /минут дуусав/

**П.Ганзориг:** М.Бадамсүрэн гишүүн хариулах уу. М.Бадамсүрэн гишүүний микрофоныг өгье.

**М.Бадамсүрэн:** Г.Хосбаяр гишүүний асууж байгаа эрсдэлтэй зүйлийн талаар тодорхой хариулт өгье.

Нэгдүгээрт, Үндэсний баялгийн сан 3 сантай.

- Нэг нь, Ирээдүйн өв сан.
- Хоёр дахь нь, Хуримтлалын сан.
- Гуравдугаарт нь, Хөгжлийн сан.

Хөгжлийн санд төсөв ашигтай гарсан тохиолдолд мөнгө хуримтлагдана. Энд нэг ч төгрөг байхгүй.

Хоёрт нь, хуримтлалын санд одоо үеийн иргэдийнхээ эрүүл мэнд, боловсролд дэмжлэг үзүүлнэ гэж заасны дагуу жилдээ 450 орчим тэрбум төгрөг төрийн өмчит компаниудын Засгийн газарт ногдох ногдол ашгаас нь орж байгаа юм. 34 хувь. Түүнээс дээш ногдол ашиг нь.

Энэ нь жилдээ 400 гаруй тэрбум төгрөгийг бүтнээр нь Монголбанкаар дамжуулаад арилжааны банкнуудад шилжүүлж ипотекийн орон сууцын зээлийн эх үүсвэр болгож эргэлтэд оруулж байгаа гэсэн үг. Ийм зарчмаар явдаг юм билээ.

Гурав дахь сан нь Ирээдүйн өв сан. Энэ сангийн мөнгийг Монголбанк удирдаж, Монголбанк гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас бондыг худалдаж авч жилийн хугацаатай. Тэгэхдээ улирал улирлаар бонд худалдаж авдаг юм билээ. Одоогийн байгаа зарчим нь.

Тэгэхээр тэр мөнгө нь үндсэндээ бонд хэлбэртэй байгаа гэсэн үг.

Тэгээд хугацааны дараа буцаагаад мөнгөө татаж авдаг. Тэгээд буцаагаад байршуулдаг. Яг энэ зарчмаар явж байгаа. Энэ бол бодитой мэдээлэл гэдгийг танд хэлье.

Сумын төвд хамгийн сайн хэрэгжих төсөл гэж үүнийг үзэж байгаа.

Яагаад гэхээр сумын төвийн хүүхдүүд нэг ангид байх хүүхдийн тоо цөөн учраас соёлын төвийн багш нар маань харьцангуй чөлөөт цаг боломжтой учраас хүүхэд нэг бүртэй тулж ажиллаж сумдын хүүхдүүд маш өндөр хувиар хамрагдаж байгаа үзүүлэлт гарсан байгаа.

Аймгийн төв, сумын төв, нийслэл Улаанбаатар хотын хүүхдийн хөгжлийн ялгааг арилгахад энэ хуулийн нэг гол зорилго оршиж байгаа юм.

Өөрөөр хэлбэл таны хэлдгээр аймгийн төв, нийслэлд секц дугуйлан олноор байдаг. Сонголт ихтэй байдаг. Сумын төвд ерөөсөө байдаггүй. Одоо манай төсөл хэрэгжиж байгаа Дорнод аймагт гэхэд сумдад хамгийн багадаа 10 орчим секц дугуйлан байгаа.

Тэгэхдээ энэ дөрвөн чиглэлээр хэрэгжиж байгаа.

- ▷ Нэгдүгээрт нь, **хувь хүний хөгжил.**
- ▷ Хоёрдугаарт нь, **гадаад хэл.**
- ▷ Гуравт нь, **спорт.**
- ▷ Дөрөвдүгээрт нь, **авьяас, ур чадвараа хөгжүүлэх** гээд.

Тэгээд соёлын төвүүдэд –

— Соёлын төвийн багш нар бүжгийн дугуйлан хичээллүүлж байна.

- Сумын биеийн тамирын багш нар хичээллүүлж байна.
- Гадаад хэлний багш нар хичээллүүлж байна.

Тэгээд багш нар нэмэлт орлоготой болж байгаа давуу тал үүсэж байгаа.

Өөрөөр хэлбэл заавал Бүгд Найрамдах Солонгос Улс явж байрны урьдчилгаа хийх биш. Тэр бүү хэл зарим биеийн тамирын багш нар өөрийнхөө өмчлөлийн газар хашаан дээрээ бөхийн заал хүртэл барьж байгаа юм.

Яагаад гэвэл орлого нь сардаа тодорхой учраас, нэмэлт орлоготой учраас.

Тэгээд одоо Та бүхэн мэдэж байгаа. Одоо нөгөө Ираны асуудлаас болоод нэг өдөр цахимаар болоод үндсэндээ 4 өдөр ажиллаад 3 өдөр амрах горим нийслэлийн хувьд шилжээд байгаа шүү дээ. Орон нутагт ч гэсэн.

Тэгэхээр амралтын хоёр өдөр болон ажлын нэг өдөр нь ингэж секц дугуйлангаа хичээллүүлэхэд багш нар бүрэн зав гаргаж байгаа. Түрүүн Д.Рэгдэл гишүүн асуусан.

Ер нь хүний нөөц өөрөө ингэж чадавхжиж явах болохоос биш бид нэг байшин барилга барьснаараа асуудал шийдэж байгаа гэж ойлгож ерөөсөө болохгүй юм билээ. Энэ бол багш өөрөө хөгжиж өөрөө ингэж байнгын нөгөө өрсөлдөж. Энэ чинь хувийн хэвшил гүйцэтгэнэ. Энэ дээр төр ерөөсөө өмнөх нийгмийн үеийнх шиг ерөнхий боловсролын сургуулийн багш нар хичээл дээрээ нэмж төсвөөс, одоо тэр сургуулийнхаа төсвөөс хөрөнгө аваад явахгүй. Багш нар нэгдэж нийлээд чөлөөт цагаараа буюу амралтын өдрүүдэд энэ секц дугуйлангаа хичээллүүлэх, ажлын өдөр цагтаа зохицуулалт хийгээд хичээллүүлэх энэ боломжийг бүрдүүлж өгч байгаагаараа онцлог гэсэн үг.

Өөрөөр хэлбэл зах зээлийн эдийн засгийн зарчимд нийцсэн хэлбэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр энэ хуулийн зарчимд тусгасан байгаа. Энэ бол манай өнөөгийн бидний сонгосон ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засгийн харилцаанд яг яс нийцсэн ийм хэлбэрээр явуулахыг бодож байгаа. Урсгал зардал огт нэмэгдэхгүй.

Яагаад гэвэл үүнийг хувийн хэвшил гүйцэтгэнэ. Өөрөө тэр төсөвтөө багтаагаад, төлбөртөө багтаагаад.

**П.Ганзориг:** Г.Хосбаяр гишүүн тодруулъя.

**Г.Хосбаяр:** Тодруулаад асуух ч үгүй. Зүгээр юм хэлэхэд. Яах вэ бид чинь улсын төсөв хэлэлцэхээр л урсгал зардлаа бууруулъя, төсөв тэлж байна гээд л олон асуудал ярьдаг.

Тэгээд нөгөө талд нь бид сайн чиглүүлж өгөхгүй бол. Жишээлбэл, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум гэхэд баг болгоныхоо хажууд заал барьсан. Заал барьсан. Тэгээд нөгөө халаалтын зардал, цэвэрлэгээ, үйлчилгээ, тог цахилгааны зардал бүгд төсөв дээр ирж байгаа юм.

Тэгэнгүүт саяхан Өвөрхангай аймагт очсон чинь яг саяын таны ярьдаг шиг бөхийн багш Өвөрхангайд заал хүрэлцэхгүй байна, заал барина гээд хандив цуглуулаад эхэлсэн. Мань мэтийг хүртлээ хандив өг гэж байгаа юм. Дахиад эцэг, эхчүүдээс хүүхдүүдээс хандив цуглуулаад эхэлсэн.

Тэгээд тэр хүн ойлгомжтой. Ингээд 1 тэрбум төгрөгөөр заалаа барьна.

Дараа нь халаалтын зардал, тогны мөнгө би авч явж чадахгүй. Үүнийгээ аймаг орон нутаг нь ав гээд л дахиад л төсөв дээр нэг дарамт ирэх байхгүй юу.

Тэгэхээр бид хууль баталсан чинь дахиад л үүнийг дагуулж гуядаад хүмүүс нэг заал бариад л, байшин... /минут дуусав/

**П.Ганзориг:** Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүд байна уу? Ц.Мөнхтуяа гишүүнээр тасаллаа. О.Саранчулуун гишүүнээр тасаллаа.

П.Наранбаяр гишүүн үг хэлье.

**П.Наранбаяр:** Хэдэн минут вэ? Би яах вэ товчхон хэлье.

Яагаад гэвэл энэ их хэрэгтэй хууль. Нийгэм хүлээж байгаа хууль. Энэ хуулийг санаачилж байгаа манай М.Бадамсүрэн гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүн, ажлын хэсгийнхэнд юуны түрүүнд баяр хүргэе.

Гэхдээ анхаарах зүйлүүд байгааг хэлэхээс өөр арга алга. Түрүүнд ярьсан. Тэр баялгийн сангийн 2030 он хүртэл цоожилсон явдал. Энэ цоожийг бид эвдэж чадах уу гэдэг асуудал. Энэ бол энэ хуулийн аягүй нарийн гол үндэс шүү. Нюанс нь шүү. Юу гэж хэлэх юм.

Хоёр дахь нь, Хүүхэд хөгжлийн төв бол зөвхөн нэг шинэ барилга бариад сум болгон соёлын төв барьсан гэдэг шиг сум болгонд янз янзын төв бариад. Түрүүнд Г.Хосбаяр гишүүн ярьж байна шүү дээ. Авч явах тэр урсгал зардлаа дийлэхээ больдог гээд.

Тэгэхээр үүнийг бид бодох ёстой. Энэ утгаараа хүүхэд хөгжлийн төв –

- одоо байгаа насан туршийн хөгжлийн төвүүд,
- одоо байгаа номын сангууд,

- одоо байгаа соёлын төвүүд,
- одоо байгаа сургуулиуд –

энэ болгон дээр түшиглэсэн байхуйцаар хийхгүй бол хуулийн механизмыг нарийн бодохгүй болохгүй.

Тэгээд эрхийн бичгийн асуудал. Урьд нь эрхийн бичгээр нь өгөөд өөрийгөө хөгжүүлэх боломжийг. Тэгээд хүүхэд, гэр бүл, эцэг, эхчүүд ярилцаж байгаа хамгийн сайн сургалтын төвүүд рүү янз янзын заал руу оч л доо. Тэгээд тэр ваучер гэдэг юм уу, нэг хэсэг нийгмийн юунд орсон эрхийн бичгээ өгөөд тэгээд хөнгөлөлтөө эдлээд үлдсэнийг нь өөрөө төлөөд ч юм уу ийм маягаар явах боломжийг нь бий болгох юм бол манай нийгмийг маш баялаг болгоно. Хэрэгтэй ийм харилцаа үүсгэж байна гэж үзэж байна.

Тэгээд ер нь хүүхэд хөгжих хөгжлийн асуудал бүх л шүү. Одоо ухаандаа сургууль дотор байхдаа Боловсролын яамны харьяанд, гараад шууд хүүхэд хөгжлийн төв гэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд ордог гэж. Энэ харилцааг ингэж айхтар хатуу зааглах аюултай.

Тэгэхээр хүүхэд бол нэг л байгаа. Гэр бүл нэг л байгаа. Энэ утгаараа энэ харилцааг энэ хоёр боловсрол хариуцсан, гэр бүлийн асуудал хариуцсан, хүүхдийн хөгжил хариуцсан гээд байгууллагууд нь уялдаж ажиллах шаардлагатай гэж харж байна.

Манай хууль бичилтийг Та бүхэн анзаарсан гол механизмаа хийхгүй. Ингээд тэрний эрх үүрэг, үүний эрх үүрэг гээд. Тэгээд сүүлдээ бүр хүүхдийн эрх үүрэг энэ тэрээ гээд баахан эрх үүргүүдийг нийлүүлээд л 80 хувь нь. Хууль нь ерөөсөө л тийм болдог.

Тэгэхээр энэ зүйл дээрээ бид нэг жоохон шинэлэг харъя. Яагаад гэвэл Европын улс орнуудын маш олон жишээг харсан байна шүү дээ. Маш сайн судалгаа хийсэн байна. Сая харсан.

Тэгэхээр энэ дээр Ж.Галбадрах гишүүн ч гэсэн яриад байгаа. Нэг ээлжтэй сургуулийг анхаарах хэрэгтэй шүү гээд. Нэг ээлжтэй сургууль шууд л энэ хөгжлийн төв болох боломжтой. Хоёр ээлжтэй бол хүндрээд эхэлнэ.

Яагаад гэвэл боломж нь, цагийн хувьд их хязгаарлагдмал болоод эхэлдэг.

Тэгээд энэ нь –

- гэр бүлд хэрэгтэй,
  - хүүхдэд хэрэгтэй,
  - багш нарт хэрэгтэй,
  - төрийн бус байгууллагуудад хэрэгтэй.
-

Мөн хүүхдийн хөгжил бүхий л талаар анхаарч байгаа хүмүүст хэрэгтэй хууль болгохын тулд хэдүүлээ ур ухаанаа уралдуулж ярьцгаая. Хэдүүлээ энэ энэ хуулиа яг идэвхтэй дэмжицгээе гэж ингэж хэлмээр байна.

Тэгээд Та бүхэнд баярлалаа.

**П.Ганзориг:** Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

**О.Саранчулуун:** Бид хүүхдийн мөнгө өгч байгаа 100 мянган төгрөгөө улсын халамжийн сангийнхаа зарлалд нийлүүлээд хэдэн их наяд гэж тооцсоноо манай улс хүүхдэд анхаардаг гэж олон жил ярьж ирсэн.

Тэгээд хүүхдийн төлөө байгууллагатай, хүүхдийн төлөө зөндөө олон газартай мөртлөө хүүхдүүд нь өвдсөөр байдаг, гэмтсээр байдаг, хүүхдүүд нь хөгжил нь ялгаатай байгаад байдаг. Ийм байгаа.

Тэгэхээр нөхцөл байдалд. Ялангуяа хөгжлөөс хоцрогдож байгаа хүүхдүүдээ бид анхаарах хэрэгтэй байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд тэр хүүхэд тэгж төрсөн нь тэр хүүхдийн буруу биш шүү дээ. Тэр ээжийн ч буруу биш.

Ер нь эрүүл мэндийн байгууллагын алдаанаас болж олон хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй төрж байгаа. Эх барихын алдаанаас болж байна. Агаарын бохирдлоос болж хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа судалгаанууд дээр зөндөө юм байгаа.

Тэгэхээр энэ хүүхдүүд өнөөдөр хоёр хүн тутмын нэг нь боловсролгүй хөгжлийн бэрхшээлтэй хүн болж байгаа шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс харахаар хоёр хүн тутмын нэг нь дээд сургуульд сурах, мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдах ямар ч боломж байхгүй.

Тэгэхээр энэ хуулийн хүүхдийг хөгжүүлбэ гэдэг үзэл баримтлалын хүрээнд маш их дэмжиж байгаа. Гэхдээ илүү сайжруулах хэрэгтэй. Би П.Наранбаяр гишүүнтэй санал нэг байна. Дотоод зохион байгуулалтыг нь яаж хийх вэ гэдэг дээр бид анхаарах хэрэгтэй байгаа.

Өнөөдөр хүүхдүүд жоохон ялгаатай суралцахуйн бэрхшээлтэй хүүхдээ аваад дурын сургуульдаа, гэрийнхээ харьяаллын сургуульдаа очоод хүүхдээ өгье гэхээр сургууль авдаггүй шүү дээ. Манайд орчин байхгүй гэж хэлдэг. Эсвэл багш байхгүй, арга зүй байхгүй. Хүүхдүүд авдаггүй байхгүй юу.

Тэгээд ээж, аав нар хүүхдүүдээ тэврээд хаачих вэ. Нөгөө хэдэн дэмжих төвүүд дээрээ л очдог. Яг түрүүний хэлсэнчлэн дэмжих төвүүд нь өөрсдөө бас л

гэр бүлийн яам, боловсролын яам нарын дунд нь байгаад байдаг байхгүй юу. Нэгдсэн бодлого хүлээгдэж байгаа.

Би саяхан гурван яам хамтарсан уулзалт хэлэлцүүлэг хийлээ гэж сонссон. Эрүүл мэнд, Боловсрол, Гэр бүлийн яам. Энэ гурав нийлээд ямар бодлогын ахиц гаргаж байгаа вэ? Энэ дээр ямар анхааралд анхаарахаар асуудлуудыг шийдсэн юм бэ? Энэ дээр мэдээлэл хэрэгтэй байгаа.

Ер нь бид хүүхдүүд гэхдээ бизнес талаас нь зах зээл рүү нь оруулж дэмжье гэдэг санаа зөв боловч нөгөө талдаа энэ чинь нийгмийн хариуцлага учраас тодорхой тэр багш нар, тэр сургалтын төвүүд, тэд нар өөрсдөө хүртээмжийн шаардлагыг хангах ёстой. Заавал оруулах ёстой. Тэгж байж бид бүх хүүхдүүдээ ижил тэгш сургах боломжтой болох байхгүй юу. Өнөөдөр өндөр боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс аягүй цөөхөн байгаа шүү дээ. Монголд.

5 дугаар ангиас эхлээд ангиуд нь дандаа дээд давхарт байрладаг байхгүй юу. Бага ангиа нэг давхар гээд. Сургуулиудын барилга тийм шүү дээ. Тэгэхээр чинь хүүхдүүд дээд анги руу орох боломжгүй болж байгаа. Хүнээр өргүүлж явахаас ичнэ. Дэргэдээ заавал нэг хүн авч явахаас ичнэ.

Ингээд хүүхдүүд бага боловсрол цэцэрлэгийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа дүн нь өндөр гараад дээшлэх тусмаа тоо нь буурдаг байхгүй юу. Дээшээгээ сурах бололцоо байхгүй. Тэгээд сургуулиуд хүүхдүүдийг авахгүй. Энэ чинь аймаар ялгаварлан гадуурхалт байхгүй юу. Үнэхээр аймаар ялгаварлан гадуурхалт.

Тэгэхээр энэ орон зайг нөхөөд одоо байгаа нөөц бололцоог хооронд нь уялдуулсан ийм агуулгатай болох талаас нь би энэ хуулийг дэмжиж байна. Зохицуулалт талаас нь ийм байвал үнэхээр дэмжиж ажиллахад таатай байна.

**П.Ганзориг:** Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн үг хэлье.

**Ц.Мөнхтуяа:** М.Бадамсүрэн гишүүн нарын 21 гишүүн өргөн мэдүүлж байгаа Хүүхэд хамгаалал, хүүхэд хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг дэмжиж байна.

М.Бадамсүрэн гишүүн маань Дорнод аймгийн Засаг дарга байхдаа “Хүн болох багаасаа” гэж энэ маш чухал хэрэгтэй төслийг санаачилж, өөрөө бүр энэ энэ дээр маш онцгой анхаарч. Тийм ээ. Багш нарыг хүртэл энэ төслөөрөө дамжуулан хөгжүүлж, багш нарт ажиллах урам зоригийг сэргээж өгсөн танд талархал илэрхийлмээр байна.

Дорнод аймгийн багш нар яг энэ “Хүн болох багаасаа” төсөл дээр бүгдээрээ маш сэтгэл хангалуун байгааг би тэр багш нартай уулзахдаа харж байсан, сонсож байсан.

Тийм учраас Дорнод аймгийн хэмжээнд туршсан, үр дүнгээ үзсэн энэ хуулийн төслийг Монголын бүх эцэг, эхчүүд, хүүхдүүд бүгд дэмжих нь тодорхой.

Ер нь 6 сарын 01 болохоор бид гэнэт хүүхдүүддээ хайртай болоод, хайр зарлаад гэнэт хүүхдүүдэд сайн дүр эсгэцгээдэг.

Тэгэхээр хүүхдэд яг хэрэгтэй, хүүхдэд үр дүн гаргах энэ сайхан хуулийн төслийг санаачилж орж ирж байгаад энэ 21 гишүүндээ үнэхээр их баярлаж байна.

Тэгээд энэ хуулийн төсөл мэдээж анхдагч хуулийн төсөл учраас алдаа оноотой юмнууд байгаа байх. Төгс төгөлдөр гэж хэлээгүй. Гэхдээ ажлын хэсгээрээ энэ хуулийн төслөө чамбайруулаад, сайжруулаад Улсын Их Хурлын гишүүд бүгдээрээ хүүхдийн төлөө нэг удаа ч гэсэн бүгдээрээ “За” гэж хэлээрэй гэж уриалмаар байна.

Тэгээд М.Бадамсүрэн гишүүндээ баярлалаа.

**П.Ганзориг:** Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо хуулийн төсөл болон хамт өргөн дүүлсэн хуулийн төсөл тус бүрээр санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Санал хураалтдаа ороогүй, бэлтгээгүй гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад нийт 26 гишүүн орсноос 17 гишүүн дэмжиж, 65.4 хувиар дэмжигдлээ.

Дагалдсан хуулийн санал хураалт явагдана шүү. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад нийт 26 гишүүн орсноос 17 гишүүн дэмжиж, 65.4 хувиар санал дэмжигдлээ.

Д.Бум-Очир гишүүнийг дэмжсэнээр тооцъё.

Тэгээд санаачилсан гишүүд болох С.Зулпхар, С.Эрдэнэбат, Д.Ганмаа гишүүн нарыг дэмжсэнээр оруулах юм байна шүү.

Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бүрээр санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганы хуралдаанд Ганбатын Хосбаяр гишүүн танилцуулна.

Ингээд өнөөдөр Байнгын хороогоор маш чухал хуулийн төсөл, асуудлууд хэлэлцэж дууслаа.

Тэгээд өнөөдөр Байнгын хорооны хорооны нийт 30 гишүүнээс 26 гишүүн оролцож, 86.7 хувийн өндөр ирцтэй хуралдсан нийт Байнгын хорооны гишүүддээ талархал илэрхийлье. Ингээд хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 3 цаг 58 минут үргэлжилж, 14 цаг 24 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**ЦАЛТАН-ОД**